



ББ- ДУ- 1-04-06

ЧАНАР, ХЭМАБ-ЫН ГАРЫН АВЛАГА

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 1/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Боловсруулсан:	Хянан шинэчилсэн:	Баталсан:
Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа	Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа	ЦССҮТ-ийн Ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр
Огноо: 2017.04.20	Огноо: 2018.04.02-05.16 2019.02.20- 03.06. 2019.04.8-04.27. 2020,02,4-2020.10.01 2021.04.12-08.11	Огноо: 2018.05.20. 2019.03.10. 2019.04.27. 2020.10.10. 2021.08.18.
Гарын үсэг: 	Гарын үсэг: 	Гарын үсэг:  

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 2/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Өөрчлөлт оруулсан бүртгэл

Д/д	Хуудасны дугаар	Зүйл ийн дугаар	Өөрчилсөн огноо	Оруулсан өөрчлөлт	Шалтгаан	Чанарын албаны даргын гарын үсэг
1	7	1,1	2020,02,04	Хамрах хүрээнд ХЭМАБ ыг нэмж оруулав	9001,45001 стандартын шаардлагыг нэгтгэх	
1	8	1.6	2018 оны 05 сар 05	Төвийн Магадлан итгэмжлэлийн дугаар хугацааг засаж оруулав	Магадлан итгэмжлэлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа сунгагдсан	
2	10	1.7	2018 оны 05 сар 05	Төвийн 2017 онцлох үйл явдал	Төвийн хамт олны 2017 оны 10 гол ололт амжилтыг нэмж оруулав	
3	11	4	2018 оны 05 сар	ЭМ-ийн сайдын 2018 онд гарсан тушаалууд	Төвийн үйл ажиллагаанд мөрдөх хоблогдох тушаалуудыг шинэчилсэн.	
4	27	4.6	2018 оны 05 сар	ҮЯТ –ууд шиэнчлэгдэн дугаар өөрчлөлт орсон шинээр нэмэгдсэн	Үйл явцын тодорхойлолт нэмэлт шинэчлэл хийсэн	
5	37	4,4,1	2018 оны 05 сар	Төвийн бүтэц үйл ажил лагааны стандарт шинэчлэгдсэн.	Төвийн үйл ажиллагааг, нарийн тодорхойлсон	
6	41	5.1.2	2019 оны 2 сар	Гадаад дотоод үйлчүүлэгчээс тогтмол санал хүсэлт авч үйл ажиллагаагаа сайжруулах	Үйлчүүлэгчийн санал хүсэлтийг алба тасгууд чиглэл, чиглэлээр авч хэвших	
7	5	1	2019 оны 2 сар	Хамрах хүрээнд 2 суурин төв, цус	ОУ-ын баталгаажуул	

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 3/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

				цуглуулах хэсгийг нэмж оруулав.	алтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
8	6	1.1	2019 оны 2 сар	Төвийн тусгай зөвшөөрлийн хугацааг засч шинэчлэв.	Төвийн тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан.	
9	11	1.7	2019 оны 2 сар	2018 оны онцлох үйл ажиллагааг нэмж оруулав	2018 оны жилийн тайлан нэгтгэгдэн гарсан тул	
10	31	4.4.1	2019 оны 3 сар	Боломж дээр нэмэлт шинэчлэл хийв	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
11	32	4.4.1	2019 оны 3 сар	Эрсдэл дээр нэмэлт шинэчлэл хийв	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
12	38	6.1.1	2019 оны 3 сар	Төвийн гадаад эрсдэл, сэргийлэх арга замыг нэмж оруулав	Төвийн нөхцөл байдлын үнэлгээний дүн шинэчлэгдсэн	
13	41	6.2.1	2019 оны 3 сар	Төвийн чанарын зорилтыг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн тоо мэдээллийг ямар давтамжаар, хаанаас хэрхэн цуглуулж, үнэн зөвийг нотлох үүргийг тодруулж нэмэв.	ОУ-ын баталгаажуул алтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
14	46	7.1.2	2019 оны 3 сар	Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, мэдлэг ур чадвар олгох, хадгалах,	ОУ-ын баталгаажуул алтын байгууллагын аудиторын	

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.04.12- .2021.06.11.	Хуудас 4/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

				өвлүүлэх чиглэлийг нэмж тусгалаа.	зөвлөмжийн дагуу	
15	50	7.1.4	2019 оны 4 сар	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх орчинд холобгох стандарт, журмуудыг иш татан орууллаа.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
16	53	7.1.6	2019 оны 4 сар	Төвийн мэдлэгийг хадгалах, хөгжүүлэх ХН-ийн залгамж холбоо хөгжүүлэх нэмэлт оруулав.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
17	59	7.5.3.2	2019 оны 4 сар	Баримт бичиг цахимд байршуулж, ашиглах талаар нэмэлт орууллаа.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
18	70-71	8.5.3	2019 оны 4 сар	Цусны донорын эрүүл мэндийг хянах нотолгоо гаргах, баримтжуулах үйл ажиллагааг нэмж тусгалаа.	ОУ-ын баталгаажуул алтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	
19	72	8.5.5	2019 оны 4 сар	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн дараа хийх яхналт, эмнэлгийн байгуулагуудад өгөх зөвлөмж, мөрдөх журмыг нэмж оруулав.	ОУ-ын аудиторын зөвлөмж	
20	72	8.5.6	2019 оны 4 сар	Төвийн үйл явц, ажиллагаанд өөрчлөлт, хяналт хийх зөвшөөрөл олгох нотолгоог нэмж тодруулга орууллаа.	ОУ-ын баталгаажуул алтын байгууллагын аудиторын зөвлөмжийн дагуу	

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.04.12- .2021.06.11.	Хуудас 5/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

21	73	8.6.в	2019 оны 4 сар	ЦЦБ олгох зөвшөөрлийг ТТ эрхлэгч, эмч нар олгох нэмэлт хийв	ОУ-ын аудиторын зөвлөмж	
22	8	1	2020,04 сар	ХЭМАБ-ын хүрээг нэмэв	2 тогтолцооны стандартыг нэгтгэх	
23	9	1,2	2020.09. 23	ЦССҮТ тодорхойлолт өөрчлөлт оров	ЭМ-ийн сайдын 2020 оны А/445 тушаал	
24	11	1,3	2020,10, 01	Алсын хараа, Эрхэм зорилго жтжтг өөрчлөлт	А/445 тушаал	
25	19	4,3	2020,10, 01	ХЭМАБ-ын тогтолцоог нэмж өргөтгөв	45001:2018 стандарт	
26	27-28	4.4	202010,0 1	Дэмжих албаны үйл ажиллагаанд өөрчлөлт оров	А/445 тушаал	
27	37	1,8	2020.10. 01	Хүний халдварт өвчин, цар тахал	Үүссэн нөхцөл байдал	
28	39	5,1	2020,10, 01	ХЭМАБ-ын тогтолцоо	45001:2018 стандарт	
29	40	5,2	2020,10, 01	ХЭМАБ-ын бодлого	45001:2018 стандарт	
30	44	6,2	2020.10. 01	ХЭМАБ-ын зорилт	45001:2018 стандарт	
31	61		2020.10. 01	ЦА-ны үйл ажиллагаанд мөрдөх тушаал өөрчлөлт	Эм-ийн сайдын 2020 оны 373 дугаар тушаал	
32	46-47	5.4	2021,05, 19	Ажилчдын оролцоо, зөвлөлдөөн хэсгийн нэмж оруулав.	45001:2018 стандартын шаардлага	

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 6/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Агуулга

Бүлэг	Хуудасны дугаар
Өөрчлөлт оруулсан бүртгэл	3
Агуулга	7
1. Хамрах хүрээ	8
2. Норматив иш таталт	14
3. Нэр томъёо ба тодорхойлолт	15
4. Байгууллагын төлөв байдал	15
4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох	15
4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох	18
4.3 Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох	19
4.4 Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц / ажиллагаа	20
Шаардагдах нөөц:	32
Боломж	33
Мэдээлэл хөтөлж, хадгалах.	36
5. Манлайлал	37
5.1 Манлайлал ба амлалт	37
5.2 Бодлого	39
5.3 Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл	40
6. Төлөвлөлт	41
6.1 Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ	41
6.2 Чанарын зорилтууд ба төлөвлөлт	43
6.3 Өөрчлөлтийг төлөвлөх	48
7. Тулгуур хүчин зүйл (Дэмжих үйл явц)	48
7.1 Нөөц	48
7.2 Ур чадвар – Чадамж	56
7.3 Мэдлэг олголт	57
7.4 Холбоо, харилцаа	57
7.5 Баримтжуулсан мэдээлэл	58
8. Ажиллагаа	61
8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт	61
8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага	63
8.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт хийх	65
8.4 Гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт	68
8.5 Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх	70
8.6 Бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргаж, бэлтгэх	74
8.7 Үл тохирол бүхий гаралтын хяналт	75
9. Гүйцэтгэлийн үнэлгээ	76
9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ	76
9.2 Дотоод аудит	78
9.3 Удирдлагын дүн шинжилгээ	79
10. Сайжруулалт	80
10.1 Ерөнхий зүйл	80
10.2 Үл тохирол ба залруулах арга хэмжээ	81
10.3 Байнгын сайжруулалт	82

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 7/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

1. Хамрах хүрээ

Энэхүү Чанарын гарын авлага нь:

а) Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь цусны донорууд, цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ) хэрэглэгч эмнэлгүүдийн эмч, мэргэжилтэн, эмчлүүлэгчдэд цусны донорыг элсүүлэх, сонгох, бүртгэх, цус, сийвэн, эс цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, эмнэлгийн захиалгын дагуу нийлүүлэх тусламж, үйлчилгээг тогтвортойгоор аюулгүй, чанартай үзүүлэх, эмч, мэргэжилтэн, ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чадвартайг харуулах, мөн,

б) Хэрэглэгчийн болон холбогдох хуулийн болон зохицуулалтын шаардлагад тохирох байдлыг хангах, сайжруулах үйл явц бүхий тогтолцоог үр нөлөөтэй хэрэглэх замаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, аюулгүй байдлыг хангах зорилготой төвийн чанарын менежментийн болон ХЭМАБ-ын тогтолцоонд тавих шаардлагыг тогтоолоо.

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв (ЦССҮТ) нь бүхий л үйл ажиллагаандаа цусны аюулгүй болон хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын стандартын байгууллага, ДЭМБ-аас тавьж байгаа стратеги зорилт, Монгол улсын хууль, стандарт, Эрүүл мэндийн болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын, Сангийн сайдын тушаалаар баталсан холбогдох журам, зааврын шаардлагад нийцүүлэн төвийн үндсэн болон дэмжих үйл явцыг хамруулан, үйл ажиллагаагаа байнга сайжруулах хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх чанарын менежментийн тогтолцоог хадгалж, цусны донорууд, төвийн эмч, ажиллагсдын хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангахад хэрэгжүүлнэ.

1.1 ЦССҮТ-ийн ерөнхий мэдээлэл:

Эрүүл Мэндийн Яамны харъяа Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв (ЦССҮТ) нь нийслэл Улаанбаатар хотод байрлан Баянзүрх дүүрэг. Сүхбаатар дүүрэг, Дүнжингарав Цус цуглуулах төв гэсэн 3 суурин болон явуулын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1. ЦССҮТ-ийн төв байр

Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-49,

Утас: 70112857 Факс: 11-70112857,

Майл хаяг: nctmmgl@gmail.com

Шуудангийн хаяг:

13395 ш/х -96 Улаанбаатар-49

Энд төвийн удирдлага, үндсэн болон дэмжих бүх алба, тасаг үйл ажиллагаагаа явуулж, эмнэлгүүдэд 24 цагаар цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ) олгодог.

2. Сүхбаатар цус цуглуулах төв

Сүхбаатар дүүрэг, энхтайвны өргөн чөлөө -13

Утас: 326504

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 8/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Энэ төвд цус цуглуулах, цусны бүлэг тодорхойлох үйл ажиллагаа ажлын 5 өдрүүдэд явагддаг. Мөн гамшиг, онцгой байдлын үед шинжилгээ хийх, ЦЦБ үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах, шаардлагатай хэрэгслийн нөөц агуулах, ОБЕГ-ын Хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөөцийг тус тус байрлуулж, гамшгийн үеийн нөөц төв байрладаг болно.

3. Дүнжингарав Цус цуглуулах төв
Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Дүнжингарав худалдааны төвийн G –хэсэг
Энэ төвд ажлын өдрүүдэд суурин хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаа явагдана.
4. Цус цуглуулах хөдөлгөөнт хэсэ /Явуул/
Төрийн болон төрийн бус байгууллагатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хувиарийн дагуу ажлын байран дээр очиж явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

ЦССҮТ нь **9070001138** дугаар бүхий Монгол усан бүртгэлийн гэрчилгээтэй.

Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ)-ээр Клиник болон Нэгдсэн эмнэлгүүдийг хангах улсын хэмжээнд цусны албаны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлнэ.

Хавсралт 1. ЦССҮ-02/23/3022-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ

ЦССҮТ нь цус, сийвэн цуглуулах, шинжлэх, ЦЦБ үйлдвэрлэх, иммуногематлогийн лавлах лаборатори, ЦЦБ эмнэлэгт олгох **ЭҮ -02/23/3022** дугаар бүхий эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, 2024 оны 01 сарын 10 хүртэл хүчинтэй хугацаатай

РД 9128905

Хавсралт 2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

ЦССҮТ- нь:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь үндэсний хэмжээнд цусны донор элсүүлэлт, цус авах, цус, цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, чанар, аюулгүй байдал, цусны сонор сэрэмжийн тогтолцоо, цус сэлбэлтийн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, стандарт заавар, арга зүйн зөвлөмж боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургах, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага /тусгай мэргэжлийн төв/ юм.

ЦСТ- нь: Харъяалах нутаг дэвсгэртээ цусны донорын сургалт, сурталчилгаа, донор элсүүлэлт, хадгалалтыг удирдан зохион байгуулах, цус авах, цусан бүтээгдэхүүн бэлтгэх, нийлүүлэх болон цусны аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий аймаг, дүүрэг, сумын Нэгдсэн эмнэлэг, ЭМ-ийн төвийн бүтцийн нэгж.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 9/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Хавсралт 3. ЦССҮТ, ЦСТ-ийн дүрэм, бүтэц баталсан

ЭМ-ийн сайдын 2020 оны А/445 тоот тушаал

Хавсралт 4. ЦССҮТ-ийн бүтцийн зураглал

1.3 Төвийн үйл ажиллагаа :

1. Хүн амын дунд сайн дурын авлагагүй цусны донорын үйлсийг сурталчлах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг Монголын улаан загалмайн нийгэмлэг болон бусад төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах, донороос цус авах, шинжлэх, болосруулах, хадгалах, олгох;

2. Хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, гүйцэтгэлийг хянах;

3. Чиг үүрэг, эрхэм зорилго, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах:

4. Цус сэлбэлт судлалын чиглэлээ төрөлжсөн мэргэжлийн лавлагаа шатны тусламж үзүүлэх;

5. Цусны донорын бүртгэл, мэдээллий сан бүрдүүлэх, холбогдох мэдээ, тайлан, цусны донор алдаршуулах, урамшуулахтай холбоотой баритыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах;

6. Цус, цусан бүтээгдэхүүн, сорьцыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлэгсэн чиг үүргийг хэрэгжүүлэх;

8. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, тэдний мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

9. Санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх;

10. Хууль тогтоомжоор олгогдсон бусад үүрэг

1.4 Төвийн алсын хараа

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 10/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ББ-ДУ-1-02-02

Цус сэлбэлт судлалын чиглэлээр Азидаа тэргүүлэгч байгууллага болно.

Хавсралт 5. Төвийн Алсын хараа

1.5 Эрхэм зорилго

ББ- ДУ-1-01-02

Чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Хавсралт 6. Төвийн эрхэм зорилго

1.6 Төвийн итгэмжлэгдсэн байдал:

ЦССҮТ нь 2014 онд ЭМЯ-ны магадлан итгэмжлэлд орж, оргүй тусгай мэргэжлийн төвүүдээс анх удаа итгэмжлүүлсэн. 2016 онд давтан итгэмжлүүлж, магадлан итгэмжлэлийг 2 жилийн хугацаатай сунгуулсан. 2018 онд 3 дахь удаагаа орж 5 жилийн хугацаагаар сунгуулсан. Итгэмжлэлийн дугаар № **01/2018** хүчинтэй хугацаа: 2023 оны 2 сарын 07.

Хавсралт 7. Магадлан итгэмжлэлийн батламж

1.7 Төвийн товч түүх, ололт, амжилт:

ЦССҮТ-ийн товч түүх

1938 онд Улсын төв эмнэлгийн эмч В.Ичинхорлоо /нэрт мэс засалч доктор, профессор/-гоос зөвлөх эмч В.Г.Глушников цус авч өвчтөн Лувсандоржид сэлбэсэн нь Эрүүлийг хамгаалахын түүхэнд тэмдэглэгдсэн анхны цус сэлбэлт гэж үздэг.

БНМАУ-ын СНЗ-ийн 1956 оны 1-р сарын 20-ны 16 тоот тогтоолоор Улаанбаатар хотын мэс заслын больницын дэргэд эмнэлгийн байгууллагуудыг бэлтгэн хадгалсан эмчилгээний цусаар хангах “Цус сольж эмчлэх газар”-ыг 4 хүний орон тоотойгоор байгуулжээ.

БНМАУ-ын СНЗ-ийн 1962 оны 9-р сарын 26-ны 505 тоот тогтоолоор “Цус сэлбэх төв станц”-ыг Улаанбаатар хотод байгуулах, улмаар бүх аймгуудад цусны салбар станцыг байгуулахаар уг тогтоолд тусгагдсан. 1963 онд Цус сэлбэх төв станцын анхны захирлаар их эмч Чимэддуламийн Шаравыг, зөвлөхөөр ЗХУ-ын

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 11/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

мэргэжилтэн И.Ф.Хоменко нарыг томилсноор Монгол улсад цус сэлбэх алба бие даан албан ёсоор байгуулагдсан билээ.

1971 онд Цусны сэлбэх төв станцын орон тоо, бүтцийг шинэчлэн өргөжүүлж БНЧУ-ын буцалтгүй тусламжаар өдөрт 60 донорт үйлчлэх хүчин чадал бүхий, иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон цусны төвийн зориулалтын шинэ байр ашиглалтанд орсон.

1973 онд БНМАУ-ын СнЗ-ийн 253 дугаар тогтоолоор хуучин нэрээр “Бактер шинжилгээний газар”-ыг Эрүүл ахуй халдвар нян судлалын улсын институтээс салган, Цус сэлбэх төв станцтай нэгтгэж Улсын эм хангамж, үйлдвэрийн газрын харъяа “Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институт” болгон өөрчилсөн.

1987 онд СнЗ-ийн 11-р тогтоол, Эрүүлийг хамгаалах яамны сайдын А/07 тоот тушаалаар Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институтын биобэлдмэлийн хэсгийг Эрүүл ахуй халдвар, нян судлалын институтэд шилжүүлж, Цус сэлбэх станцыг бие даалган “Биобэлдмэл, цусны үйлдвэр шинжилгээний институт” болгон

1990 онд СнЗ-ийн 161-р тогтоолыг үндэслэн Эрүүлийг хамгаалах яамны сайдын А154 тоот тушаалаар “Биобэлдмэл цусны үйлдвэр шинжилгээний институт”-ыг татан буулгаж “Цус сэлбэлт судлалын төв” нэртэйгээр ЭХЯ-ны харъяанд шилжүүлэв.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 5-р сарын 23-ны 138 тоот тушаалаар “Цус сэлбэлт судлалын төв”-ийг “Цус сэлбэлт судлалын үндэсний төв” болгон өргөжүүлж, ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны дүрмийг баталсан юм.

ЭМС-ын 2013 оны 408 тоот тушаалаар ЦССҮТ-ийн дүрэм бүтэц шинэчлэгдэн баталсан.

Монгол улсын ЗГ, АХБ-ны санхүүжилтээр ЦССҮТ-ийн шинэ байр 2016 онд ашиглалтанд орж техник технологийн бүрэг шинэчлэлийг хийсэн.

ЭМС-ын 2020 оны 09 сарын 22-ны А/445 дугаар тушаалаар шинэ бүтцийг шинэчлэн баталсан.

Цусны албаны ололт амжилт, 1993-2018 он

№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
1	Сайн дурын авлагагүй донорын тогтолцоонд шилжсэн /1994 он/
2	ЦЦБ-ийг нийлэг хүүдийнд цуглуулах, бэлтгэх технологид шилжсэнээр цус цуглуулах үйл ажиллагаанд хэрэглэгдэх бүх зүйл нэг удаагийн хэрэглээний болсон /1994 онд цусны төвөөс эхлэн 1996 он гэхэд улсын хэмжээнд 100% шилжсэн/
3	С гепатитын халдвар илрүүлэх шинжилгээг 1997 оноос эхлэн хийж эхэлсэн

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 12/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

4	Цус, цусан бүтээгдэхүүнд хийгдэх ДОХ, В, С гепатитын шинжилгээг 1998 оноос ELISA-ийн аргаар хийдэг болсон
5	Цуглуулсан шинжилгээний дээжийг ийлдсийн санд хадгалах, ашиглах журам боловсруулан мөрдсөн /1999 он/
6	Сургалтын кабинет байгуулан, номын сан, шаардлагатай техник хэрэгслээр тохижуулсан/2000, 2004, 2009/
7	Цусны сийвэн, ялтас эс ялгах Аферезийн технологийг нэвтрүүлсэн /2001 он/
8	ДОХ, сүрьеэтэй тэмцэх дэлхийн сангийн дэмжлэгтэй “Цусны аюулгүй байдал” дэд хөтөлбөр хэрэгжиж ирсэн /2003 он/
9	Цусны албаны үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн 2004 он
10	ЦССҮТ-ийн үйл ажиллагааны үйл ажиллагаа бүрт САА боловсруулж, мөрдөж эхэлсэн /2004-2005/
11	ЦСДХ илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээгээр олон улсын ЧГҮ-ний хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн /2005 он/
12	Трансфузиологийн лавлагаа лаборатори байгуулагдсан /2007 он/
13	Донор элсүүлэх цус цуглуулах тасгийг шинээр тохижуулж, донорт үйлчлэх таатай орчинг бүрдүүлсэн /2009 он/
14	Цусны хувийн тохироог 3 үе шаттай хуруу шилний аргаар тодорхойлох шинэ тогтолцоог нэвтрүүлсэн /2010 он/
15	ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд цахим сүлжээ нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн /2011 он/
16	Молекул биологийн лаборатори байгуулж, PCR –ийн аргаар шинжилгээ хийдж эхэлсэн /2011 он/
17	Шинэ цусны төв байгуулах ажлыг санаачлан барилгын зураг боловсруулж, газрын асуудлыг шийдвэрлүүлсэн /2011 он/
18	Цус, цусан бүтээгдэхүүнийг улсын байнгын нөөцтэй байлгах эрх зүйн орчинг шинэчилсэн /2011 он/
19	Донорын тухай хууль боловсруулж, шинэчлэн батлуулсан /2012 он/
20	ЦСДХ илрүүлэх үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн
21	ЦССҮТ-ийн бүх үйл ажиллагаанд цахим сүлжээг бүрэн нэвтрүүлсэн /2013 он/
22	НХО шинжилгээгээр олон улсын ЧГҮ-ний хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн. /2013/
23	Сийвэнгийн бүтээгдэхүүний гамшгийн нөөц бүрдүүлж эхэлсэн /2013 он/
24	Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох чиглэлээр үндэсний чанарыни гадаад үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн 2012-2013 он
25	Донорын сургалт сурталчилгааг зохион байгуулах маркетингийн нэгж байгуулсан /2014/
26	Цитоферезийн аргаар ялтаст эсийн өтгөрүүлэг бэлтгэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбаруудад олгож эхэлсэн./2014 он/
27	УБ хотод цусны төвийн шинэ барилгын ажил эхэлсэн /2014 он/

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 13/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

28	АХБ-ны хөнгөлттэй зээлээр ЭМСХХ-5 төсөл хэрэгжиж эхэлсэн./2014/
29	БЗД-т төвийн шинэ барилга ашиглалтанд орсон 2016 он
30	Улаан эсийг хөлдөөж хадгалах, эсийн бүтээгдэхүүнийг рентген туяагаар шарах, ялтас эс, сийвэнгийн бүтээгдэхүүний эмгэг төрүүлэгчийн идэвхгүйжүүлэх зэрэг орчин шинэ технологиудыг нэвтрүүлж, нутагшуулж байна 2016-2017 он
31	БНХАУ-ын Шанхай хотын цусны төвтэй хамтарч “Цусны ховор бүлэг” ОУ-ын хурлыг УБ хотод зортон байгуулж 8 орны эрдэмтэн судлаач нар оролцсон. 2016
32	Донорын тухай хуулийг шинэчлэн батлуулсан /2017 он/
33	ЦССҮТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандартыг батлуулсан MNS6647:2017
34	ЦССҮТ-ийн стратеги болон маркетингийн дунд хугацааны төлөвлөгөө болосруулсан /2017-2021/
35	ЦССҮТ нь БНХАУ-ын Шанхай хотын цусны төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан./2017/
36	Цусны албаны тоног төхөөрөмжийн бүртгэл, завсар үйлчилгэний удирдлагын цахим тогтолцоог хэрэгжүүлсэн. /2017 он/
37	Төвийн лаборатори MNS ISO 15189:2015 стандартаар итгэмжлүүлж 4 жилээр сунгуулсан
38	Төв MNS ISO 9001:2016 стандартаар баталгаажуулалт хийлгэн 3 жил хүчинтэй гэрчилгээ авсан /2017/
39	2018 1 сарын 1-ээс “Донорын тухай” хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн
40	БНХАУ-ын Шанхай хотын Цусны төвтэй хамтарсан анхдугаар хурал зохион байгуулж, 170 гаруй эмч мэргэжилтэнг хамруулсан.
41	Төв нь 2018 онд MNS ISO 18001:2008 ХЭМАБ-ын тогтолоцооны стандартыг хэрэгжүүлж, 3 жилээр баталгаажуулалт хийлгэсэн.
42	“Эрүүл ажлын байр” улсын уралдаанд 2- байр эзэлсэн. 2018
43	ЭМСХХ-5 төслийн хүрээнд ТТ, НЛ-ийн Тасгийн тавилгууд шинэчлэгдэн суурилуулсан 2018
44	НЛ-ийн тасагт ХИ, бүлэг тодорхойлох, бүлэгнэлтийн шинжилгээний шинэ тоног төхөөрөмжийг хүлээн авч суурилуулах ажил эхэлсэн. 2018
45	Англи улсад төвтэй Lloyds Register байгууллагаар ЧМТ хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээ хийгэн баталгаажуулалт хийлгэсэн. 2019 он Энэ нь Монгол улсын Цусны албаны үйл ажиллагаа, ЦЦБ-ий чанарын баталгааг ОУ-д хүлээн зөвшөөрсөн том нотолгоо боллоо.
46	ЧМТ давтан баталгаажуулалтанд амжилттай орж, гэрчилгээг 3 жилээр сунгасан. 2020 он

2. Норматив иш таталт

Дараах баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн норматив байдлаар энд иш татсан ба тэдгээрийг хэрэглэх зайлшгүй шаардлагатай. Хугацаа заасан ишлэлийн хувьд зөвхөн тухайн хэвлэлийг ашиглана. Хугацаа заагаагүй ишлэлийн хувьд иш татсан баримт бичгийн сүүлчийн хэвлэл (аливаа өрчлөлтийг багтаасан)-ийг хэрэглэнэ.

Төвийн үйл ажиллагаанд Монгол усны **41** хууль, Монгол улсын **4** стандарт, **ЗГ-ын 7** тогтоол, ЭМ-ийн сайдын **70**, сангийн сайдын **2**, хөдөлмөрийн сайдын **1** тушаал,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 14/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

төвийн захирлаар батлуулсан 52 журам, 76-САЗ, 29 ТТАЗ, 27 АЗ, 163- маягт, 24 хяналтын хуудас үйл ажиллагаандаа мөрдөнө.

Хавсралт 8. Төвд мөрдөж байгаа баримтжуулсан мэдээллийн нэгдсэн жагсаалт
ISO 9001: 2015 Чанарын менежментийн тогтолцоо - Үндсэн ухагдахуун, тайлбар
толь

3. Нэр томъёо ба тодорхойлолт

ISO 9001: 2015 стандартад тогтоосон нэр томъёо ба тодорхойлолтыг энэ баримт бичигт хэрэглэнэ.

Төвийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд холбоотой үндсэн тодорхойлолтуудыг Англи, Монгол хэл дээр нэр томъёоны тодорхойлолтын хамт орууллаа.

Хавсралт 9. Нэр томъёоны тайлбар

4. Байгууллагын төлөв байдал

4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

Байгууллагын төлөв байдалд төвийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулахад эерэг болон сөргөөр нөлөөлж болох боломж, эрсдлүүдийг авч үзнэ.

ЦССҮТ- нь чанарын менежментХЭМАБ-ын тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх зорилгоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Гадаад асуудалд:

- Хууль эрх зүйн талаас:
 - Донорын тухай хууль, ЭМ-ийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль, ХЭМАБ-ын хууль зэрэг бусад холбоотой хуулиудыг үйл ажиллагаандаа мөрддөг.
 - ЭМ-ийн сайдын тусламж, үйлчилгээ, цусны албаны үйл ажиллагаатай холбогдох тушаалуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.
 - Хууль, ЭМ-ийн сайдын тушаал батлагдах, шинэчлэгдэх үйл явц боловсруулан, хянуулах, хэлэлцүүлэхэд тодорхой хугацаа шаарддаг.
- Эдийн засгийн талаас:
 - ЦССҮТ дээр 2014 оноос эхлэн АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа ЭМСХХ- 5 төслийн санхүүжилтээр техник, технологийн шинэчлэлийг бүрэн хийж чадсан ололттой.
 - Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг алба, тасгууд тооцоолон санхүүгийн алба нэгтгэн боловсруулж, төвийн Ерөнхий захирал хянан ЭМЯ-

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 15/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ны эдийн засаг, санхүүгийн газарт хүргүүлдэг. ЭМЯ, СЯ-ны холбогдох хэлтэс газар төсвийн төслийг хянах, танах, баталгаажуулах, үйл ажиллагааг хийнэ. Батлагдсан төсөвт тохируулан хуваарилж, зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилладаг.

- Валютын ханшны өөрчлөлт, үнийн өсөлт импортоор орж ирдэг бараа материалын нийлүүлэлтэнд, хугацаанд сөрөг нөлөөл үзүүлэх магадлалтай.
- ЗГ-аас баталсан хязгаарлагдмал төсөвд тохируулан үйл ажиллагаа явуулдаг.

3. Дэд бүтэц:

- Улирлын байдлын нөлөө - зуны улиралд их дээд сургууль, ажилчдын амралтын үед донорын тоо цөөрч нөөц хомсдох асуудал үүсч болно.
- Хөдөө орон нутагтай холбоотой – УБ хотоос аймгийн төв рүү онгоцны нислэг өдөр бүр байхгүй тул зарим ховор бүтээгдэхүүнийг яаралтай үед тээвэрлэх асуудалд бэрхшээл тулгарч болно. Мөн УБ аймгуудтай хар замаар холбогдсон байдал нь хотоос алслагдсан аймгуудад бүтээгдэхүүн тээвэрлэх боломжгүй байдаг.
- Авто замын ачаалал их үед явуулын хэлбэрээр цуглуулсан цусны тээвэрлэлтийн асуудал удаашрах, цаг агаарын хүчин зүйлийн өөрчлөлт хэт халах, хүйтрэх нь цусан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтэнд нөлөөлж болно.

4. Нийгэм, соёлын:

- Монгол хүний нээлттэй тусархаг зан донорын хөдөлгөөнийг сурталчилахад эерэг нөлөөтэй.
- Хүн амын өсөлт нэмэгдэж байгаа, 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд нийт хүн амын дийлэнх хувийг эзэлдэг.
- Сүүлийн жилүүдэд байгууллага, хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд донорын эгнээд нэгдэх ажилд хамрагдах нь сайжирч эхэлсэн.
- Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг хандлага муу гэдэг нь судалгаагаар тогтоогдсон,
- Хүн амын дунд цусаар дамждаг В, С гепатит, тэмбүүгийн халдварын тархалт өндөр,
- Вакцинжуулалтын үед донорууд тодорхой хугацаанд цус өгөх боломжгүй болдог
- Өвчлөлийн бүтэц, осол гэмтэл ихсэж байгаа, хавдрын өвчнүүд хожуу оношилогдож, төрөлт нэмэгдсэн нь ЦЦБ-ий хэрэглээг ихэсгэж байна.
- Агаарын бохирдол, буруу хоололт, амьдралын буруу дадал хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна.
- КОВИД -19 цар тахал, хөл хорионы дэглэм доноруудын цус өгөхөд бэрхшээл учруулж, цус өгөлтийн хэмжээ багасахад хүрч байна
- Улирлын чанартай өвчлөлтэй холбоотой донороос цус авахад учрах бэрхшээл учирдаг.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 16/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Сүүлийн жилүүдэд нийгмийн хариуцлагын хүрээнд цусны донорын хөдөлгөөнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд сайн хамрагдаж, дэмжиж хамтран ажилладаг болсон.
5. Өрсөлдөөний хүчин зүйл - цусны асуудал хариуцсан цор ганц, мэргэжлийн лавлагаа төв байгууллага. Цор ганц байгууллага тул өрсөлдөгч байхгүй. Сөрөг байдал нь сайн туршлага хамтын ажиллагаа хийхэд заавал гадаад харилцаа хөгжүүлэх шаардлага гардаг бэрхшээлтэй байдаг.
 6. Улс төрийн:
 - Хөгжилтэй оронд цусны асуудал хариуцсан төв байгууллага болон мэргэжлийн холбоо, нийгэмлэг цусны аюулгүй байдалтай холбоотой бүх асуудлыг бие даан шийдвэрлэдэг тул хялбар байдаг байна.
 - ЗГ, ЭМЯ-ны бүтэц жил тутам өөрчлөгддөг байдал халаа, сэлгээ богино хугацаанд хийдэг нь бодлого, зорилтыг тууштай хэрэгжүүлэхэд саад учирч болно.
 - Улсын хэмжээнд мөрдөх нийтлэг журам, заавар ЭМЯ-аар орж баталгааждаг нь тодорхой хугацаа шаардах бэрхшээл байж болно.
 7. Байгалийн хүчин зүйл, гамшиг
 8. Цахилгаан, дулаан, усны хангамж одоогоор төвлөрсөн хангамжтай. Цахилгааны нөөц үүсгүүрүүдээр бүрэн хангагдсан тул Баянзүрх, Сүхбаатар төвийн хэмжээнд нөөц үүсгүүрүүдийг ажиллуулж бүтээгдэхүүнийг зөв нөхцөлд хадгалж чадаж байна.
 9. Хэвлэл мэдээлэл, цахим орчиноор цусны донорын тухай, мэдээлэл, сургалт сурталчилгааг хийх боломжтой болсон.

Дотоод асуудалд:

1. Монгол улсын цусны алба үүсч хөгжсөн 55 жилийн түүхтэй.
2. Үе, үеийн эмч, ажиллагсдын бүтээсэн ажил үйлс, хуримтлуулсан арвин баян туршлагатай
3. Олон улсын шаардлагад нийцсэн цусны албаны бүтцийг шинэчлэн бүрдүүлсэн.
4. Байгууллагын соёлыг нэвтрүүлж, хөгжүүлж байна. Ажиллагсад ажилдаа дуртай, үнэнч, шударга сэтгэлтэй.
5. Трансфузиологийн чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулж, мэргэшсэн үндэсний боловсон хүчнээр хангагдсан.
6. Цусны албанд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн өндөр технологи нэвтэрч, цус, сийвэн, эс цуглуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах аппарат, тоног төхөөрөмжтэй болсон.
7. Бүхий л үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн.
8. Үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг улсаас хангадаг.
9. Ахмад, дунд, залуу үеийн төлөөллийн тэнцвэртэй харьцаа, залгамж, холбоог хадгалдаг.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 17/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

10. Ажлын ачаалал их, хүний нөөцийн хомсдолтой.
11. Цусны албаны нарийн мэргэжлийг заавал гадаад оронд эзэмших шаардлагатай болдог.
12. Үндсэн болон дэмжих үйл ажиллагааг нийт 70 орон тоотойгоор цус сэлбэлт судлалын лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлдэг учир амралтын улирал болон сургалтанд хамрагдах удаан хугацаагаар өвчтэй чөлөөтэй үед хүний нөөцийн ачаалал их зарим тохиолдолд олон ажлыг хослон хавсран гүйцэтгэх шаардлага гардаг.

ЦССҮТ нь эдгээр гадаад, дотоод асуудалд хамаарах мэдээлэлд мониторинг, байнгын дүн шинжилгээ хийж ажилладаг. Долоо хоног бүрийн шуурхай зөвлөгөөнөөр үйл ажиллагааны гүйцэтгэл, асуудлыг хэлэлцэн төвийн захирал шийдвэр гаргаж, үүрэг өгөгдөн хэрэгжилтийг хянадаг.

ЦССҮТ нь хөгжлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулах, үйл ажиллагааг жил бүрийн төлөвлөлтөнд тусган хэрэгжилтийг үнэлэх, төвийн дүрэм, бүтцийг шинэчлэх бүрд гадаад болон дотоод асуудлыг үнэлэн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, хэрэгжилтэнд шаардлагатай өөрчлөлтийг хийдэг.

Төвийн алба тасгууд жилийн үйл ажиллагааны тайланд дээрх гадаад болон дотоод асуудалд мониторинг, дүн шинжилгээ хийн, өөрчлөлтийг тайланд тусган удирдлагын зөвлөлд тайлагнаж хэвшиж байна.

4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох

ЦССҮТ нь хэрэглэгчийн болон холбогдох хууль, стандарт, дүрэм, заавар, журмын шаардлагыг хангасан цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээг 24 цагийн турш байнга нийлүүлэхэд нөлөөлөх сонирхогч талууд, тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойллоо.

Төвийн **гадаад сонирхогч тал**: - ЭМЯ, ЭМХТ, МУЗН, ДЭМБ, ЦЦБ хэрэглэгч улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, ханган нийлүүлэгч байгууллагууд, МХЕГ, СХГ, цусны донорууд, төвөөс тусламж, үйлчилгээг авч буй ард, иргэд, хамтран ажиллагч төрийн болон төрийн бус байгууллагууд, анагаахын чиглэлээр сургалт хийдэг их, дээд сургуулиуд

Төвийн **дотоод сонирхогч тал**: - Төвийн алба, тасаг, орон тооны бус алба, баг, комисс, эмч, мэргэжилтэн, ажиллагсад, гэрээт ажилтан, орон нутгийн ЦСТ-ийн эмч, мэргэжилтэн.

Сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлага:

ЭМЯ - Холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг чанд мөрдөх хэрэгжилтийг цаг хугацаанд нь тайлагнах, цусны аюулгүй байдалтай холбоотой бодлого хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр хангах.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 18/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ДЭМБ - Цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр гаргасан стратеги, зөвлөмж, санамж бичгийг хэрэгжүүлэх.

МУЗН - “Донорын тухай” МУЗН эрх зүйн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх хүрэлцээтэй санхүүжилт, хамтын дэмжлэгт ажиллагаа,

Эмнэлгүүд - Эмчилгээний үр дүнтэй, чанартай, хүрэлцээтэй ЦЦБ, 24 цагийн олгох үйлчилгээ

Ханган нийлүүлэгч байгууллага - Урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, төлбөрийг хугацаанд нь шилжүүлэх.

МХЕГ- Хууль, стандарт, тушаал шийдвэрийг зөв дагаж, хэрэгжүүлэх.

СХГ- Олон улсын болон үндэсний стандартыг мөрдөж, хэвшүүлэх, хөгжүүлэх.

ЭМХТ- Статистик мэдээлэл цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн мэдээлэх, богино хугацааны болон мэргэшүүлэх сургалтыг заавар журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн мэдээлэх

АШУУИС болон бусад сургууль - Оюутан, мэргэжил олгогч эмч, мэргэжилтэнд сургалт зохион байгуулах, дадлага хийх нөхцөл бололцоогоор хангах, судалгаа шинжлэгээний ажлыг хамтран зохион байгуулах, судалгаа хийх мэргэжил арга зүйгээр хангах

Цусны донорууд - Үйлчилгээний цэвэр, тухтай, аюулгүй орчин, хурдан, чадварлаг үйлчилгээ, хүрэхэд ойр олон цэгийн үйлчилгээ, эелдэг харьцаа хандлага, зөв боловсон, шуурхай үйлчилгээ, зөвлөгөө.

Ард, иргэд - Шуурхай, нэг цэгийн үйлчилгээ, шинжилгээний зөв хариу, богино хугацаанд хариугаа авах, цахим үйлчилгээ, эелдэг харьцаа хандлага, зөв боловсон, шуурхай үйлчилгээ, зөвлөгөө.

Төвийн эмч, ажиллагсад - Аюулгүй, тухтай орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын хувийн хамгаалалтын хувцас, шаардлагатай хэрэгслийн хангамж, сурах, мэдлэг, боловсрол, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг, ажлын байран дээрх эрүүл, хөнгөлттэй, үдийн хоол, амжиргаанд хүрэлцээтэй цалин хөлс, нийгмийн асуудлын дэмжлэг

Гэрээт ажилтан- Хөдөлмөрийн холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэрээ байгуулах, тохирсон хөдөлмөрийн хөлсийг хугацаанд нь авах

Орон нутгийн ЦСТ эмч, ажиллагсад – Цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг авах, шаардлагатай зөвлөмжийг шуурхай авах

ЦССҮТ нь эдгээр сонирхогч талуудад хамаарах мэдээлэл, холбогдох шаардлагад мониторинг хийх, үйлчүүлэгч, хэрэглэгч, хамтран ажилладаг

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 19/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

байгууллага, хамт олноос сэтгэл ханамжийн судалгаа тогтмол давтамжаар авах, уулзалт ярилцлага хийх, цахим болон цаасан хэлбэрээр санал хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн дүгнэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Төвийн алба, тасаг, ёс зүйн хороо сар, улирал бүр дээрх судалгааг тогтмол явуулан үр дүнг нэгтгэн санал, хүсэлтийн дагуу хэрэгжүүлсэн ажлын үр дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн дүгнэсэн байна.

Төвийн цахим хуудас, мэдээллийн самбар дээр сонирхогч талуудын санал, хүсэлт, түүний мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг мэдээлж ажиллана.

Нээлттэй хаалганы өдрийн хүрээнд холбогдох сонирхогч талуудад холбоотой мэдээллүүдийг өгч баримтжуулна.

Удирдлагын дүн шинжилгээгээр хэрэглэгч, үйлчүүлэгч, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааны дүн, түүний мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ, дэмжлэг ахмтын ажиллагааны талаар хэлэлцэж, шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллана.

4.3 Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны хамрах хүрээ

Төвийн хамт олон Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр -5 төслийн “Цусны аюулгүй байдлыг хангах” дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн, чанарын менежментийн тогтолцоо стандартыг бүх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн үндэсний хэмжээнд 2017 онд, олон улсын хэмжээнд 2019 онд баталгаажуулалт хийлгэн гэрчилгээ авсан. 2018 онд ХЭМАБ-ын 18001 стандартыг үндсэн болон дэмжих үйл ажиллагаандаа хэрэгжүүлж гэрчилгээ батламжаа авсан одоо 45001 стандарт руу шилжих ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цусны албаны техник технологийн бүрэн шинэчлэл хийх,
2. Сайн дурын авлагагүй донор, байнгын донорын эгнээг өргөжүүлэх, хадгалах
3. Цус, цусан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах,
4. Цахим төв болох,
5. Эрсдлийн үнэлгээг хийж, засаж, сайжруулах, сэргийлэх арга хэмжээг тодорхойлон, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
6. Үйл ажиллагаандаа ISO 9001:2015 Чанарын Менежментийн Тогтолцоо (ЧМТ), Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ)-ын стандартыг нэвтрүүлэн үйл ажиллагаагаа байнга сайжруулах зэрэг болно.

Төвийн ЗМА, ЭШМТА, ЦЧАБА, СҮ-ий алба, ДЗБ, НЛ, БҮТ, ИТ-ийн тасгууд Чанарын Менежментийн Тогтолцоо MNS ISO 9001:2016, ХЭМАБ-ын тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартын шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 20/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ажиллана. Төвийн ерөнхий захирлын 2016 оны а/51, 2017 оны а/18 тоот тушаалаар төвийн нийт хамт олон ЧМТ-г хэрэгжүүлэхийг баталгаажуулсан. . . .ХЭМАБ баг байгуулсан тушаал ????

Төвийн цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулах, ЦЦБ үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, олгох үндсэн үйл ажиллагаа болон эдгээр үйл ажиллагааг зөв зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай дэмжих үйл ажиллагаа, цусны донор, эмнэлгийн байгууллага, ард иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээнд Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог нэвтрүүлж, хадгалж, байнга сайжруулж ажиллана.

Төвийн чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны хамрах хүрээг төвийн Ерөнхий захирал батлан, нийт эмч ажиллагсад цахим болон мэдээллийн самбараар ил тод мэдээлж ажиллана. /2017 оны 6 сарын18 ны өдрийн а/18 тоот тушаал, ХЭМАБ-ыг төвийн бүх ала тасаг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

4.4 Чанарын менежментийн болон ХЭМАБ-ын тогтолцоо ба үйл явц / ажиллагаа

4.4.1 ЦССҮТ нь цусны албаны үндсэн болон дэмжих үйл явц, ажиллагааг тодорхойлсон. Үйл явц, үйл ажиллагааг бүрдүүлэх ажилбаруудыг нарийвчлан тодорхойлж, хариуцах алба, тасаг, нэгжийг болон орон тооны бус алба, баг, комиссыг төвийн захирлын тушаалаар батлан холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллана.

Үйл явц, ажилбаруудын харилцан уялдаа, үйлчлэл, бие, биедээ харилцан нөлөөллийг зөв тогтоон, үйл явц, ажилбар бүр үйлчлүүлэгч, эмч, ажиллагсад аюулгүй орчинд явагдаж, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг дараагийн үйл явц, ажилбарт хүлээлгэн өгч баримтжуулах тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлж, хэрэгжилтийг хянан, байнга сайжруулж ажиллана.

Төвийн үндсэн болон дэмжих үйл ажиллагааны тоон болон үйл ажиллагааг жил, улирал, сараар төлөвлөн гүйцэтгэлийг улирал, хагас бүтэн жилээр хэлэлцэн дүгнэж ажиллана.

ЦССҮТ-ийн үйл явц:

Нэг. Үндсэн үйл явц/ ажиллагаа

1. Цусны донорын сургалт, сурталчилгааг Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сурталчилгааны бүх арга хэрэгслийг ашиглан зохион байгуулах,
2. Цус, сийвэн, эс цуглуулах /суурин болон явуулын хэлбэрээр/
3. Цусны доноруудад болон цус, цусан бүтээгдэхүүнийг шинжлэх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 21/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

4. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, /ердийн болон гамшгийн нөөц бүрдүүлэх/
5. ЦЦБ хадгалах, хадгалалтыг хянах, ЦЦБ-ийг эмнэлгийн захиалгын дагуу олгох

Хоёр. Дэмжих үйл ажиллагаа

1. Төв зорилгодоо хүрэх хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэх, сайжруулах
2. Төвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилтийг төсөвлөх, батлуулах, хуваарилуулах, орлого, зарлагыг бүртгэн тайлагнах, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн явуулах,
3. Төвийн ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэх, сонгох, сургах, ур чадвар эзэмшүүлэх, хадгалах, хөгжүүлэх
4. Төв үйл ажиллагаа явуулахад шаардлагатай чанартай, хүрэлцээтэй хэрэгслээр хангах, тодорхой нөөц бүрдүүлэн тогтвортой хангах
5. Төвийн үйл ажиллагааны мэдээг тогтмол цуглуулж, нэгтгэн төвийн удирдлагын зөвлөл, холбогдох газарт цаг хугацаанд нь илгээх, хадгалах
6. Тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээг тогтмол хийн, тохируулж, аюулгүй тогтвортой ажиллагааг хангах,
7. Төвийн үйл ажиллагааны цахим орчинг бүрдүүлж, тогтвортой, аюулгүй байдал, нууцлалыг хадгалах
8. Төвийн үйл ажиллагаанд чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог нэвтрүүлж, байнга сайжруулж, хөгжүүлэх
9. Төвийн алба, тасгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах
10. Архивын үйл ажиллагаа төвийн баримт бичгийг цаасан, цахим хэлбэрээр хадгалах, хамгаалах

4.а Оролт: Цусны албанаас эмнэлгийн байгууллага аюулгүй, эмчилгээний үр дүнтэй, цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэгцээтэй үедээ хүрэлцээтэй хэмжээгээр авах, цусны донорууд ард иргэд цэвэр тухлаг орчин, эелдэг харилцааг нэг цэгийн шуурхай үйлчилгээ, мэргэжлийн өндөр ур чадварыг хүсэн хүлээнэ.

Үндсэн үйл ажиллагааны оролт нь Хүн амын эрсдэл багатай бүлгээс сонгосон, сайн дурын авлагагүй донорууд болно. Хүрэлцээтэй ЦЦБ нөөц бүрдүүлэхэд хангалттай хэмжээний цусны донортой байх.

4.б Гаралт: Үйлчүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамж манай төвийн ерөнхий үйл явцын гарц болно. Энэ нь байгууллага, хамт олны донорын хөдөлгөөнд хамрагдалт нэмэгдэх, байнгын донорын тоо өсөлт, эмнэлгүүдэд цаг хугацаанд нь бүтээгдэхүүн бүрэн олгосон хэмжээ хувь өсөх, эмч, ажиллагсад, үйлчүүлэгчийн аюулгүй байдал хангагдалт, ард иргэд үйлчүүлэгчийн сэтгэл ханамж, талархал нэмэгдэлтээр илэрнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 22/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Үндсэн үйл ажиллагааны гаралт нь чанар болон техникийн стандартын шаардлагад нийцсэн аюулгүй, хүрэлцээтэй цус, цусан бүтээгдэхүүн шуурхай, цогц үйлчилгээ болно.

Төвийн ерөнхий үйл явцын тухай:

- ҮЯТ-ЧА-2- 04-02,

Хавсралт 11. ЦССҮТ-ийн үйл явцын зураглал.

Тасгуудын үйл явцын тодорхойлолт:

- ҮЯТ- ДМ- 2-01-02,
- ҮЯТ- НЛ-2-28-02,
- ҮЯТ-БҮТ-2-01-02,
- ҮЯТ-МТ-2-01-02,
- ҮЯТ-СМ-2-01-02,
- ҮЯТ-АА-2-01-02,
- ҮЯТ-АА-2-04-02,
- ҮЯТ- АА-2-03-02
- ҮЯТ –ЭШМТ -2-01-02
- ҮЯТ –ЗМ -2-01-01 баримт бичгээс дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Хавсралт 12. Төвийн алба, тасгуудын үйл явцын тодорхойлолт

4.в Төвийн үндсэн үйл ажиллагаа нь:

Нэг. Донор зохион байгуулалтын тасаг.

1.1 Донор элсүүлэх, цус, сийвэн, эс цуглуулах

- Тасгийн үйл явцын тодорхойлолт, донорыг угтах, мэдээлэл өгөх, бүртгэх, эрүүл мэндийн үзлэг хийх, шинжилгээний хариу өгөх, цус, сийвэн, эс цуглуулах, шаардлагатай үед яаралтай тусламж үзүүлэх, донор дуудах зэрэг бүхий л үйл ажиллагааны журам, стандарт ажиллагааны заавар, ажлын зааврыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, үйл ажиллагаанд хяналтын хуудас боловсруулж, хэрэглэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
- Суурин болон явуулын хэлбэрээр цус, сийвэн цуглуулах журам, заавар боловсруулж мөрдөх, цэвэр, тохилог, тухтай, аюулгүй орчинг бүрдүүлэх
- Явуулын цус цуглуулах төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, биелэлтийг гаргах, дүгнэх
- Донорын эрүүл мэндийн үзлэгийг шалгуурын дагуу зөв, бүрэн хийн, асуумж судалгаа, ярилцлага хийн донор сонгох шалгуур үзүүлэлтийг чанд мөрдөнө

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 23/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Суурин болон явуулын хэлбэрээр стандартын шаардлага хангасан цус, сийвэнг цуглуулах,
- Ийлдэсийн сангийн болон шинжилгээний дээжийг зөв, бүрэн авч, лабораторийн тасагт хүлээлгэн өгч, баримтжуулах
- Донорын сонор сэрэмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Цус, сийвэн, эс цуглуулалт хийгдсэн тухай холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн зөв хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэггэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх
- Цус, сийвэн, эс цуглуулахад хэрэглэгдэх аппарат, тоног төхөөрөмжийн суурилуулалт, баталгаажуулалт, тохируулга, засвар үйлчилгээг графикийн дагуу зөв хийж байгаад хяналт тавьж, хэрэглэгчийн талаас хийх арчилгаа үйлчилгээг тогтмол хийж, ажилласан цагийн бүртгэлийг баримтжуулах,
- Тоног төхөөрөмжтэй зөв, аюулгүй ажилуулах, халдварын сэргийлэлт хяналтын сургалтанд сууж, биологийн халдвартай зүйлстэй зөв харьцаж, аюулгүй ажиллагааны журам, дүрмийг чанд мөрдөж өөрийгөө болон хамт ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана
- Үйлчлүүлэгчдэд эрүүл аж төрөх ёс, дадал хэвшүүлэх, цус өгөхийн өмнө болон дараах зөвлөгөө, сургалт, сурталчилгааг тогтмол хийн баримтжуулна
- Улсын хэмжээний донорын бүртгэлийн мэдээллийн санг үүсгэн баяжуулах, мэдээллийн үнэн зөвийг батлах, нууцлалыг хадгалах, тухай бүр архивлах
- Өдөр бүр бүтээгдэхүүний нөөцтэй танилцан нөөц бага, хомсдсон үед донор дуудах, бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх
- Тасгийн үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны маягтуудыг бүрэн хөтөлж, баримтжуулж, баталгаажуулан архивлах,
- Доноруудын нууцлалыг чанд хадгалах, шинжилгээний хариу, зөвлөгөө өгөх /хувийн нууц, ЭМ-ийн тухай хуулийн заалт зөрчвөл хариуцлага хүлээнэ./
- Доноруудын эрүүл мэндийг хамгаалах, цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн удаа тоо мэдээг нотолгоонд тулгуурлан үнэн зөв гаргаж өгөх болон урамшуулах, алдаршуулахад ажлыг Маркетингийн нэгжтэй хамтран зохион байгуулах
- Сүлжээ системийн тогтмол ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах
- Яаралтай тусламжийн цэгийг зохион байгуулах, эмч мэргэжилтнүүдэд сургалт явуулах
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Цусны донорын тухай, эрүүл аж төрөх дадал хэвшлийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол олон хэлбэр ашиглан хийх
- Шинжилгээний хариу урилга, талархал илгээх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 24/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Донорын бүртгэл, хөдөлгөөн, үзлэг, цус, сийвэн цуглуулах, сургалт, сурталчилгаатай холбоотой тайлан мэдээг төвийн, салбар төвийн, улсын хэмжээнд үнэн, зөв гаргаж цаг хугацаанд нь мэдээлэх
- Донор зохион байгуулалтын чиглэлээр МУЗН, сайн дурын ажилтан, цусны албаны эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах

Хоёр. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тасаг:

2.1 ЦЦБ- үйлдвэрлэх нэгж

- Тасгийн үйл явцын тодорхойлолт, ЦЦБ-ийг хүлээн авах, бүртгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хорионд хадгалах, чөлөөлөх стандарт ажиллагааны аргачлал, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
- Үйлдвэрлэлд хэрэглэгдэх аппарат, тоног төхөөрөмжийн суурилуулалт, баталгаажуулалт, тохируулга, засвар үйлчилгээг графикийн дагуу зөв хийж байгаад хяналт тавьж, хэрэглэгчийн талаас хийх арчилгаа үйлчилгээг тогтмол хийж, ажилласан цагийн бүртгэлийг баримтжуулах,
- Тоног төхөөрөмжтэй зөв, аюулгүй ажилуулах, халдварын сэргийлэлт хяналтын сургалтанд сууж, биологийн халдвартай зүйлстэй зөв харьцаж, аюулгүй ажиллагааны журам, дүрмийг чанд мөрдөж өөрийгөө болон хамт ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана
- Цуглуулсан цус, сийвэн, эсийг хүлээн авах, шалгах, бүртгэх, чанарыг хянах
- Эмнэлгийн захиалга, нөөцийн хэмжээнд тохируулан шаардлагатай бүтээгдэхүүний нэр төрлийг сонгох
- ЦЦБ-ийг САЗ, ТТАЗ-ын дагуу үйлдвэрлэх,
- ЦЦБ-ийг зөв нөхцөлд хадгалах,
- Хорионд хадгалах, чөлөөлөх,
- Ердийн болон гамшгийн үеийн нөөц бүрдүүлж, хадгалах, эргэлтийг зохицуулах
- Үйлдвэрлэлийн процес явагдсан тухай холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн зөв хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэггэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх
- Сүлжээ системийн тогтмол ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах.
- Цусны албаны хэмжээнд хэрэглэх цусны хүүдийний нөөцийг зохицуулан хувиарлах, хэрэглээнд хяналт тавих
- Улсын хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж, цаг хугацаанд нь мэдээлэх /Төвийн, салбар төвийн, улсын түвшинд

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 25/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- ЦЦБ үйлдвэрлэл, хадгалалт тээвэрлэлтийн чиглэлээр цусны албаны эмч мэргэжилтэнд сургалт зохион байгуулах

2.2 ЦЦБ хадгалалт, олголтын нэгж

- Эмнэлгүүдээс захиалгыг хүлээн авах, эрэмбэлэх, холбогдох тасаг, эмч, мэргэжилтнүүдэд мэдээлэх,
- Үндэсний удирдамжийн дагуу бүтээгдэхүүнийг хүрэлцээтэй хэмжээгээр цаг хугацаанд нь олгох, хэрэглээг баримтжуулах,
- Олгогдоогүй бүтээгдэхүүнийг үнэн зөв, бүрэн бүртгэж, шалтгааныг тогтоон бууруулах үйл ажиллагаа зохион байгуулах,
- ЦЦБ захиалах, олгох, хүлээн авах, тээвэрлэх талаар эмнэлгүүдийг мэдээллээр хангаж ажиллах,
- Харилцагч эмнэлгүүдтэй жил бүр гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж, гэрээг бүрэн хийх, жилийн эцэст гэрээг дүгнэж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх,
- ЦЦБ-ий оновчтой сонголт зөв хэрэглээний талаар хэрэглэгч эмнэлгүүдэд зөвлөгөө өгөх,
- ЦЦБ-ний алсын тээвэрлэлтийг асуудлыг зохицуулах, тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана,
- ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн мэдээг хүлээн авч бүртгэн, холбогдох алба тасагт мэдээлж баримтжуулна,
- ЦЦБ хадгалалтын тоног төхөөрөмжийн хэмийг өдөрт 3 удаа шалган баримтжуулна. СБЦЦТ-ийн бүтээгдэхүүний хадаглалтын хэмийн хяналтыг утсаар асууж жижүүрийн мэдээнд тусгаж баримтжуулна.
- Шаардлагатай үед болон гамшиг, ЭМ-ийн ноцтой байдал үүссэн үед холбогдох тасгийн ажилчдыг дуудах,
- Гэрээт харуулуудад байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл өгөх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих,
- Сүлжээ системийн тогтмол ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах,
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах,
- ЦЦБ-ний хэрэглээний тайланг төвийн, цусны банкуудын, улсын түвшинд гарган нэгтгэж, тайлагнана. Цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж, баримтжуулна

Гурав. Нэгдсэн лабораторийн тасаг:

3.1 ЭМ-ийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага стандарт хэрэгжүүлж, байнга сайжруулах

- Тасгийн үйл явцын тодорхойлолт, шинжилгээний өмнө, шинжилгээний, шинжилгээний дараах үед мөрдөж журам, ЦЦБ-ийг хүлээн авах, бүртгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хорионд хадгалах, чөлөөлөх стандарт ажиллагааны аргачлал, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 26/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх

- Шинжилгээнд хэрэглэгдэх аппарат, тоног төхөөрөмжийн суурилуулалт, баталгаажуулалт, тохируулга, засвар үйлчилгээг графикийн дагуу зөв хийж байгаад хяналт тавьж, хэрэглэгчийн талаас хийх арчилгаа үйлчилгээг тогтмол хийж, ажилласан цагийн бүртгэлийг баримтжуулах,
- Тоног төхөөрөмжтэй зөв, аюулгүй ажилуулах, халдварын сэргийлэлт хяналтын сургалтанд сууж, биологийн халдвартай зүйлстэй зөв харьцаж, аюулгүй ажиллагааны журам, дүрмийг чанд мөрдөж өөрийгөө болон хамт ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана
- Сүлжээ системийн тогтмол ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах
- Бүх шинжилгээ хийсэн тухай холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн, зөв бүрэн хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэггэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Улсын хэмжээний лабораторийн шинжигээний тайлан мэдээг үнэн зөв гаргаж, цаг хугацаанд нь мэдээлэх /Төвийн, салбар төвийн, улсын түвшинд

3.2 Цус өгөхийн өмнө хийх шинжилгээ:

- Шинэ доноруудын цусны АВО бүлэг шууд аргаар тодорхойлох
- Цус өгөхийн өмнө гемоглобины хэмжээг чанарын болон тоон аргаар хэмжих
- Сийвэнгийн доноруудад САЗ д заасан шинжилгээг хийх
- Эсийн донорт цусны ерөнхий шинжилгээг хийх

3.1 Цуглуулсан цусны нэгж бүрд хийх шинжилгээ:

- Цуглуулсан цус, сийвэн авсан донорын сорьц бүрийг бүрэн хүлээн авч, бүртгэн, чанарыг шалган баримтжуулах.
- Цуглуулсан цусны нэгж бүрд цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх болон цусны АВО, резус, келл бүлэг тодорхойлох шинжилгээг бүрэн зөв хийж баталгаажуулах.
- Шинжилгээндээ ДЭМБ-ын цусны аюулгүй байдлыг хангах стратеги, алгоритмыг мөрдөх.
- Шинжилгээндээ чанарын баталгаатай, шаардлага хангасан оношлуурыг хэрэглэх, оношлуурыг үнэлэх ажлыг зохион байгуулах,
- Шинжилгээнд хэрэглэгдэх аппарат, тоног төхөөрөмжийн суурилуулалт, баталгаажуулалт, тохируулга, засвар үйлчилгээг графикийн дагуу зөв хийгдэж байгаад хяналт тавьж, хэрэглэгчийн зүгээс хийх арчилгаа үйлчилгээг бүрэн хийж, ашиглалтын цагийг бүрэн баримтжуулах.
- Тоног төхөөрөмжтэй зөв, аюулгүй ажилуулах, халдварын сэргийлэлт хяналтын сургалтанд сууж, биологийн халдвартай зүйлстэй зөв харьцаж,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 27/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

аюулгүй ажиллагааны журам, дүрмийг чанд мөрдөж өөрийгөө болон хамт ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана

- Цуглуулсан цус, сийвэн, эсийн нэгж бүрд АВО бүлэг урвуу аргаар тодорхойлох, резус, келл бүлэг баталгаажуулах шинжилгээг хийн хариуг тухай бүр ЦЦБ үйлдвэрлэх нэгжид илгээх
- Байнгын доноруудад дэд болон ховор бүлэг тодорхойлох шинжилгээг хийн баримтжуулж, мэдээллийн сан үүсгэх
- Шинжилгээ хийх бүрдээ дотоод хяналтыг ашиглан шинжилгээний үнэн зөвийг баталгаажуулах, баримтжуулах.
- Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт шинжилгээний төрөл бүрээр хамрагдан үйл ажиллагаагаа байнга сайжруулж ажиллах.
- Ийлдсийн санг бүрдүүлэн, баримтжуулж, хадгалах, хянах, хамгаалах.

3.3 Бүтээгдэхүүний чанарын хяналтын шинжилгээ

- Үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнд хийгдэх чанарын хяналтын шинжилгээг ЭМ-ийн сайдын тушаал, стандарт, фармокопейд заагдсаны дагуу бүрэн зөв хийх, үр дүнг БҮТ тасагт мэдээлэх, баримтжуулах

3.4 Лавлагаа шинжилгээ:

- Эмнэлгүүдийн хүсэлтээр цусны эргэлзээтэй бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээг хийн баталгаажуулах.
- Хөдөө орон нутгийн ЦСБ-ий үйлдвэрлэсэн ЦЦБ-д чанарын шинжилгээг хийх.
- Хөдөө орон нутгийн ЦСБ-наас ирүүлсэн донорын сорьцонд ЦСДХ илрүүлэх шинжилгээг хийх.
- Эмнэлгүүдээс ирүүлсэн дээжинд эсрэгбие илрүүлэх, дүйн тодорхойлох шинжилгээг хийх.
- Эмнэлгүүдээс ирсэн сорьцонд Кумбсийн шууд болон шууд бус, титр, тодорхойлох шинжилгээнүүдийг хийж баталгаажуулах.
- ЦСДХ илрүүлэх үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг ХӨСҮТ-ийн НЛА-тай хамтран зохион байгуулах
- Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, баримтжуулах
- Цусны нэгж бүрд болон цус сэлбэхийн өмнө хийх шинжилгээний талаар ЭМ-ийн байгууллагын лабораторийн эмч, ажиллагсад сургалт зохион байгуулах

Дэмжих үйл ажиллагаа:

Нэг. ЭШМТ-ын алба

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 28/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

1.1 Сургалт төслийн хэсэг

- Албаны хэмжээний мэргэжилтнүүдийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх
- Төв болон цусны албаны хэмжээнд зохиогдох сургалтын удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах
- Ажлын байран дээрх сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах, баримтжуулах
- Донорын мэдлэг олгох, сургалт сурталчилгааны сургалтыг зохион байгуулах /Нийгмийн ажилтантай хамтрах/
- Үйлчлүүлэгчид эрүүл аж төрөх, ёс, хэвшлүүлэх сургалтыг ДЗБ тасагтай хамтран зохион байгуулах
- Ажилчдын кредит цагийн биелэлтийг хангаж, баталгаажуулан ажиллах
- Үйлдвэрлэлийн трансфузиологич эмч, тусгай мэргэжилтэн, цус сэлбэлтийн сувилахуй судлалын чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах
- Төсөл хөтөлбөрийн дагуу хийгдэх сургалтыг графикийн дагуу зохион байгуулах, тайланг бичиж илгээх
- Байгууллагыг хөгжүүлэх стратегийн дагуу төсөл бичиж батлуулах, санхүүжилт олох
- Батлагдсан төслийг хэрэгжих ажлыг зохион байгуулах
- Сургалт, төслийн тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж, илгээх, баримтжуулах, мэдээлэх
- Байгууллагын номын сангийн баяжилт, үйл ажиллагааны тогтмол байдлыг хангаж ажиллах /цахим номын санг үүсгэн, ажиллуулах/
- Сургалт төслийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийн жагсаалт төсөв гарган жил бүрийн төсөвт суулгах
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Тасаг хэсгийн эд, хогшил, техник хэрэгслийг бүртгэн баримтжуулж, зөв, зохистой ашиглана.

1.2 Судалгаа, эрдэм шинжилгээ

- Трансфузиологийн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, мөрдөж ажиллах
- Судалгаа эрдэм шинжилгээний ажил хийх төсөв батлуулах, бусад төсөл хөтөлбөрөөс санхүүжилт олж авах
- Эмч мэргэжилтнүүдэд судалгаа шинжилгээний ажил хийх ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах
- Байгууллагын эрдмийн зөвлөлийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хурал зохион байгуулах
- Судалгаа шинжилгээний ажил хийн үр дүнг практикт нэвтрүүлэх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 29/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

1.3 Гадаад харилцаа:

- Олон улстай харилцаа тогтоон хамтын ажиллагаа хэрэгжүүлэх
- Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцэл байгуулах, үр дүнг тооцох
- Олон улсын хурал зөвлөгөөнд эмч, мэргэжилтнүүдийг хамруулах ажлыг зохион байгуулах
- Эмч, мэргэжилтнүүдийг гадаадад урт богино хугацаагаар сургах ажлыг зохион байгуулах
- Мэдээллийн олон сувгаар трансфузиологийн талаар мэдээлэл авч, эмч мэргэжилтнүүдэд түгээх, баримтжуулах

1.4 Мэдээллийн технологи:

- Мэдээллийн технологи, сүлжээ системийн тогтмол хэвийн жигд үйл ажиллагаа хангах,
- Цахим сүлжээний нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах
- Албаны болон төвийн сүлжээ системийн мэдээллийг хатуу дискэнд тогтмол давтамжаар хуулж, архивлах, аюулгүй байдлыг хангах
- Эмч, мэргэжилтнүүдийг цахим сүлжээ систем ашиглахад сургаж, ур чадвар эзэмшүүлнэ.
- Программ хангамж зохиосон, үйлчилгээ хийдэг байгууллагатай хамтран ажиллах, кпрограмм хангамжийг шинэчлэн байна сайжруулах,
- Мэдээллийн тоног төхөөрөмжийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, баримтжуулна
- Мэдээллийн технологийн хэрэгсэлд тогтмол үзлэг хийн үйлчилгээ, завсар хийнэ.
- Орон нутгийн цусны салбар төвийн эмч мэргэжилэнд цахим сүлжээ ашиглах талаар мэргэжил арга зүйгээр ханаж ажиллана

1.5 Бусад

- 2 Албаны үйл явцын тодорхойлолт мэргэжил олгох, дээшлүүлэх, ажлын байран дээрхи болон төвийн бренд сургалт зохион байгуулах, төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа цахим сүлжээ, мэдээллийн технологи, судалгаа эрдэм шинжилгээний ажил эрхлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холобоотой журам, стандарт ажиллагааны аргачлал, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
- 3 Сүлжээ системийн тогтмол ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах
- 4 Бүх үйл ажиллагааны х мэдээ тайлан, холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн, зөв бүрэн хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэгэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх
- 5 Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- 6 Улсын хэмжээний сургалт, цахим сүлжээ, судалгааны ажлын тайлан мэдээг үнэн зөв гаргаж, цаг хугацаанд нь мэдээлэх /Төвийн, салбар төвийн, улсын түвшинд/

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 30/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Хоёр. Захиргаа, маркетингийн алба:

2.1 Стратеги төлөвлөлт, хөгжлийн хөтөлбөр

- Стратеги болон байгууллага хөгжүүлэх бодлого, зорилт, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтыг жил бүр гаргаж тайлагнах
- Стратеги болон байгууллага хөгжүүлэх төлөвлөлтөнд дунд хугацааны үнэлгээг хийн тодотгол хийх
- Бодит байдлын үнэлгээ шинжилгээ /гадаад, дотоод харилцаа, давуу, сул, боломж, эрсдэл/хийн хэрэгцээг гаргаж ирэх
- Байгууллага, албаны стратегийн болон байгууллага хөгжүүлэхэд шаардагдах төсвийн төслийг боловсруулан удирдлагад хүргэх
- Үйл ажиллагааны өртөг зардлыг тооцох, эдийн засгийн судалгаа хийх
- Албаны хэмжээнд хэрэгжих дүрэм, журам боловсруулах, биелэлтэнд хяналт тавьж, тайлагнах
- Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг тайлагнах
- Удирдах байгууллагад илгээх тайлан мэдээг нэгтгэх, хянаж, цаг хугацаанд нь илгээх

2.2. Статистик эдийн засаг:

- Төвийн үндсэн үйл ажиллагааны тайланг ЭМХТ-д хүргүүлж үнэлгээг тогтмол хийлгэнэ.
- Албаны үйл ажиллагааны статистик мэдээг тогтмол /сар, улирал, хагас бүтэн жилээр/ гарган дүн шинжилгээ хийн удирдлагын зөвлөлд танилцуулах, удирдлагыг мэдээллээр хангах /Төвийн, цусны салбар банкны, улсын түвшинд/
- Үйл ажиллагааны эдийн засаг судалгаа шинжилгээ хийх, бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг тооцох

2.3. Хүний нөөц:

- Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох
- Төвийн ажлын байр бүр дээр албан тушаалын тодорхойлолт боловсруулах
- Эмч, мэргэжилтэн ажиллагсдыг сонгон шалгаруулах
- Баримжаа олгох сургалтанд хамруулах
- Төвийн ажиллагсдын хувийн хэрэг бүрдүүлэх, баяжуулах, нууцлалыг хадгалах

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 31/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Төвийн ажиллагсдыг хөгжүүлэх, ур чадварыг сайжруулах, хадгалах хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Эмч, ажиллагсдыг нийгмийн асуудлыг сайжруулах, урамшуулах, гавъяа шагналд тодорхойлох

2.4 Маркетингийн нэгж

- Хүн амын дунд цусны донорын сургалт сурталчилгааг хийх ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
- Цусны донорын сургалт, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах, баримтжуулах
- Цусны донорын тухай сургалт хийх хөтөлбөр төлөвлөгөө, сургалтын материал боловсруулах
- Донорын сурталчилгааны материал боловсруулах, хийлгэх, түгээх
- Эрүүл аж төрөх ёс, дадал хэвшүүлэх зөвлөгөө, сургалт, сурталчилгааг үйлчлүүлэгчид хийх, баримтжуулах
- Явуулын цус цуглуулах төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, биелэлтийг гаргах, дүгнэх
- Донор элсүүлэх сайн дурын ажилтанг бэлтгэн, хамтран ажиллах
- Цус цуглуулах албан газруудад угтуулан сургалт, сурталчилгааг хийн шаардлага хангасан доноруудыг цус цуглуулах үйл ажиллагаанд хамруулах
- Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах, дүгнэх, үр дүнг тайлагнах
- Үйл ажиллагааны тайланг хугацаанд нь үнэн зөв, баримтжуулалттай гаргаж өгөх
- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Хүмүүнлэгийн үйлс, доноруудыг алдаршуулах, урамшуулах ажил зохион байгуулах
- Цусны донорын үйлсийг сурталчлах, донорын эгнээг өргөжүүлэх, донор хадгалах талаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах /гэрээ, санамж бичиг байгуулах, дүгнэх/
- МУЗН, Дүүргийн Дунд шатны хороодтой хамтран ажиллах, тэдний үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх

2.5 Бусад :

- Албаны үйл явцын тодорхойлолт, үйл ажиллагаанд шаардлагатай САЗ, ТТАЗ, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
- Бүх үйл ажиллагааны х мэдээ тайлан, холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн, зөв бүрэн хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэгэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 32/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Төвийн хөгжлийн хөтөлбөр, стратеги, жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг тогтмол нэгтгэж холобгдох газруудад илгээнэ.

Гурав. Санхүү бүртгэлийн алба:

Санхүү нягтлөн бодох:

- Санхүү, нягтлан бодох, бүртгэлийн хууль, журам, зааврын дагуу үйл ажиллагаа явуулна.
- Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай төсөвийн төсөл боловсруулан хянаж, холобгдох газар хэлтсүүдээр хэлэлцүүлж хамгаалж батлуулна.
- Төсвийн хувиарлалт хийж, зөв жигд үарцуулж зарцуулалтанд тогтмол хяналт тавьж ажиллан
- Санхүүгийн аудитад тогтмол хамраглаж зөвөлмжийг хэрэгжүүлж ажиллах

Хангамж үйчилгээний нэгж

1. Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай бүх зүйлсийн бэлэн байдал, нөөц, чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллана
2. Тендер болон гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа материалын чанар, тоо хэмжээг шалгаж хүлээн авч баримтжуулна
3. Үйл ажиллагаандаа нярав, санхүүгийн бүртгэл тооцоог бүрэн, зөв хөтөлж ажиллана
4. Эд хөрөнгө, хүнсний бүтээгдэхүүн, бэлэн мөнгөний аюулгүй байдлыг хангаж, хадгалалтын нөхцөлийг хянаж, эд хариуцагчийн хариуцлага хүлээж ажиллана.
5. Тайлан тооцоог тогтоосон хугацаанд хийн нягтлантай тооцоо нийлж, өр, авлагагүй ажиллах
6. Эд аж ахуй, урвалж, бодис, хүүдий бусад хэрэгслийн агуулахыг зөв зохион байгуулж, эрсдэлээс сэргийлж ажиллах
7. Ханган нийлүүлэгч байгууллагуудтай гэрээний дагуу чанартай зөв бараа бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь авах
8. Бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтыг зөв зохион байгуулна
9. Үйл ажиллагааны орлого, зарцуулалтын тайлан мэдээг цаг хугацаанд үнэг зөв гарган баримтжуулж, мэдээлэх, санхүүтэй тооцоо нийлнэ.

Бусад :

- Албаны үйл явцын тодорхойлолт, үйл ажиллагаанд шаардлагатай журам, САЗ, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
- Бүх үйл ажиллагааны х мэдээ тайлан, холбогдох баримтжуулалтыг тухай бүр үнэн, зөв бүрэн хөтөлж, 7 хоног, сар, улирлаар нэгэн дүгнэж, цаасан болон цахим архив үүсгэн хадгалах, мөшгөн тогтоох боломж бүрдүүлэх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 33/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт авч нэгтгэн дүгнэн, захиргаагаар хэлэлцүүлэн засч сайжруулж ажиллах
- Төвийн санхүү нягтлан бүртгэлийн ажилтай холбоотой хөгжлийн хөтөлбөр, стратеги, жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг тогтмол нэгтгэж холбогдох газруудад илгээж баримтжуулсан байна.

Дөрөв. Цусны чанар, аюулгүй байдлын алба:

- Чанарын бодлого, зорилтыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжин туслах
- Дотоод, гадаад аудит хийлгэн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана
- Төвийн эмч ажиллагсдад чанарын сургалт тогтмол зохион байгуулна.
- Чанарын гарын авлага боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжин тусална.
- Баримт бичгийн хяналт хийгдэж байгаад үнэлгээ хийн үр дүнг тооцно. Баримт бичгийн нэгдсэн жагсаалтыг нэгтгэн, шинэчлэнэ, боловсруулсан баримт бичгийг хянаж зөвшөөрөл олгоно.
- Сэтгэл ханамжийн судалгааны дүнтэй танилцаж, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжин ажиллана.
- Алдаа, эрсдэл, үл тохирлын дүнтэй танилцаж, засч, сайжруулах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд дэмжин тусалж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- Төвийн магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан зохион байгуулна. жил бүр хэрэгжилтийн тайланг ЭМХТ-д хүргүүлж, хамт олонд мэдээлнэ.
- Төвийн үйл ажиллагаанд үндэсний болон Олон улсын стандартыг нэвтрүүлж, үр дүнг тооцох.

Халдварын Сэргийлэлт Хяналтын тогтолцоо:

- Төвийн үйл ажиллагаанд халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог нэвтрүүлж байнга сайжруулж ажиллана
- ХСХ чиглэлээр журам заавар боловсруулж, шаардлагатай шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр хийн, нийт эмч ажиллагсдад сургалт зохион байгуулж, мэдлэг олгон, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана
- Эмч ажиллагсдын эрүүл мэнд, халдварын эрсдэл, ажлын орчинд жил бүр үнэлгээ хийж судалгаа дүгнэлт гарган ажиллана
- ХСХ тогтолцооны хэрэгжилт, халдвар, өртөлтийн бүртгэл судлагааг тогтмол нэгтгэн үр дүнг холбогдох газруудад мэдээлж баримтжуулна.
- Төийн эмч ажиллагсдын ХХХ, халдваргүйжүүлэх, ариутгалын тендерийн материал боловсруулалт, ханган нийлүүлэлт, зарцуулалтанд тогтмол хяналт тавьж мэдээ тайланг тухай бүр илгээж баримтжуулна
- Хог хаягдлын тогтолцоо хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хамтран ажиллах газруудтай гэрээ байгуулан хэрэгжилтэнд дүгнэлт хийн энгийн болон аюултай

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 34/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

хог хаягдлын ялган ангилалт, бүртгэл, хадгалалт, тээвэрлэлтийн тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж баримтжуулна.

- Эмч ажиллагсдыг дархлаажуулалтанд хамруулах баримтжуулах ажлыг хариуцана

Тав. Инженер техникийн тасаг:

4.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж, аюулгүй байдал:

- Тасгийн үйл явцын тодорхойлолт, үйл ажиллагаанд шаардлагатай стандарт ажиллагааны аргачлал, ажлын заавар, хяналтын хуудсуудыг боловсруулан, ажилчдыг сургаж, мөрдүүлэх, тогтмол хянаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх
 - Засвар үйлчилгээний болон ханган нийлүүлэгч компаниудтай гэрээ байгуулж, жил бүр дүгнэн үр дүнг тооцож ажиллах.
 - Төвийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн сан үүсгэн, жил бүр шинэчлэл хийх.
 - Тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаанд хяналт тавих /паспорт хөтлөлт/.
 - Тоног төхөөрөмж ажиллуулах зааврыг аппарат, хэрэгсэл бүр дээр гаргаж, ажилтнуудыг сургаж, хэрэгжилтэнд хяналт тавих /Ханган нийлүүлэгч компанитай хамтран ажиллах/.
 - Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны сургалтыг тасаг нэгж бүрд зохион байгуулж, баримтжуулах /мэргэжлийн инженер, техникчтэй хамтрах/.
 - Тоног төхөөрөмжинд хийгдэх үнэлгээ, тохируулга, баталгаажуулалтыг хугацаанд нь тогтмол хийж, баримтжуулах.
 - Эвдрэл гэмтэл гарсан үед холбогдох чиглэлийн мэргэжилтэн, инженер техникийн ажилтанг дуудаж засуулах, баримтжуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэх.
 - Тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийхэд холбогдох тасаг нэгжийн эрхлэгч, ахлагчид мэдэгдэн, эмч, мэргэжилтэнг байлцуулах.
 - Завсар үйлчилгээ хийсэн тохиолдол бүрт баримтжуулалт сайн хийх, санхүүжилтийг нягтлан, няравуудтай тооцоо нийлэх.
 - Эмнэлгийн тоног төхөөрөмж, туслах үйл ажиллагаатай холбоотой тайланг ЦССҮТ, ЦСТ, улсын хэмжээнд тогтмол гаргаж үнэлж, удирдлагын зөвлөлд мэдээлж ажиллана.

4.2 Туслах ажил:

- Төвийн гадаад орчны болон дотоод цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанарын өндөр түвшинд хийх
- Байгууллагын барилга, байшин, автомашин, аппарат, тоног төхөөрөмж, эд хогшлын бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 35/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Тасаг хэсгийн эд, хогшил, техник хэрэгслийг бүртгэн баримтжуулж, зөв, зохистой ашиглана.
- Төвийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах, сэргийлэх, гал гарсан үед яаралтай арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах
- Харуул хамгаалалт, дохиоллын системийн тогтвортой аюулгүй ажиллагааг хангах
- Цахилгаан тасарсан үед нөөц үүсгүүрүүдийн ажиллагааны бэлэн байдлыг тогтмол хангаж, шаардлагатай үед ажиллуулж, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн хадгалалт, шинжилгээний тасралтгүй байдлыг хангах заавар боловсруулан, холбогдох ажилтнуудыг сургаж, дадлагажуулан мөрдөж ажиллах
- Төвийн автомашины бүрэн бүтэн байдал, завсар, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.4.1. с)

Төвийн үйл явцын шалгуур үзүүлэлт:

1. Тухайн жилийн цус өгөлтийн тоо, өсөлт
2. Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлт, нэр төрлөөр /нэгжээр/
3. Цус цусан бүтээгдэхүүний хангалтын хувь /нэгжээр/
4. Тайван, онцгой байдлын үеийн нөөцийн бүрдүүлэлтийн хэмжээ /нэгжээр/
5. Эрсдлээс сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилт

Хавсралт 13. Төвийн чанарын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт улирал, хагас, бүтэн жилээр

Алба, тасгуудын чанарын зорилт, шалгуур үзүүлэлт:

Төвийн алба тасаг бүр төвийн чанарын болон ХЭМАБ-ын тогтолцооны зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүр дүгнэж, байнга сайжруулж ажиллана.

Үйл явц, ажиллагааг хянах

- а) ЭМ-ийн сайд, төвийн захирлын тушаалаар байгуулсан алба, тасаг, төвийн захирлын тушаалаар байгуулсан орон тооны бус алба, баг, комисс хүлээсэн үүргээ бүрэн биелүүлнэ. Албаны дарга, тасгийн эрхлэгч өөрийн алба, тасгийн үйл явцын тодорхойлолт боловсруулж, хэрэгжүүлэн үйл явцын гаралтыг шалгуур үзүүлэлтийн дагуу сар, улирал, хагас, бүтэн жилээр үнэлэн, үр дүнг

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 36/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

нийт ажиллагсдад болон удирдлагын зөвлөлд мэдээлж ажиллана. Эмч, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан байна.

- b) Албаны дарга, тасгийн эрхлэгч, баг комиссын ахлагч, дарга нар хэрэгжүүлсэн үйл явц, ажиллагааны биелэлтийг сар, улирал бүр гарган удирдлагын зөвлөлд мэдээлнэ.
- c) Хагас бүтэн жилээр алба, тасаг, баг, комиссын үйл явцын хэрэгжилт, ололт амжилт, асуудал, бэрхшээл, тэдгээрийг даван туулах гарц, сайжруулах саналыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.
- d) Шаардлагатай өөрчлөлт сайжруулалт хийх асуудлыг төвийн удирдлагын дүн шинжилгээгээр хэлэлцэн ерөнхий захирал эцсийн шийдвэрийг гаргана.

4.4.1. d)

Шаардагдах нөөц:

ЦССҮТ-ийн үйл явц, ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах нөөц шаардагдана.

Нэг. Хууль эрх зүйн зохицуулга

- 1. ДЭМБ-ын зөвлөмж, санамж бичиг, удирдамж, заавар
- 2. Донорын тухай хууль 2000, 2012, 2018
- 3. ЭМ-ийн тухай хууль
- 4. ЭМ-ийн тусламжийн тухай хууль
- 5. ЭМ-ийн сайдын 2020 оны 373, 445, 2017 оны 3 тоот болон бусад тушаалуудын холбогдох заалт
- 6. Төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6647: 2017

Хоёр. Хүний нөөц:

- 1. Мэргэшсэн, чадварлаг
- 2. Багаар ажиллах чадвартай
- 3. Хөрвөх чадвартай
- 4. Шудрага, зарчимч, үнэнч сэтгэлтэй

Гурав. Санхүүгийн нөөц

- 1. Үйл ажиллагаанд хүрэлцээтэй
- 2. Тогтвортой төсөв хуваарилалт

Дөрөв. Салбар дундын хамтын ажиллагаа

- 1. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ
- 2. Хэвлэл олон нийтийн хэрэгслээр сурталчлах, уриалах

Тав. Тоног төхөөрөмж, оношлуур, дагалдах хэрэгсэл

- 1. Үнэлэгдэж, баталгаажсан

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 37/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

2. Үйлчилгээ, тохируулга хийгдсэн
3. Аюулгүй
4. Хүрэлцээтэй, нөөцтэй

4.4.1. е)

Төвийн алба, тасаг ЭМ-ийн сайдын болон төвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдаж, орон тооны болон орон тооны бус алба, тасаг, баг, комиссын үйл ажиллагааг хэвийн жигд явуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилт, биелэлтийг 7 хоног, сард шуурхай зөвлөгөөн дээр, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагын зөвлөл болон ерөнхий захирал, бичиг хэргийн ажилтанд тайлагнаж ажиллана.

4.4.1. F)

Гадаад орчны боломж:

1.1 Эдийн засгийн орчин

- АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ЭМСХХ-5 төсөл хэрэгжсэн барилга, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж тавилга, технологийн иж бүрэн шинэчлэл хийж байгаа
- МУЗН-ийн донорын хөтөлбөрт донорын сургалт, сурталчилгаанд зарцуулах зардлын тодорхой хувийг ЭМ-ийг дэмжих сангаас санхүүжүүлдэг болсон

1.2 Техник, технологийн орчин

- Олон нийтийн дунд цахим мэдээллийн сүлжээний хэрэглээ нэмэгдэж байгаа
- Сошиал хэлбэрийг ашиглан зардал багатай сургалт сурталчилгаа явуулах боломжтой
- Мэдээ мэдээллийг улсын хэмжээнд түргэн шуурхай солилцох боломж бүрдэж байна

1.3 Улс төрийн орчин

- Монгол улсын Цусны албыг хөгжүүлэхэд анхаарч төрийн бодлогоор дэмжиж ирсэн

1.4 Хууль эрх зүйн орчин

- Донорын тухай хууль
- Улсын нөөцийн тухай хууль
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журам батлагдсаж үйл ажиллагаа явуулах эрх зүйн таатай орчин бүрдсэн

Цусны аюулгүй байдлын талаар баримтлах ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлдэг

1.5 Нийгэм соёлын хүчин зүйл

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.04.12- .2021.06.11.	Хуудас 38/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Хүн амын дунд эрүүл амьдрах хэв маяг, зөв хооллолтын талаар мэдлэг, хандлага сайжирч байгаа
- Сайн үйлсэд нэгдэх, тэмдэглэлт өдрүүдэд ач холбогдол өгөх зэрэг зөв хандлага нэмэгдэж байгаа нь донорын эгнээг өргөжүүлэх, донор сонголтонд сайнаар нөлөөлөх боломжтой

Аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагаа ухамсарлах, энэ хүрээнд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлдэг болсон

1.7 Хэрэглэгч, түншлэгч

- Донорын тоо, ЦЦБ хэрэглэх эмнэлгүүдийн тоо жил бүр нэмэгдэж байна
- Донор зохион байгуулагч байгууллага болон хандивлагч, хамтран ажиллагч байгууллагын тоо өсөн нэмэгдэж байгаа
- Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн цусны бүлгийг үздэг болсноор үйлчлүүлэгч болон хамтран ажилладаг байгууллагын тоо нэмэгдэх боломжтой
- Эрүүл мэндийн салбарт дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулагдах сургалтын тоо нэмэгдэж байна

Эрсдэл

1.1 Эдийн засгийн орчин

- Улс орны эдийн засгийн чадавх сул төсвийн санхүүжилт хязгаарлагдмал, шаардлагатай хэмжээгээр нэмэгддэггүй
- Эм эмнэлгийн хэрэгсэл, уут хүүдий оношлуурын үнэ өндөр, инфляцийн өсөлттэй холбоотой үнэ хэлбэлзэх
- МУЗН-д донорын сургалт сурталчилгаа явуулах санхүүжилт маш бага
- ЦЦБ-ний тээвэрлэх дэд бүтэц муу хөгжсөн
- Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин, урамшууллын хэмжээ бага

1.2 Техник, технологийн орчин

- Төсвөөс шалтгаалан нэвтрүүлсэн шинэ технологитой уялдсан хүрэлцээтэй зардал, санхүүжилт шийдвэрлэгдэхгүй
- Шинэээр үйлдвэрлэж байгаа цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэх эмнэлгийн төсөв санхүүжилт хязгаарлагдмал

1.4 Улс төрийн орчин

- Улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан хүний нөөцийн тогтвор суурьшил алдагдах
- ЭМЯ-ны бүтэц, хүний нөөц өөрчлөгддөг

1.5 Хууль эрх зүйн орчин

- Үндэсний стандартыг шинэчлэхэл шат дамжлага олон, хугацаа их шаарддаг

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 39/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- ЭМЯ-ны тушаал шийдвэр уян хатан биш удаан өөрчлөгддөг

1.6 Нийгэм соёлын хүчин зүйл

- Цус сэлбэлтийн талаарх эмч, мэргэжилтний мэдлэг хандлага өөрчлөхөд хугацаа шаардана, шинэ бүтээгдэхүүн хэрэглэх, уламжлалт сэтгэлгээний өөрчлөлт удаан
- Халдварт болон халдварт бус өвчлөлийн тоо нэмэгдсээр байна
- Цусны донор болон иргэн бүр цусаа тогтмол хугацаанд өгөх талаар хүн амын дунд буруу мэдлэг, мэдээлэл тархсан
- ДОХ-ын тохиолдлын тоо нэмэгдэж байгаа
- Монгол орны байгаль цаг агаарын нөхцлийн нөлөөлөл

1.7 Хэрэглэгч, түншлэгч

- Төрийн болон аж ахуй нэгж байгууллага, салбар дундын хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй
- Байгууллага, хамт олны цусны донорын хөдөлгөөнийг дэмжих, тогтмол оролцох үүрэг, харицлага жигд биш
- Хүн амын эрүүл мэндийн боловсрол хангалтгүй
- Эмнэлгийн цусны нөөцийн эмч, сувилагч, эмч нарын зохистой хэрэглээний мэдлэг хангалтгүйгээс зохистой хэрэглээ хэвшээгүй.
- Өвчлөлийн бүтэц өөрчлөгдсөн, дотооддоо эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо нэмэгдэж байгаа зэрэгтэй холбоотой ЦЦБ-ний хэрэглээ өсч байна.

1.8 Халдварт өвчин

- Хүн амын дундах халдварт өвчний тархалт, цар тахал
- Хөл хорионы дэглэм тогтоож донорууд цусаа өгөх тоо цөөрөх
- ЦЦБ-ий нөөц хангамж буурах
- Эмч, ажиллагсад, үйлчүүлэгч халдварт өртөх эрсдэл учрах

4.4.1.h)

Төвийн удирдлага үйл явцыг сайжруулах шаардлага гарвал холбогдох өөрчлөлт, шинэчлэлтийг хийн тушаалаар баталгаажуулна. Мөн алба, тасгууд холбогдох журам, заавруудад өөрчлөлт хийн тухай бүр шинэчлэн батлуулж, мэдээллийг шуурхай дамжуулан, сургалт зохион байгуулан мөрдөж ажиллана.

Төвийн үйл ажиллагааны явц, ололттой болон асуудалтай байдлыг 7 хоног бүр эмч, мэргэжилтнүүдийн шуурхай зөвлөгөөн дээр хэлэлцэж, төвийн захирал шийдвэр гаргаж, үүрэг өгч, хэрэгжилтийг үнэлж ажиллана.

Сар бүр үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн статистик мэдээллийг хэлэлцэнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 40/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гадаад болон дотоод аудит, хяналт үнэлгээний дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж, шийдвэрийг хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллана.

4.4.2 ЦССҮТ нь дараах мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a) Төвийн алба, тасаг, нэгжүүд холбогдох үйл явц, ажиллагааны шат дамжлага бүрд ажиллах хүний нөөцийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хувиарлалт, үйл ажиллагаанд мөрдөх стандарт ажиллагааны, тоног төхөөрөмж ажиллуулах зааврыг боловсруулж, мөрдөж ажиллана.
Төвийн алба тасгууд өөрийн үйл ажиллагаанд мөрдөх үйл явцын тодорхойлолт, журам, АТТ, САЗ, ТТАЗ-ын мастер листийг боловсруулж, батлуулан мөрдөж ажиллана. Алба, тасгийн нийт эмч, ажиллагсад холбогдох баримт бичгүүдийг судлаж, хаана хэзээ хэрэглэх мэдлэгтэй, мөрдөж ажилладаг байна.
- b) Төвийн алба, тасаг, нэгжүүд үйл явц төлөвлөсний дагуу явагдаж байгааг нотлох баримтжуулалт хөтөлж хадгална. Үүнд:
 1. Алба тасаг бүр САЗ, ТТАЗ-д ямар үйл ажиллагааг ямар маягт дээр ямар хэлбэрээр баримтжуулахыг тодорхой зааж өгнө. Үүний дагуу үйл ажиллагаа хийсэн тухай бүр бүрэн баримтжуулна. Хариуцсан эмч, мэргэжилтэн хяналт тавьж ажиллана. Хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ. Баримт бичгийн 4-р түвшний маягтуудыг цаасан болон цахим хэлбэрээр хөтөлж, хадгална. Төвийн хэмжээнд мөрдөх 4-р түвшний маягтын жагсаалтыг баримт бичгийн нэгдсэн жагсалтын дагуу захирал баталсан байна. Цусны албаны үйл ажиллагаанд мөрдөх стандарт маягтуудыг ЭМ-ийн сайдын тушаалаар батлуулан улсын хэмжээнд мөрдөнө. /2019 оны 611 тоот/
 2. Төвийн стратеги төлөвлөгөө, жил бүрийн хэрэгжилтийг гарган архивм хадгална
 3. Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган архивт хадгална
 4. Төвийн тоон үзүүлэлтийн статистик тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган архивт хадгална.
 5. Төвийн үйл ажиллагаа, санхүүгийн аудитын тайлан, зөвлөмж хэрэгжүүлсэн тайланг хагас бүтэн жилээр гаргаж хадгална.
 6. Алдаа, эрсдэлийн бүртгэл, шалтгаан, засч, сэргийлэх талаар хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж архивт хадгална
 7. Сэтгэл ханамжийн судалгаа, үйлчлүүлэгч, ажилчдын санал хүсэлтийн дүн, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хагас, бүтэн жилээр гаргаж хадгална.

5. Манлайлал

5.1 Манлайлал ба амлалт

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 41/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

5.1.1 Ерөнхий зүйл

Төвийн дээд удирдлага ерөнхий захирал, удирдлагын зөвлөлийн гишүүд, орон тооны бус албаны чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлэн манлайлж ажиллана. Үүнд:

- a) Төвийн үйл явц, ажилбарт тохирсон чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог хэрэгжүүлж, үр нөлөөтэй байдлыг ханган, тогтмол үнэлж, байнга сайжруулах хариуцлага хүлээнэ. Чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцооны хэрэгжилт, үр дүнг ЭМЯ-д мэдээлж ажиллана;
- b) Төвийн төлөв байдал, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн чиглэлтэй уялдсан чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны бодлого, зорилтуудыг тодорхойлон хэлэлцэн зөвшилцөж, ерөнхий захирал батална;
- c) Тусламж, үйлчилгээний чанар, эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоог хэрэгжүүлэх орон тооны бус алба, багийг байгуулж, үйл ажиллагааг дэмжих;
- d) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны шаардлагыг төвийн үндсэн болон дэмжих үйл ажиллагааны тодорхойлолтонд нийцүүлэн нэгтгэж өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжих нөхцөлөөр хангана;
- e) Эрсдалд суурилсан сэтгэлгээг дэмжинэ. Эрсдлийн баг байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. Төвийн үйл явц, алба, тасгийн үйл явцыг тодорхойлон уялдуулах, учирч болох эрсдэлийг үнэлэн бууруулах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- f) Төвийн үйл ажиллагаанд чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн, хүний нөөцийн болон бусад нөөцийг тодорхойлж, бэлэн байлгана;
- g) Төвийн нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсдад чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны шаардлагад бүх үйл ажиллагааг нийцүүлэх ач холбогдлыг ойлгуулсан байна, эдгээр үйл ажиллагаанд ажилтнуудыг оролцуулах, зөвлөлдөх үйл явцыг бий болгож, хэрэгжилтийг хангах;
- h) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоо төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Учирч болох эрсдэл, гамшиг, гэмтэл, эрүүл мэндийн хохирлыг урьдчилан тооцоолж, сэргийлэх ба эрүүл, аюулгүй ажлын байр болон үйл ажиллагааг хангах үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Цахилгаан тасарсан үед үндсэн үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гамшгийн төлөвлөгөөг боловсруулж, гамшиг тохиолдсон үед ажилтан бүр юу хийхийг тодорхойлсон журам баталж, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- i) Төвийн үйл ажиллагаанд чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоо хэрэгжиж, үр нөлөөтэй байлгахын тулд бүх ажилтнуудын оролцоог ханган, чиглүүлж, дэмжлэг үзүүлж ажиллана. Албаны дарга, тасгийн эрхлэгч нар өөрийн ажилтан бүрд ЧМ, ХЭМАБ-ын тогтолцоо хэрэгжүүлэхэд оролцох хувь нэмрийг ойлгуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана;
- j) Ажилтныг аюултай тохиолдол, аюул, эрсдэл, боломжуудыг мэдээлэх явцад буруутгахаас хамгаалах;

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 42/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- к) Төвийн үйл явц, ажилбарыг сайжруулах санал, сайжруулалтын үр дүнг алба, тасаг сар, улирал бүр хамт олноор хэлэлцэн тодорхойлж, удирдлагад мэдээлнэ. Удирдлагын зөвлөл сайжруулалтыг үнэлж, урамшуулж ажиллана;
- л) Бусад удирдах чиг үүргийг бүх талаар дэмжин манлайлж ажиллана.

Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч, эмч, мэргэжилтэн, ажиллагсад бүр хариуцсан ажил дээрээ манлайлал үзүүлнэ.

Энэ нь хариуцсан үүрэгт ажлаа зөв, заавар, журмын дагуу хийн, үр дүнг бүртгэн баримтжуулж, эмч, эрхлэгч, албаны дарга, захиралд мэдээлэх, ямар нэг асуудал гарвал нэн даруй мэдээлж, шуурхай арга хэмжээг төгс хэрэгжүүлэх зэргээр илэрнэ. Сайн туршлага, мэдлэгээ бусдад түгээж, үлгэр дууриал үзүүлж ажиллахыг хэлнэ.

5.1.2 Хэрэглэгчид төвлөрөх

Төвийн Ерөнхий захирал, удирдлагын зөвлөлийн гишүүд үйлчлүүлэгч болох цусны донор, эмчлүүлэгч, лавлагаа лабораторийн тусламж, үйлчилгээ авч байгаа ард иргэдийг дээдэлсэн, хэрэглэгчид төвлөрөх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Төвийн үйлчлүүлэгч, хэрэглэгчийн, холбогдох хууль, дүрэм журам, заавраар зохицуулсан шаардлагыг тодорхойлж, үйлчлүүлэгч, эмч, мэргэжилтэн, ажиллагсад мэдээлж, ойлгуулж, шаардлагыг тогтвортой мөрдөж ажиллана. Цусны донорын эрх, үүрэг, ЦЦБ хэрэглэгч улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн эрх, үүрэг, лавлагаа лабораториор үйлчлүүлж байгаа иргэд, байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, төвийн цахим болон мэдээллийн самбарт байрлуулж, эмч, ажиллагсад хэрэгжүүлэн мөрдөж байгаад албаны дарга, тасгийн эрхлэгч нар хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана;
- б) Төвийн үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлж буй тусламж, үйлчилгээ нь холбогдох стандарт, дүрэм, журам зааварт нийцэж, тохирсон байна. Цусны донор сонгох шалгуур, ЦЦБ–д тавигдах өвөрмөц үзүүлэлтийг ЭМ-ийн сайдын 2019 оны 373 тоот тушаалын хавсралт, үндэсний фармокопейд тодорхойлж баталгаажуулсан. Сайдын тушаалд заагдсан давтамжаар цусан бүтээгдэхүүнд чанарын хяналтын шинжилгээг хийж баримтжуулалт хөтөлнө.

Алба, тасгууд үйл ажиллагаа хэвийн, зөв явагдахад учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд нөлөөлөх эрсдэл болон боломжуудыг тодорхойлон, үйл ажиллагааны төлвөлгөөнд тусган хэрэгжүүлнэ;

- с) Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарч, манлайлах үүргээ цаг ямагт биелүүлнэ. Алба тасаг бүр гадаад болон дотоод үйлчлүүлэгчээс санал

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 43/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

хүсэлтийг тогтмол цуглуулж, нэгтгэн, хамт олноороо хэлэлцэнтүүний дагуу засах, сайжруулах ажлыг хэрэгжүүлж ажиллана. Зарим тогтолцоотой холбоотой томоохон асуудлыг удирдлагын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ. Төвийн хүний нөөцийн ажилтан ажиллагсдаас, алба, тасаг бүр өөрийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, санал, хүсэлтийг бүх хэлбэрээр авч, нэгтгэн дүгнэж, сайжруулах саналын хамт удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж, шийдвэрийг хэрэгжүүлэн үр дүнг тооцож, илтгэж ажиллана.

5.2 Бодлого

5.2.1 Чанарын болон ХЭМАБ-ын бодлого боловсруулах

ЦССҮТ-ийн Ерөнхий захирал нь:

- a) Төвийн алсын хараа, эрхэм зорилго, төлөв байдалд тохирсон, стратегийн чиглэлийг дэмжсэн,
- b) Чанарын болон ХЭМАБ-ын зорилтыг тогтоох үндэслэл, боломжийг хангасан, төвийн алба, тасаг бүгд хамрагдсан байх,
- c) Хууль, дүрэм, тушаал, заавруудын шаардлагыг биелүүлэх үүргийг тусгасан, Олон улсын үндэсний стандартын болон үйл ажиллагаанд холбогдох тушаал, заавруудыг мөрдөх, Эмч, ажилчдын ажлын байрны тодорхойлолтонд тусган ажилтан бүрийн оролцоог дэмжих
- d) Аюулыг арилгах, эрсдлийг бууруулах үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажлын аюулгүй, эрүүл нөхцөлөөр хангах,
- e) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог тасралтгүй сайжруулах үүрэг бүхий чанарын болон ХЭМАБ-ын бодлогыг бий болгож, хэрэгжүүлж, мөрдөнө.

ЦССҮТ-ийн чанарын болон ХЭМАБ-ын бодлогыг төвийн эмч, мэргэжилтнүүд, удирдлагын зөвлөл хэлэлцэн дараах байдлаар томьёоллоо.

ББ- ДУ- 1- 04 – 02

Чанар, ХЭМАБ-ын бодлого

Үйлчлүүлэгч, ажиллагсдад ээлтэй орчинг бүрдүүлэн, чанарын болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог байнга сайжруулахад оршино.

5.2.2 Чанарын болон ХЭМАБ-ын бодлогыг мэдээлэх

Төвийн чанарын болон ХЭМАБ-ын бодлогыг дараах байдлаар төвийн эмч, мэргэжилтнүүд, сохирхогч талуудад мэдээлсэн байна. Үүнд:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 44/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- a) Чанарын болон ХЭМАБ-ын бодлогыг төвийн ерөнхий захирлаар батлуулж, баталгаажуулна. Төвийн суурин бүх цэгүүдийн алба, тасаг нэгж бүрд цаасан болон цахим хэлбэрээр хүртээмжтэй байдлаар түгээнэ.
- b) Төвийн алба, тасаг, нэгжүүдийн удирдлага нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсдад мэдээлж, ойлгуулна. Өдөр тутам харж, уншиж, зорилтуудыг хэрэгжүүлж ажиллана. Эмч, ажилчдын ажлын байрны тодорхойлолтод тусган ажилтан бүрийн оролцоог дэмжих
- c) Төвийн цахим хуудсанд байршуулна. Мэдээллийн самбаруудад цаасан болон цахим хэлбэрээр байршуулж, сонирхогч талуудад нээлттэй байлгана.

5.3 Зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдэл

Төвийн Ерөнхий захирал нь ЭМ-ийн сайдын 2020 оны 445 тоот тушаалаар батлагдсан дүрэм, бүтцэд нийцүүлэн алба, тасаг, нэгжийн чиг үүрэгт хамаарах үүрэг, хариуцлага, эрх мэдлийг хуваарилж, тушаалаар баталгаажуулан, төвийн хэмжээнд мэдээлж ил тод байдлыг ханган ажиллана. Төвийн захирлын тушаалаар алба, тасгийн үүрэг, эрх, хариуцлага, үйл явцыг тодорхойлж баталгаажуулсан байна.

Төвийн Ерөнхий захирал нь хариуцлага, эрх мэдлийг хуваарилахдаа:

- a) Төвийн чанарын удирдлагын болон ХЭМАБ-ын тогтолцоо нь хэрэгжүүлэхээр зорьж байгаа олон улсын ISO 9001:2015, 45001: 2016 стандартын шаардлагад тохируулна,
- b) Төвийн үндсэн болон дэмжих үйл явцууд нь аюулгүй чанартай, хүртээмжтэй цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэн хүртээмжтэй нөөцийг бүрдүүлэх, эмч ажиллагсад, үйлчлүүлэгч эрүүл, аюулгүй орчин, ажлын байраар хангагдах үр дүнд хүрэх нөхцөлийг хангасан байна, Алба, тасаг бүрийн үйл явц, ажилбарын эцсийн бүтээгдэхүүн юу болохыг тодорхой тусгаж өгнө. Энэ бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд нийлүүлэх нөхцөлийг хангасан байна.
- c) Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч нар эмч мэргэжилтэн, ажиллагсдын чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл, сайжруулах боломж, саналыг нэгтгэн удирдлагад мэдээлж, тайлагнана, Үйл ажиллагаанд гарсан ямар нэг сайжрал, дэвшил бүрийг мөн адил мэдээлж ажиллана.
- d) Төвийн хэмжээнд үйлдвэрлэсэн цусан бүтээгдэхүүн, цусны донор, эмнэлэг, ард иргэдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээ нь хэрэглэгчид чиглэн төвлөрсөн байх явдлыг дэмжсэн байна. Төвийн алба, тасаг бүр үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, үйлчлүүлэгч, эмч ажиллагсдын аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Алба, тасгууд гадны болон дотоод үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч, нийцүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 45/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- е) Чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцооны өөрчлөлт нь төлөвлөгдөж, хэрэгжих үед чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцооны нэгдмэл байдлыг хангах асуудалд нийцүүлсэн байна.

5.4 Ажилтнуудын оролцоо ба зөвлөлдөөн

Төв нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, хадгалах төлөвлөлт, хэрэгжүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээ ба сайжруулах арга хэмжээнд төвийн бүх алба тасаг, бүх түвшний төлөөллийг оролцуулах, зөвлөлдөх, аюул, эрсдлийг олж тогтоох, илрүүлэх, мэдээлэх, засах, сэргийлэх талаар санал бодлыг сонсох үйл явцуудыг бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн хэвийн байдлыг хангана

- a) Ажилтнуудыг оролцуулах ба зөвлөлдөхөд шаардлагатай арга хэрэгсэл, хугацаа, сургалт, нөөцөөр хагана;
- b) ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны талаар тодорхой, ойлгомжтой ба хамааралтай мэдээллэлд цаг тухайд нь нэвтрэх боломжийг олгоно;
- c) Оролцоонд учрах саад, бэрхшээл /ажилтны санал, санаачлагад хариу өгөхгүй байх, хэл мэдэхгүй, бичиг үсэг тайлагдаагүй байх, ажилтны оролцоог мохоодог, шийтгэдэг бодлого, арга хэмжээг/-ийг тодорхойлох, арилгах, багасгах;
- d) Дараах асуудлаар удирдлагын бус /эмч, мэргэжилтэн, бусад туслах ажилтан/ ажилтантай зөвлөлдөхийг чухалчлах:

1. Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох
2. ХЭМАБ-ын бодлого тодорхойлох
3. Зохион байгуулалтын үүрэг хариуцлага ба эрх мэдлийг боломжтой байдлаар тохоон хувиарлахад
4. Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг хэрхэн биелүүлэхийг тодорхойлох
5. ХЭМАБ-ын зорилтуудыг тодорхойлох ба тэдгээрийн биелэлтийг төлөвлөх
6. Бусдаар ажил гүйцэтгүүлэхэд, худалдан авалт ба гэрээлэгчдэд тавих боломжтой хяналтыг тодорхойлох
7. Байнгын хяналт, хэмжилт, үнэлгээг юунд хийхийг тодорхойлох
8. Аудитын хөтөлбөрийг төлөвлөх, бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн хэвийн байдлыг хангах
9. Байнгын сайжруулалтын үйл явцыг бий болгоход

- е) Дараах асуудлаар удирдлагын бус ажилчдыг оролцуулахыг чухалчлах
1. Ажилтнуудыг оролцуулах ба зөвлөлдөх хэрэгслийг тодорхойлох
 2. Аюулыг тогтоох ба эрсдэл боломжийг үнэлэх
 3. Аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах
 4. Чадамжийн шаардлага, сургалтын хэрэгцээ, сургалт, сургалтын үнэлгээг тогтоох
 5. Юуг мэдээлж, танилцуулах, түүнийг хэрхэн хийж гүйцэтгэхийг тодорхойлох

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 46/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

6. Хяналтын арга хэмжээнүүдийг тодорхойлох, тэдгээрийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хэрэглэх
7. Аюултай тохиолдол ба үл тохирлыг судлах, залруулах арга хэмжээг тодорхойлох;

6. Төлөвлөлт

6.1 Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ

6.1.1 ЦССҮТ нь чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцоог төлөвлөхдөө төвийн төлөв байдал, гадаад, дотоод асуудал, сонирхогч талуудын шаардлага хамрах хүрээнд үндэслэнэ. Үүнд:

- a) Чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хадгалж, хөгжүүлснээр төвийн үйл явцын гаралт, цусан бүтээгдэхүүн болох аюулгүй, эмчилгээний үр дүнтэй цус, цусан бүтээгдэхүүнийг хүрэлцээтэй хэмжээгээр үйлдвэрлэж, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг тогтмол нийлүүлэх эмч, ажиллагсад, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалан, эрүүл ажлын нөхцөл бий болгож, хадгалах үр дүнд хүрэхийг нотолно.
- b) Чанарын удирдлага, ХЭМАБ-ын тогтолцоог хэрэгжүүлж, хөгжүүлснээр хүсч байгаа үр дүнг дээшлүүлж чадна. Төвийн эмч, мэргэжилтэн, ажилтан бүр хийж буй ажлаа цаг хугацаанд нь зөв, бүрэн төгс, чанартай хийж байж төвийн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хувь нэмрээ оруулна гэдгийг ойлгон өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж, хэвших нь чухлыг ойлгуулна.
- c) Мөн тулгарч болох эрсдлийг тодорхойлж, хүсээгүй үр дүнгээс урьдчилан сэргийлэх ба бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- d) Үйл явц, ажилбарыг байнга сайжруулахад байгаа боломж болон үүсч болох эрсдэлийг тооцоолон үзэж төлөвлөлт хийнэ.

Гадаад эрсдлийг дараах байдлаар тодорхойлж, сэргийлэх арга замыг томёоллоо. Үүнд:

- Хүн амын дундах халдварын тархалт өндөр

Халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн сайдын тушаал, журмыг мөрдлөг болгон хэрэгжүүлэх, халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх үйл ажиллагаанд бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах,

- Цус өгөхөд хориглох өвчлөл, заалт ихсэх

Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн сайдын тушаал, журмыг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, бусад эрүүл мэндийн байгууллагууд, болон аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 47/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Импортоор орж ирдэг зүйлс тасалдах Ж: хүүдий, оношлуур, аппаратны сэлбэг тасалдах

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн цус цуглуулалт, үйлдвэрлэлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зөв зохион байгуулах, сарын нөөц бүрдүүлэн ажиллах,

- Санхүүгийн төсөв танагдах, хасагдах

Төсвийн төлөвлөлтийг бодитой хийх, батлуулахдаа үндэслэлийг тодорхой гаргах, өртөг зардлын тооцоололыг хийх

- Хүний нөөц

Нийгмийн асуудлыг сайжруулах

- Аппарат тоног төхөөрөмж эвдрэх, запас сэлбэг ховор байх

Зарим тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн арчилгаа үйлчилгээг тогтмол хийх

- Байгалийн гамшиг

Гамшгийн үеийн бэлэн байдал, нөөцийг бүрэн хангаж ажиллах, жил бүрийн төлөвлөлтөнд тодотгол хийж батлуулах

Дотоод

Төвийн захирлын тушаалаар байгуулсан орон тооны бус бус эрсдлийн багболон ХЭМАБ-ын зөвлөл ажиллана. Энэ баг, зөвлөлд төвийн үндсэн болон дэмжих үйл ажиллагааг бүрэн төлөөлсөн байна.

Алба, тасаг нэгжүүд үйл ажиллагааны онцлогтоо тохируулан дотоод эрсдэлээ тодорхойлон эрсдэлээс сэргийлэх, бууруулах, хянах төлөвлөлт гарган ажиллана.

6.1.2 ЦССҮТ нь дараах арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- а) Эрсдэл болон боломжуудад чиглэсэн арга хэмжээг төлөвлөнө. Эрсдэл, гамшиг үүсгэх шалтгааныг тодорхойлох, эрсдэлийн эх үүсвэрийг арилгах, эрсдэлийн магадлал буюу үр дагаврыг өөрчлөх, эрсдэлийг хуваалцах, шийдвэрийг ил тод байлгах зэргээр эрсдэлийг сэргийлэх буюу бууруулах арга хэмжээг авна. Боломж нь шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх, нутагшуулах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ зах зээл нээх, шинэ хэрэглэгчид чиглүүлэх, түншийн харилцаа бий болгох төвийн болон хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн бусад бодит тааламжтай бололцоонуудыг ашиглана
- б) Хэрхэн яаж төлөвлөсөн арга хэмжээнүүдийг:
 - 1) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны үйл явцуудтай уялдах, холбон нэгтгэж хэрэгжүүлэхийг

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 48/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- 2) Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үр нөлөөг үнэлэхийг тусгаж өгнө. Хянаж, үнэлэх.

Үйл ажиллагаа явуулахад нөлөөлж болох эрсдэл, боломжуудыг тооцоолон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа нь үйлдвэрлэх цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарын шаардлагад нийцэхэд үзүүлэх нөлөөлөлтэй уялдсан байна. Жил бүрийн эхэнд ЗГ-аас ЭМ-ийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, төвийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөнд тулгуурлан төвийн, алба, тасаг, орон тооны бус алба, баг, комисс жилийн үйл ажиллагааны болон үндсэн тасгууд цус цуглуулалт, шинжлэгээ, ЦЦБ үйлдвэрлэлийн төлөвлөгөө боловсруулна. Эдгээр төлөвлөгөөг боловсруулахдаа төвийн боломж, давуу тал, сул тал эрсдэл, аюулыг тооцоолон аль болох аюул, эрсдлээс сэргийлэн үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Төвийн болон алба тасгууд үйл ажиллагааны /үндсэн дэмжих үйл ажиллагаа, аюул эрсдлээс сэргийлэх, чанар сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаанууд тусгагдсан байна/ болон тоон үзүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан хамт олноороо хэлэлцүүлэн төвийн захирлаар батлуулж, хэрэгжилтийг хагаж ажиллана.

Аюулыг тодорхойлох:

Төв нь аюулыг урьдчилан тодорхойлох үйл явцыг бий болгож, нэвтрүүлж хөгжүүлнэ. Үүнд:

- a) Төвийн гадна, дотно гарсан аюултай тохиолдлууд үүнд онцгой байдал тэдгээрийн шалтгаан
- b) Ажлын зохион байгуулалт, нийгмийн хүчин зүйл /ажлын ачаалал, ажлын цаг, ажлын байрны дарамт, / манлайлал, байгууллагын соёл
- c) Хэвийн болон хэвийн бус нөхцөл /нөхцөлийн нэмэгдэл, ажлын хорогдолтой цаг/
- d) Онцгой байдлын нөхцөл –КОВИД 19 хөл хорио, ХСХ дэглэм мөрдөлт
- e) Хүмүүс:
 1. Ажлын байранд нэвтэрч болон үйл ажиллагаанд оролцож буй ажилтнууд, гэрээт ажилтан, зочид
 2. Ажлын байрны ойролцоо байгаа байгууллагын үйл ажиллагаанд өртөж болох хүмүүс
 3. Тухайн байрлалд байгаа боловч байгууллагын шууд удирдлаган дор байдаггүй ажилтнууд- кофе шоф
- f) Бусад
 1. Ажлын орчны дизайн, үйл явцууд, суурилуулалт, машин тоног төхөөрөмж, ажиллагааны журам, ажлын зохион байгуулалт, оролцож байгаа ажилтнуудын хэрэгцээ болон боломжуудад тааруулах асуудал

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 49/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

2. Төвийн шууд удирдлага дор хийгдэж байгаа үйл ажиллагаанд хамааралтай ажлын байрны оролцоо үүссэн нөхцөл байдал
3. Төв хянадаггүй болон ажлын байран дахь хүмүүст гэмтэл эсвэл ЭМ хохирол учруулах шалтгаан болж болох нөхцөл байдлууд
- g) Төвийн үйл ажиллагаа, үйл явцууд болон ХЭМАБ-ын тогтолцоонд гарсан бодит болон төлөвлөж буй өөрчлөлтүүд
- h) Аюулын тухай мэдээлэл болон мэдлэгт гарсан өөрчлөлтүүд

ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд учрах эрсдлийг үнэлэх

Төв нь

- a) Хууль тогтоомжийн шаардлага, бусад шаардлагууд ба хэрэглэж байгаа хяналтын үр нөлөөг авч үзэх, олж тогтоосон аюулын эрсдэлд үнэлгээ өгөх
- b) ХЭМАБ-ын тогтолцоог бий болгох, нэвтрүүлэх, ажиллуулах холбоотой үйл явц, үйлчүүлэгчийн хэргэцээ ба хүлээлтээс үүсэх эрсдлийг олж тогтоох, үнэлэлт өгөх

ХЭМАБ-ын болон бусад боломжуудыг үнэлэх

Төв нь дараах үйл явцуудыг бий болгож, нэвтрүүлж, хөгжүүлнэ:

- a) ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах боломжууд
 1. Ажил, ажлын зохион байгуулалт, ажлын орчинг ажилтнуудад таруулах боломжууд
 2. Аюулыг устгах болон ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах боломжууд
 3. Төвийн бодлого, үйл явц, үйл ажиллагаанд хийхээр төлөвлөсөн өөрчлөлтүүд

- b) ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог сайжруулах боломжууд

Хавсралт 15 Төвийн үйл ажиллагаанд учрах эрсдлийг сэргийлэх төлөвлөгөө, алба тасгуудын үнэлгээ

6.2 Чанарын болон ХЭМАБ-ын зорилтууд ба төлөвлөлт

6.2.1 ЦССҮТ нь чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин дэх алба, тасаг, нэгжүүдийн үйл явцууд дахь чанарын болон ХЭМАБ-ын зорилтыг тогтооно.

Чанарын зорилт:

- a) Чанарын бодлоготой уялдсан, Аюулгүй, эмчилгээний үр дүнтэй, хүрэлцээтэй бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахад чиглэсэн байна
- b) Хэмжигдэхүйц үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр хэмжиж болохуйц байна

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 50/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- с) Төвийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээ, цусны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль, стандарт, журам, заавар болон хэрэглэгчийн болон ISO 9001 стандартын холбогдох шаардлагад нийцсэн байна.
- д) ЦЦБ, тусламж, үйлчилгээний тохирлын байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд хамааралтай цусны донор, хэрэглэгч эмнэлгийн эмч, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, байнга сайжруулдаг байна.
- е) Сар, улирал, хагас бүтэн жилээр хэрэгжилийг хянаж, дүгнэн баримтжуулсан байна
- ф) Төвийн алба, тасгийн бүх эмч, ажиллагсадад үр дүнг тухай бүр мэдээлж, хэрэгжилтийн явцыг ажилагсад бүр мэддэг байна. Сар, улирлын статистик үзүүлэлтүүд гарсан байна.
- г) Шаардлагатай тохиолдолд шинэчлэгддэг байна. 2-3 жил тутам хянаж шинэчилнэ.

ХЭМАБ-ын зорилт:

- а) Эрсдлийн үнэлгээг хийж, засаж, сайжруулах, сэргийлэх арга хэмжээг тодорхойлон, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
- б) ХЭМАБ-ын хууль, тогтоомж, эрх зүйн актууд олон улсын болон үндэсний холбогдох стандартад нийцэж, ажиллаж байгаад дотоод аудит эсвэл хөндлөнгийн үнэлгээ хийх
- с) ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо, шаардлага, MNS OHSAS 18001: 2012, MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж, хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, гэрчилгээ авах
- д) ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж, үнэлгээнд тогтмол хамрагдах

Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч нар:

- Чанарын болон ХЭМАБ-ын зорилтын дагуу үйл ажиллагааны чиглэлд уялдуулан тохирсон, шалгуур үзүүлэлтийг хамт олноор хэлэлцүүлэн тодорхойлж гаргана.
- Шалгуур үзүүлэлт нь үйл ажиллагаа зөв хийгдэн, байнга сайжирч, хөгжин дэвшихэд үр өгөөж өгөхүйц байхад анхаарна.
- Чанарын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг холбогдох эмч, мэргэжилтэн, ажилтнаас үндсэн үйл ажиллагааны цахим програм, хөтөлж байгаа цаасан маягт, бүртгэлээс сар бүр гаргуулан авч, үнэн зөвийг нотлон баталгаажуулсан байна.
- Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг дүгнэлт хийн нийт ажиллагсдад мэдээлнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 51/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Үр дүнг улирлаар нэгтгэн төвийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, баримтжуулж, мэдээллийг Чанарын албанд бичгээр хүргүүлсэн байна.

ЦССҮТ-ийн Чанарын болон ХЭМАБ-ын зорилт:

1. Донорын эгнээг өргөжүүлж, байнгын донорын эзлэх хувийг хадгалах, нэмэгдүүлэх.
2. Нэгдсэн лабораторийн үйл ажиллагаанд мөрдөж буй Чанар, чадавхид тавих шаардлага стандартыг хөгжүүлэх, хадгалах
3. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлыг хангах, нөөц, хангамжийн зохистой түвшинг хадгалах
4. Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тасралтгүй суралцагч байгууллага болох
5. Төвийн программ хангамжийн тогтолцоонд ОУ-ын стандартыг нэвтрүүлэх,
6. Тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангаж, тогтвортой, хэвийн ажиллагааг хангах
7. Эрсдлийн үнэлгээг жил бүр хийж, засаж, сайжруулах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
8. **Чанарын болон ХЭМАБ-ын шалгуур үзүүлэлт:**

ДЗБ-ын тасаг:

1. Цус цуглуулалтын тоо, жил бүр 1%-аар нэмэгдүүлэх
2. Байнгын донорын эзлэх хувь, жил бүр 500 донорыг байнгын донор болгох
3. Асуумж үзлэгээр хасагдалтын хувь, жил бүр 0.5%-аар бууруулах
4. Донорт илрэх сөрөг хариу урвалыг бүртгэх, сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах
5. Үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, засч сайжруулах ажил хэрэгжүүлсэн байна.

НЛ-ийн тасаг:

1. Чанарын гадаад үнэлгээ – Боломжит чиглэл бүрээр 100% хамрагдаж үр дүнг тооцож ажиллана.
2. Шинжилгээг давталтыг бүрэн бүртгэж, шалтгааныг тодруулж засаж сэргийлэх арга хэмжээ авч ажиллах
3. Шинжилгээ бүрт хийгдэх дотоод хяналтыг хийж зөвшөөрөгдөх хязгаараас давсан тохиолдлыг бүртгэж нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулах
4. Үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, засч сайжруулах ажил хэрэгжүүлсэн байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тасаг:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 52/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

1. Нутагшсан шинэ технологийн ЦЦБ-ий үйлдвэрлэл, хэрэглээг хэвшүүлэн, нэмэгдүүлнэ.
2. Чанарын шинжилгээнд бүрэн хамруулан, үр дүнг тооцож ажиллана.
3. Эмнэлгийн захиалгыг бүртгэж, бүрэн олгоно.
4. Үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, засч сайжруулах ажил хэрэгжүүлсэн байна.

Инженер техникийн тасаг:

1. Төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг 95%-иас бууруулахгүй ажиллана
2. Тоног төхөөрөмжийн арчилгаа, үйлчигээг 100% хийн бүрэн баримтжуулна
3. Хамтран ажиллагч байгууллага, алба тасгаас сэтгэл ханамжийн судалгаа авч, засч, сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.
4. Ханган нийлүүлэгч байгууллагын тоног төхөөрөмжийн завсар үйлчилгээнд хяналт тавьж ажиллана
5. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, бүрэн баримтжуулна.

ЭШМТ-ын алба:

1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтын сурлагын амжилт 100%, чанар 80%-иас дээш байх
2. Эрдэм шинжилгээний журнал клубыг улиралд 3 аас доошгүй удаа зохион байгуулан эмч, мэргэжилтнүүдийг 80%-иас дээш хамруулах
3. Тухайн жилийн гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 70% - иас дээш байх
4. Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн ашиглалтын тасралтгүй байдлыг ханган засвар үйлчилгээний гүйцэтгэл 80% иас доошгүй байх
5. Төвийн програм хангамж, сүлжээний тасралтгүй ажиллагааг ханган аливаа гэмтэл, саатал гарсан үед 24 цагт багтаан шаардлагатай арга хэмжээ авсан байх
6. Албаны үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж “Сайн”-аас дээш үнэлгээтэй байна.

ЗМА-ны Чанарын шалгуур үзүүлэлт:

1. Хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж, өмнөх хөтөлбөрийн хэрэгжилтээс 5% иар нэмэгдүүлсэн байна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 53/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

2. Эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг бүрэн хангаж, гэрээ, тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг 100% хянасан байна.
3. Сошиал орчинд хийж буй цусны донорын сургалт сурталчилгаа, маркетингийг бүрэн бүртгэлжүүлж үр дүнг тооцож ажиллана.
4. Төвийн дотоод хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн бүртгэл хөтлөн баримтжуулж, өргөжүүлэн үр дүнг тооцож ажиллана.
5. Хүндэт донорын мэдээллийн баазыг баяжуулж, үйлчилгээ авах нөхцлийг хялбаршуулан, цусны донорын алдаршуулалт, урамшуулалын нэгдсэн бүртгэл мэдээллийг бий болгосон байна.
6. Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, эрх бүхий байгууллагын шалгалт, үзлэгт өмнөх шалгалтаас буурахгүй дүнтэй оролцсон байна.
7. Дотоод, гадаад тайлан мэдээг цаг хугацаанд гаргаж тайлагнах, дүн шинжилгээ хийж, мэдээллэх, мэдээний сан үүсгэж тогтмол баяжуулан жилийн тайлангийн үнэлгээний дүнг А үнэлгээнд барина

ЦЧАБ-ын алба:

1. Чанар, ХСХ сургалтыг жилд 2- оос доошгүй хийж, нийт ажиллагсдын 90%-иас дээш хамруулсан байна
2. Стандартуудын хэрэгжилтэнд дотоод аудит жилд 1 удаа хийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлнэ
3. Баталгаажуулалтын байгууллагаар аудит хийлгэн, илэрсэн үл тохирлыг засч, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.
4. Төвийн халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагааг үнэлэх хяналтын дүнг 93% -иас дээш хүргэнэ
5. Эрүүл мэндийн урьчдиглан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан ажилчдын хувийг өмнөх оноос 3%-иас дээш нэмэгдүүлнэ
6. Эмч, ажиллагсдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эсрэг хийгдсэн дархлаажуулалтын хувийг өмнөх оноос 2 хувиар нэмэгдүүлнэ.

СБА:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 54/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

1. Санхүү бүртгэлийн дотоод, гадаад тайлан тооцоог цаг хугацаанд бүрэн илгээж, баримтжуулсан байна
2. Санхүү бүртгэлийн бүртгэлийг бүрэн бүртгэнэ
3. Өр авлагыг бууруулж ажиллана.
4. Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах бараа, материалыг цаг хугацаанд нь бүрэн олгож нөөцийг тасалдуулахгүй ажиллах

ХЭМАБ-ын баг:

1. Эрсдлийн үнэлгээг хийж сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллана
2. ХЭМАБ-ын сургалтыг жилд 2- оос доошгүй хийж, нийт ажиллагсдын 90%-иас дээш хамруулсан байна
3. Стандартуудын хэрэгжилтэнд дотоод аудит жилд 1 удаа хийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлнэ
4. Баталгаажуулалтын байгууллагаар аудит хийлгэн, илэрсэн үл тохирлыг засч, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

6.2.2 ЦССҮТ-ийн жилийн төлөвлөгөөт ажил, чанарын зорилтуудад хүрэх үйл ажиллагааг төлөвлөхдөө дараах зүйлсийг тодорхойлно. Төвийн алба, тасаг, орон тооны бус баг, комисс төвийн болон чанарын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ажиллах орчин байр, хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад шаардагдах зүйлсийг тооцоолон төлөвлөнө. Төлөвлөгөөнд дараах зүйлс тусгагдсан байна. Үүнд:

- a) Ямар үйл ажиллагааг хэрхэн хийх (Журам, заавар, АБТ, САЗ, ТТАЗ)
- b) Энэ үйл ажиллагааг хийхэд ямар нөөц шаардлагатай болох (Арга, аргачлал, хүүдий, оношлуур, ажилтан)
- c) Хэн хариуцаж ажиллах(дарга, эрхлэгч, эмч, сувилагч, ажилтан)
- d) Хэзээ хийж дуусгах (хугацаа бодитой байх)
- e) Гүйцэтгэл, үр дүнг хэрхэн үнэлэх (бүх үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, үр дүнг статистик боловсруулалт хийж үнэлэх) зэргийг тус тус тодорхойлсон байна.

Төвийн алба, тасаг, баг, комиссууд үйл ажиллагаа, чанарын зорилт хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хамт олноор хэлэлцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган стратеги төлөвлөлтийн албанд хянуулж, чанарын албаны саналыг аван ерөнхий захирлаар батлуулж, хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана.

6.3 Өөрчлөлтийг төлөвлөх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 55/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ЦССҮТ чанарын удирдлагын тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлагатай гэж тодорхойлсон бол түүнийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ. Тухайлбал жил бүр АЗ, САЗ, ТТАЗ-ыг хянаж шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийнэ. Хэрэв өөрчлөлт хийх шаардлагатай бол хяналт хийх төлөлөгөө болосруулж, хэрэгжүүлнэ. Өөрчлөлтийг төлөвлөхдөө дараах зүйлсийг авч үзнэ. Үүнд:

- a) Өөрчлөлт хийх зорилго, хийсэн өөрчлөлтөөс гарах боломжит үр дагавар юу болох эерэг-боломж, сөрөг- эрсдэл
- b) Чанарын удирдлагын тогтолцооны нэгдмэл байдал – үйл явц, ажилбарын уялдаа холбоо, цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний чанарт нөлөөлөх байдал
- c) Өөрчлөлт хийхэд шаардагдах санхүү, хүний нөөц болон бусад нөөц, түүний бэлэн байдал
- d) Үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хуваарилалт, дахин хуваарилалтыг тус тус харгалзан үзэж, өөрчлөлтийг төлөвлөнө.

7.Тулгуур хүчин зүйл (Дэмжих үйл явц)

7.1 Нөөц

7.1.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ нь чанарын удирдлагын болон ХЭМАБ-ын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулахад шаардлагатай бүх нөөцийг тодорхойлж хангана. Төв үндсэн болон дэмжих үйл ажиллагаа явагдаж аюулгүй, эмчилгээний үр дүнтэй, хүрэлцээтэй ЦЦБ үйлдвэрлэхэд шаардагдах төсөв боловсруулна. Төсөвт үйл ажиллагааг хэрэгжүүлэх аюул, эрсдлийг тогтоох, сэргийлэх үйл ажиллагаанд шаардагдах хүний нөөц, тоног төхөөрөмж, урвалж бодис бусад дагалдах хэрэгсэл зэрэг бүх нөөцийг багтаана. Төв дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- a) Дотоод нөөц боломж ба хязгаарлагдмал байдал:
 - Бэлтгэгдсэн, мэргэшсэн хүний нөөцтэй, үйл ажиллагааг явуулж тогтворжсон байдал, техник технологийн шинэчлэл хийгдэж шинэ тоног төхөөрөмж ашиглаж байгаа, засвар үйлчилгээний загвар нэгж байгуулагдсан, ханган нийлүүлэгчтэй хийсэн гэрээгээр зарим үйлчилгээ хийгддэг, шинэ тоног төхөөрөмжүүд баталгаат хугацааны явцад завсар, үйлчилгээг ханган нийлүүлэгч бүрэн хариуцаж байгаа зэрэг боломжууд байна.
 - Хүний нөөцийн дутагдал, шинэ төв ашиглалтанд орж, үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой ажлын ачаалал ихэссэн, шинэ тоног төхөөрөмжүүдийн запас сэлбэг худалдан авах, баталгаажилт, үнэлгээ хийх зардал нэмэгдэж байгаа зэрэг бэрхшээлүүд байна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 56/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

б) Гадны нийлүүлэгчээс авах шаардлагатай зүйлс:

Үйл ажиллагаанд хэрэглэгдэх зүйлсийг Тендерийн хуулийн дагуу зохион байгуулна. Холбогдох алба, тасгууд үйл ажиллагаанд шаардлагатай зүйлсийн жагсаалтыг гарган төрөлжүүлэн ангилж, төрөл зүйл бүр дээр тавигдах шаардлага, тоо хэмжээ, нийлүүлэх давтамж, тээвэрлэх, хадгалах нөхцөлүүдийг нарийвчлан тодорхойлж өгнө. Үүний дагуу төвийн ерөнхий захирлын тушаалаар байгуулагдсан тендерийн хороо тендерийн материалыг боловсруулж, хууль, журмын дагуу худалдан авах үйл ажиллагааны бараа, үйлчилгээ нийлүүлэх тендер зарлан, нээж, үнэлгээ хийн сонгож, гэрээ байгуулж, ажиллана. Тендерийн үйл ажиллагаа, нийлүүлэлт, хяналт үнэлгээ, дүгнэлт хийж ажиллан баримтжуулна. Цус, цусан бүтээгдэхүүн савлах цусны хүүдий, шинжилгээнд хэрэглэх оношлуур, тоног төхөөрөмжийн сэлбэг, дагалдах хэрэгслүүд, халдваргүйтлийн бодис, уусмал, програм хангамж, бусад материал хэрэгслийг тендерийн хуулийн дагуу ханган нийлүүлнэ. Хэрэгжилтэнд үнэлгээ хийн засч, сайжруулах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

7.1.2 Хүмүүс

ЦССҮТ нь үйл ажиллагаа хэвийн явагдах, чанарын болон ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог үр бүтээлтэй хэрэгжүүлэх үйл явцыг хангахад шаардлагатай хүний нөөцийг тодорхойлж, хангана.

Төв нь үйл явц, ажилбартай уялдуулан ажлын байрыг тодорхойлж, ажлын байр бүр дээр ажиллах орон тоог тогтоож, ерөнхий захирал жил бүр батална.

Хавсралт 16. Төвийн захирлын тушаал 2021 оны 01 тоот

Хүний нөөцийн ажилтан ажлын байранд тавигдах шаардлага, ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан нийтлэг шаардлагад нийцүүлэн ажлын байрны тодорхойлолтыг холбогдох алба, тасгийн эрхлэгч нартай зөвшилцөн боловсруулна.

Хавсралт 17. Төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдын ажлын байрны / албан тушаалын/тодорхойлолтын жагсаалт,

Ажлын байранд тавигдах шаардлагад тохирсон эмч, мэргэжилтэн, ажилтныг бүрдүүлж, сонгож, мэдлэг олгон, сургаж, ур чадвар эзэмшүүлнэ. Төвийн ажилтан сонгон шалгаруулах, дадлагжуулан сургах, туршилтаар ажиллуулах, үндсэн ажилтанаар томилох журмыг мөрдөж ажиллана.

Хүний нөөцийн ажилтан сургалтын албатай хамтран шинэ ажилтанг сургах хөтөлбөрийн дагуу шинээр ажилд орсон бүх ажиллагсдад баримжаа олгоно. Мөн эмч, мэргэжилтэн, ажиллагчдын ерөнхий мэдлэг, чадварт үнэлгээ өгч, сайжруулж, хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллана. Хүний нөөцийн залгамж байдлыг судлан хуримтлуулсан мэдлэг, туршлагыг өвлөн авах, түгээх,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 57/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

орлон, хөрвөн ажиллах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг удирдлагын зөвлөлд тайлагнаж ажиллана.

Алба, тасаг бүр ажлын байран дээр дагалдан суралцаж, ур чадвар эзэмших тусгай хөтөлбөр боловсруулсан байна. Үүний дагуу эмч, мэргэжилтэн ажилтанг сургаж, сургалтын үр дүнг онол болон дадлага ур чадварыг үнэлэн, баримтжуулна. Албаны дарга тасгийн эрхлэгч ур чадварт тохирсон ажлын байран дээр бие даан ажиллах эрхийг олгож ажил үүргийн хувиарьт оруулна. Албаны дарга, тасгийн эрхлэгч эмч, мэргэжилтэн, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг үнэлж, сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хавсралт 18. Хүний нөөцийн товч судалгаа

Эмч, ажилтны ажиллах орчин, нийгмийн асуудлыг байнга сайжруулж, боловсон хүчнийг хадгалах бодлого барьж ажиллана. Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана.

7.1.3 Дэд бүтэц

ЦССҮТ нь үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг стандартын шаардлагад тохирсон байлгахад шаардлагатай дэд бүтцийг тодорхойлон хангаж, хадгалж ажиллана. Үүнд:

- a) Төв нь Баянзүрх дүүрэг дэх төв байр, СБ дүүрэг, Дүнжингарав худалдааны төв дэх цус цуглуулах суурин төвүүд болон явуулын хөдөлгөөнт хэлбэрээр үйл ажиллагааг явуулна. Төвийн барилга нь цусны албаны болон эрүүл мэндийн байгууллагын байранд тавигдах нийтлэг болон өвөрмөц шаардлагыг хангасан байна. Төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад заагдсан нөхцөлийг хангасан байхаар зохион байгуулна.
- b) Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай материал хэрэгслийг тендерийн хуулийн дагуу нийлүүлнэ.

Цусны албаны үйл ажиллагаа, чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцсэн программ хангамжийг боловсруулан ашиглана. Програмын аюулгүй байдал, нууцлалыг ЭМ-ийн сайдын болон төвийн ерөнхий захирлын баталсан журмаар зохицуулна. Шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийг хийж, баримтжуулна.

Төвийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, тохируулах протокол хөтөлж баримтжуулна. Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар, үйлчилгээ хийх журам мөрдөж ажиллана. Тоног төхөөрөмжийн бүртгэлийн программ ашиглана. Программд тоног төхөөрөмжийн гарал үүсэл, хэрэглээ, ашиглалт, засвар үйлчилгээ, тохируулга, арчилгаатай холбоотой бүхий л мэдээлэл орсон байна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 58/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Эмч, мэргэжилтэн ажиллагсад тоног төхөөрөмж ажиллуулах, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, арчлах, зарим үйлчилгээ хийх сургалтад хамрагдаж ур чадвар эзэмшсэн байна. Ашиглах явцыг бүрэн баримтжуулсан байна.

- с) Төв нь үндсэн болон дэмжих үйл ажиллагаанд тээврийн хэрэгсэл ашиглана. Явуулын хэлбэрээр цус цуглуулах жижиг оврын автобус, эмнэлгийн зориулалтын дохиололтой машин хэрэглэнэ
Тээврийн хэрэгсэл нь эмч, мэргэжилтний болон цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан байна. Холбогдох ангиллын эрх бүхий туршлагатай жолооч ажиллана. Жолооч өдөр бүр ажил эхлэхийн өмнө тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалган, аюулгүй байдлыг ханган замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллана. Урсгал болон төлөвлөгөөт засвар, үйлчилгээг бүрэн хийж баримтжуулна. Төвийн дэмжих үйл ажиллагаанд зориулагдсан тээврийн хэрэгсэл нь холбогдох хууль дүрэм зааврын шаардлагад нийцсэн байна. Төвийн тээврийн хэрэгслийг ажлын бус цагуудад төвийн гражид хадгална. Төвийн автомашиныг ажлын зорилгоор хэрэглэх үед холбогдох албанд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авч, хэрэглэх ба замын хуудас дээр ашигласан зорилго, зарцуулсан замын урт, хугацааг тэмдэглэн гарын үсэг зурж баримтжуулна. СТСБ-ийн алба автомашин, зогсоол ашиглах журам боловсруулж, мөрдөж, хяналт тавьж ажиллана.
- д) Төвийн үйл ажиллагаанд цахим сүлжээ систем ашиглана. ЭМ-ийн сайдын болон төвийн ерөнхий захирлын баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөнө. Мэдээллийн технологийн инженер цахим сүлжээний мэдээлэл харилцаа холбооны технологийг хөгжүүлж, нууцлал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Төвийн төв байранд дотоод холбоо ашиглана. Алба, тасгууд холбогдож, үйл ажиллагааны болон яаралтай мэдээлэл дамжуулж ашиглана.

Төвийн дэд бүтцэд цахилгааны аюулгүй байдал, үйл ажиллагаанд шаардагдах хүчин чадал бүхий цахилгааны нөөц үүсгүүрүүд хамаарна. Мөн төвийн суурин цэгүүдийн цэвэр, бохир усан хангамж, цэвэрлэгээ үйлчилгээ, угаалга, эмч ажилчид, донорын цай, зууш, хоолны үйлчилгээ, ажилчдын амрах, алжаал тайлах, чийрэгжүүлэлтийн өрөө, усанд орох газрын үйлчилгээ хамаарна.

7.1.4 Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

ЦССҮТ нь үйл явцуудыг хэрэгжүүлэх цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээ стандартын шаардлагад нийцэх тохирлын байдлыг хангах, ажилтан, үйлчүүлэгчийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд шаардлагатай орчныг тодорхойлж, бүрдүүлж, хадгална. Төв үндсэн болон дэмжих үйл ажиллагааг явуулахад шаардагдах орчинг тодорхойлж төлөвлөн, шаардагдах зүйлсээр хангана. Холбогдох журам зааварт заагдсан үйлчилгээ, засварыг хийж, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 59/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Энэ үйл ажиллагаанд дараах үндэсний стандарт, журмуудыг мөрдөнө. Үүнд:

- MNS 6647:2017 Төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт,
 - NNS OHSAS 18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт,
 - MNS ISO 15189:2015 Эмнэлгийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага,
 - Халдварын сэргийлэлт, хяналтын журам Ж-2- EP-14-2
- a) Нийгмийн – төвийн нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсад аюулгүй, цэвэр, тохилог орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Ажлын орчин нь дулаан, гэрэлтүүлэг тохирсон, цахилгааны аюулгүй байдал хангагдсан байна. Зориулалтын өрөөнүүд усан хангамжид холбогдсон байна. Эмч ажиллагсад төвийн зөвшөөрөгдсөн хэсэгт зөвшөөрөгдсөн цагт орж ажиллана. Хувийн хамгаалах хэрэгсэл, хүйтэн өрөөнд ажиллах зориулалтын хувцас, дохиоллын системээр хангагдсан байна. Ажлын хувцсыг угаах, индүүдэх, хадгалах зориулалтын угаалгын хэсэгтэй байна
- b) Сэтгэл зүйн – төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсад хувцас солих өрөө, хувийн хувцас хадгалах шүүгээгээр хангагдана. Өдрийн хоолыг зориулалтын хэсэг, өрөө, гуанзанд дотоод журмаар зохицуулсан цагийн хуваарийн дагуу хооллоно. Ажлын байран дээр чанга дуугаар ярих, маргалдах зэрэг бусдын сэтгэл тавгүйтэх, ажлаа хийх анхаарлыг сарниулах зэргийг хориглоно.
- c) Физикийн - Төвийн цус цуглуулах, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинжилгээ хийх өрөөнүүдэд шороо тоос, шавьж орохоос сэргийлэн цонх онгойлгож, байгалийн агааржуулалт оруулахгүй. Цэцэг, ургамал тавихгүй. Өрөөнд зориулалтын зохиомол агааржуулалт хийгдсэн байна. Ажлын урсгалыг нэг чигийн байдлаар донор, цусан бүтээгдэхүүний урсгал давхцахгүйгээр зохицуулсан байна. Хөргөгч хөлдөөгч бүхий, цус цуглуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх өрөөнүүдэд зориулалтын агааржуулалт, хөргүүр тавьж тогтмол ажиллуулна. Өрөөний хэм, чийгшил хэмжин хянана. Мөн хөргөгч хөлдөөгч бүхий өрөөнүүдэд нарны гэрлийг бууруулах зориулалтын хөшиг хийнэ. Нээлттэй аргаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон нян судлал, молекул биологийн шинжилгээг хийхэд зориулалтын өрөө, био аюулгүйн кабин ашиглана. Байгалийн болон нэмэгдэл гэрэлтүүлгийг ажлын онцлогт тохируулан байрлуулна. Цуглуулалт, үйлдвэрлэл, шинжилгээний хэсэгт зориулалтын ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ. Үйл ажиллагаа явагдаж байхад дуу чимээ гаргах хөгжим, радио сонсох зэргийг хориглоно. Цус, сийвэн эс, цуглуулах, шинжилгээ хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэсгүүдэд хоол хүнс хадгалах, хоол хүнс идэж уух, гоо сайхны хэрэгсэл авч орох гоо сайхны ажилбар хийхийг, цус, сийвэн, эс цуглуулах, шинжилгээ хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд оролцож байгаа үед гар утсаар ярих зэргийг тус тус хориглоно. Төвийн халдварын сэргийлэлт, хяналтын баг журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 60/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

7.1.5 Мониторинг ба хэмжилтийн нөөц

7.1.5.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ-ийн алба, тасгийн эрхлэгч, үйл ажиллагааг гүйцэтгэж буй эмч, мэргэжилтэн, ажилтан, ашиглаж байгаа тоног төхөөрөмж, арга аргачлал нь тухайн үйл явц, ажилбарт тохирч, нийцэж байгааг хянаж, хэмжиж үнэлнэ. Үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээ стандарт, заавар, журмын шаардлагад тохирч, нийцэж байгааг шалгадаг хяналт, хэмжилтийг хүчин төгөлдөр, найдвартай байлгахад шаардлагатай нөөцийг тодорхойлж хангаж ажиллана. Нөөц нь дараах шаардлагыг хангасан байхыг ЦССҮТ хариуцна. Үүнд:

- a) Тухайн үйл ажиллагаанд тохирсон мониторинг, хэмжилт хийх шаардлагыг хангасан байна. Хэмжүүр, хэмжих, хянах хэрэгслийг баталгаажуулах, түүний ашиглалтанд хяналт тавих журмыг мөрдөж ажиллана. Байнгын ямар хяналт, хэмжилт хийхийг САЗ, ТТАЗ бүрд тусгасан байна. Мониторинг, хэмжилт хийх хүн сургагдсан байна.
- b) Зориулалтаар нь тасралтгүй ашиглах бололцоог хангасан хэвийн ажиллагаатай байна. Хүний нөөцийн хавтсанд сургагдсан, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг нотлох баримтжуулалт хийсэн байна. Тоног төхөөрөмжийн бүртгэл бүрэн хөтлөгдсөн, хэмжих хэрэгсэл баталгаажсан байна. /Ж: термометр/

Төв нь цусны донорыг ЭМ-ийн сайдын 2016 оны 02 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу сонгоно. Бүх хэлбэрээр цус цуглуулахад цусны донор сонгох зааврыг мөрдөж ажиллана. Цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх стандарт ажиллагааны зааврыг мөрдөж, донорын эрүүл мэндийн карт дээрх асуумжийн дагуу ярилцлага хийн баримтжуулна. Шалгуур үзүүлэлт хангаагүй донорыг шалтгаан бүрээр ангилж, бүртгэнэ. Зохих зөвлөгөөг өгнө.

Цуглуулсан цус, сийвэн, эс бүрд хийсэн халдвар илрүүлэх болон цусны бүлгүүд тодорхойлох шинжилгээг бүрэн хийж баримтжуулсан байна. Донорын код тус бүрээр шинжилсэн шинжилгээний хариуг бүртгэн баримтжуулж, хариуг технологийн тасагт хүлээлгэн өгч давхар хяналт хийн баримтжуулалт хөтөлнө.

Үйлдвэрлэсэн цусан бүтээгдэхүүнд ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан чанарын хяналтын шинжилгээг хийж, баталгаажуулна. Цуглуулсан болон бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бүртгэл дээр ямар дугаартай бүтээгдэхүүнээс чанарын хяналтын дээж авч шинжилсэн тухай бүртгэж, баримтжуулна. НЛ-ийн тасаг цусан бүтээгдэхүүний дээжинд ямар нэр төрлийн шинжилгээг хийж үр дүн ямар гарсныг бүртгэж баримтжуулна. Хариуг технологийн тасагт илгээнэ. Өөрчлөлттэй гарсан тохиолдол бүрийг холбогдох эмч, тасгийн эрхлэгчид мэдээлж, баримтжуулна. Тасгийн эрхлэгч, эмч шалтгааныг тогтоож, засч, арилган, дахин гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 61/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслүүдийг СХГ-ын холбогдох алба, лабораториор тодорхой давтамжаар баталгаажуулна. Жин, туухай, автоклав, автомат пипетик, термометр баталгаажилт хийгдэнэ. Стандарт туухай, термометр, хэмжээт сав, пипетик, хурд хэмжигч байна.

Төвийн хөргөгч хөлдөөгчийн хэмийг зориулалтын хяналтын программаар хянана. Хэмийг стандарт термометрээр тодорхой давтамжаар шалгана.

Сийвэн, эс цуглуулах болон шинжилгээний хагас болон бүрэн автомат аппаратуудыг ханган нийлүүлэгч байгууллагын мэргэшсэн инженерүүд хуваарийн дагуу ирж шалган тохируулга хийнэ. Суурилуулсан, тохируулсан, хянаж, шалгасан протокол хөтөлж баримтжуулна.

ЦССҮТ нь хяналт, хэмжилтийн нөөц шаардлага хангаж байгааг гэрчлэх баримтжуулсан мэдээллийг хадгална. Үүнд:

- Цусны донорын эрүүл мэндийн карт, эмчийн үзлэг хийсэн бүртгэл,
- Цус, цусан бүтээгдэхүүнд хийгдсэн бүлэг, халдвар илрүүлэх, чанарын шинжилгээний протокол
- ЦЦБ-ийг хорионоос чөлөөлсөн баримтжуулалт
- Жин, автоклав баталгаажилтийн гэрчилгээ,
- Шинжилгээний аппарат тоног төхөөрөмжийг суурилуулсан, тохируулсан, калибровка хийсэн, хяналтын шинжилгээний үр дүнгийн протокол зэргийг хадгална.

7.1.5.2 Хэмжилтийн нэгж дамжуулалт

Төвийн хэмжээнд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) Төвийн жингүүд, ариутгалд ашиглаж байгаа автоклавын даралт хэмжигч, термометр, ялтас, автомат пипетикийг жилд 1 удаа СХГ-аар шалгаж, тохируулан баталгаажуулсан байна. Мөн хагас болон бүрэн автомат багаж, хэрэгслийг зориулалтын хяналтын материал, калибровкаор шалгаж тохируулан баримтжуулалт хөтөлнө. Өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэхийн өмнө холбогдох эмч, мэргэжилтнүүд шалгаж, баримтжуулна. Зөвшөөрөх хэмжээнд байгаа тохиолдолд үйл ажиллагаанд ашиглана. Тухайлбал центрифугийг 3 сар тутам тохируулга хийнэ. Тахометрээр хурдыг хэмжинэ. Энэ багаж баталгаажсан байна. Тохируулга хийсэн он сар өдрийг бичиж тэмдэглэнэ. 2017.05.18 гэж тэмдэглэнэ. Энэ тэмдэглэлийг хараад энэ өдрөөс 3 сар хүчин төгөлдөр гэдгийг ойлгоно.
- б) Дээрх багаж хэрэгслийг шалгасан баримтжуулалтыг хөтөлж хадгална. Тоног төхөөрөмжийн бүртгэлийн баримт дээр тэмдэглэл хийн гарын үсэг зурсан байна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 62/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

с) Шалгах, тохируулах явцад зөвшөөрөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тасгийн эрхлэгч, холбогдох инженер, техникийн ажилтанд мэдэгдэж асуудлыг шийдвэрлэнэ. Тасгийн эрхлэгч, инженер шаардлага хангахгүй болсныг илрүүлсэн үед өмнөх хэмжилтийн үр дүнгийн баталгаа сөрөг үр дагавартай байж болох нөхцөлүүдийг тогтоож, холбогдох арга хэмжээг авна. Эвдэрсэн, ажилахгүй байгаа тоног төхөөрөмжийг боломжтой бол өөр өрнөөд тусгаарлах буюу “**Эвдэрсэн, ажиллахгүй байгаа**” гэсэн тэмдэглэл анхааруулга бичиж тавина.

Энэ хэсэг дээр төвийн хэмжээнд мөрдөгдөж байгаа бүх баримт бичгийн код, дугаарлалт хамаарна. Баримт бичгийн код дугаарлалтын журмыг боловсруулж, хэрэгжүүлэн, төвийн баримт бичгийн мастер жагсаалтыг гарган жил бүр шинэчилнэ. Төвийн алба, тасаг дээр ашиглаж байгаа бүх баримт бичиг аль түвшний аль алба тасгийн баримт бичиг болох нь танин тодруулах боломжтой дахин давтагдахгүйгээр **стандарт нэгэн жигд** байдлаар дугаарлагдсан, мөшгөн тогтоох боломжтой байна.

7.1. 6 Байгууллага дахь мэдлэг

ЦССҮТ-ийн бүх эмч, мэргэжилтэн, ажиллагсад мэдлэг, ур чадвар олгох сургалтанд хамрагдсан байна. Төвд шинээр орсон ажилтан бүр шинэ ажилтанд баримжаа олгох сургалт болон холбогдох алба, тасаг бүр дээр ажлын байраар дагалдан сурах хөтөлбөрт сургалтанд хамрагдаж, мэдлэг, ур чадварын үнэлгээнд орсон байна.

Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд ямар албан тушаал дээр байгаа ямар эмч, мэргэжилтнийг хэзээ ямар мэргэжил олгох, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг сайжруулах сургалтанд хамруулахыг тусган хэрэгжүүлнэ. Төвийн хүний нөөцийн залгамж, холбоог хөгжүүлэх – төвийн гол албан тушаалд ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, туршлагыг өвлүүлэн авч хадгалах, дараагийн үед уламжлуулах үйл ажиллагаа, төвийн мэдлэгийн залгамж холбоог хадгалах үйл ажиллагаа хүний нөөцийн бодлого, стратегид тусгагдан хэрэгжинэ.

Мөн шинэ техник технологи нэвтрэхэд ямар эмч, мэргэжилтэн, ажилтныг яаж сургах талаар хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Төвийн үндсэн болон дэмжих үйл явцыг хэрэгжүүлэх, цус, цусан бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай мэдлэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:

- ДЭМБ-аас цусны аюулгүй байдлыг хангах талаар дэвшүүлсэн стратеги, зөвлөмж
- Тусгай мэргэжлийн оргүй төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт
- Цусны аюулгүй байдлыг хангах, ХСХ, ХЭМАБ тусламж, үйлчилгээний чанартай холбоотой гарсан тушаал, зааврууд

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 63/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх стандарт, үндэсний фармакопей, цус, цусан бүтээгдэхүүний ҮЗП
- Үйл явц, ажилбарын тодорхойлолт, нийтлэг, өвөрмөц журам, зааврууд,
- Холбогдох САЗ, ТТАЗ, АЗ-ууд
- Цахим сүлжээнд ажиллах мэдлэг, чадвар
- Төвийн эмч, мэргэжилтэн, ажилагсдын хуримтлуулсан туршлага, мэдлэг
- Төвийн 57 жилийн турш боловсруулж, батлуулсан оюуны өмч
- Олон улсын болон үндэсний эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлын үр дүн, онол практикийн хурлын эмхтгэл, нотолгоо зэрэг хамаарна.

Дээрх зүйлс төвийн холбогдох алба, тасгийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдад ашиглахад нээлттэй байна. Төвийн номын сан, цахим номын сан, СХГ-ын цахим номын сан, төвийн веб хуудаснаас олж үзэх, ашиглах боломжтой байна.

Бүтээгдэхүүний САЗ, ТТАЗ, журам, заавар, стандарт, үндэсний фармакопейн өгүүллэлд шаардлагатай шинэчлэлийг тухай бүр оруулж холбогдох хурлаар хэлэлцүүлэн шинэчлэн батлуулна.

Төвийн нийт ажиллагсад төвийн үүрэг, бүтэц, үйл ажиллагаа, эрхэм зорилго, алсын хараа, төвийн болон тасгийн үйлчүүлэгч, тэдгээрийн эрэлт хэрэгцээ, чанарын менежмент болон ХЭМАБ-ын бодлого, зорилт, шалгуур үзүүлэлт, дээрхи тогтолцоонд хувь хүн, алба тасаг хамт олны үүрэг хариуцлага, оролцооны талаар мэдлэгтэй байна.

7.2 Ур чадвар - Чадамж

ЦССҮТ нь Хүний нөөцийн үйл явц, ажилбарыг гүйцэтгэх, тоног төхөөрөмж ажиллуулах, урвалж бодистой харьцах ур чадвар, чадамжийг тодорхойлно. Дараах зүйлийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- а) Төвийн үйл явц, ажилбарт оролцож байгаа эмч, мэргэжилтэн, ажиллагсдын чанарын болон ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл, үр нөлөөтэй байдлыг хариуцах, ажилтны ур чадварт тавих шаардлагыг тогтооно. Төвийн алба, тасаг, нэгжийн ажлын байрны тодорхойлолтод ямар үйл явц, ажилбар дээр ямар шаардлага ханасан ур чадвартай ажилтан ажиллахыг тусган түүнд нийцүүлэн стандарт ажиллагааны зааврыг боловсруулж мөрдөн, сонгож авна.
- б) Эмч, ажилтны эзэмшсэн боловсрол, сургалт туршлагад үндэслэн ур чадварыг магадална.
- в) Шинэ ажилтанд цусны албаны нийтлэг болон ажиллах алба, тасгийн өвөрмөц онцлог мэдлэг, ур чадварыг батлагдсан хөтөлбөрт сургалтаар эзэмшүүлнэ. Сургалтын дараа ур чадварыг тодорхой шалгуураар үнэлж, баримтжуулна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 64/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- d) Төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдын мэргэжил, мэдлэг, ур чадвар, чадамжийг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хүний нөөцийн мэргэжилтэн бүрдүүлж, хадгална. Нууцлал, аюулгүй байдлыг хариуцна.

7.3 Мэдлэг олголт

ЦССҮТ нь өөрийн нийт эмч, мэргэжилтэн, ажиллагсдад дараах зүйлсийг мэдсэн байх нөхцөлийг хангана. Үүнд:

- a) Төвийн чанарын блон ХЭМАБ-ын бодлого
- b) Чанарын бодлогыг хэрэгжүүлэх чанарын зорилтууд
- c) Үүрэгт ажлаа хариуцлагатай, зөв, хийж, гүйцэтгэлээ сайжруулах замаар чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны үр нөлөөтэй байдалд оруулах хувь нэмэр гэдгийг ойлгож мэдэх
- d) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар зэрэг болно.
- e) Мөн ХЭМАБ-ын тогтолцооны шаардлага хангаагүйгээс болзошгүй үр дагавар, уршиг, аюултай тохиолдлууд тэдгээр судлсан үр дүн, ХЭМАБ-ын эрсдэл, сэргийлэх арга хэмжээ, Амь нас, ЭМ-д зайлшгүй ба ноцтой аюул учруулах нөхцөл үүсэж болзошгүй гэж өөрсдөө үзсэн тохиолдолд ажилтанд ажил үүрэг гүйцэтгэхээс татшалзах боломж олгох
- f) Аюул, эрсдлийн илрүүлсэн, мэдээлсэн хүнд урамшуулах, үл бурутгах тогтолцоог хөгжүүлнэ.

Төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсад бүр төвийн ерөнхий үйл явц, түүний дотор өөрийн харъяалагдах алба, тасгийн үйл явц, түүний орц, гарц, харилцан уялдаа, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага түүнийг хэрэгжүүлэхэд хувь хүн, алба, тасгийн оруулах хувь нэмрийг сайн ойлгож мэдсэн байна. Эдгээр мэдлэгийг шинэ ажилтанд баримжаа олгох сургалт, харъяа алба, тасгийн ажлын байраар дагалдан сургах хөтөлбөрөөр тус тус эзэмшинэ. Шинэ ажилтанд баримжаа олгох сургалтыг ЭШХНХА-ны албаны хүний нөөцийн мэргэжилтэн, өвөрмөц сургалтыг харъяа алба, тасгийн эрхлэгч нар хариуцан зохион байгуулж, бүрэн баримтжуулна.

Төвийн Донор зохион байгууллалтын тасагт ажиллагсад хүн амын дунд цусны донорын сургалт сурталчилгаа хийх, донор сурталчлагч, сайн дурын ажилтан донор, иргэдэд сургалт зохион байгуулах мэдлэг, цус, сийвэн эс цуглуулах, донорт анхны тусламж үзүүлэх зэрэг ур чадварыг, үйлдвэрлэлийн хэсэгт ажиллаж буй сувилагч, эмч нар бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи, мөн чанар, физиологи үйлдэл, бүтээгдэхүүний агуулагдахуун, хадгалах тээвэрлэх нөхцөл, ЦЦБ-тэй харьцах, зөв хэрэглэх талаар лабораторийн эмч лаборантууд цусны албаны шинжилгээний стратеги, алгоритм, шинжилгээний зарчим, дотоод хяналт, гадаад үнэлгээний талаар, эмнэлгийн цус сэлбэлтэд оролцдог эмч сувилагчид ЦЦБ-тай зөв

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 65/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

харьцах, хадгалах, тээвэрлэх, цусны бүлэг, хувийн болон биологийн тохироо тодорхойлох, ЦЦБ сэлбэх мэдлэг, ур чадвар тус тус эзэмшсэн байна.

7.4 Холбоо, харилцаа

ЦССҮТ нь чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд хамаарах дотоод болон гадаад холбоо харилцааны асуудлыг тодорхойлно. Үүнд:

- a) Юу мэдээлэх
- b) Хэзээ мэдээлэх
- c) Хэнд мэдээлэх
- d) Хэрхэн мэдээлэх
- e) Хэн мэдээлэх

Мэдээлэл дамжуулах харилцааны асуудлыг төвийн дотоод журам, алдаа эрсдэл бүртгэх, мэдээлэх, засч, сэргийлэх, шинжилгээний онцгой, ноцтой хариу мэдээлэх, халдварын сэргийлэлт, хяналт зэрэг журам, заавраар зохицуулагдана.

Тухайлбал: эрсдэл, үл тохирол алдаа илэрвэл:

- a) Илрүүлсэн үл тохирол, алдаа, эрсдэлийг
- b) Илрүүлсэн тэр даруйдаа
- c) Холбогдох тасгийн эмч, эрхлэгчид шаардлагатай бол чанарын алба, төвийн захиралд
- d) Тасгийн эрхлэгч, албаны даргаар дамжуулан буюу шууд амаар, утсаар, цахимаар нууцлалын зэргээс хамаарна
- e) Илрүүлсэн ажилтан, тасгийн эрхлэгч, чанарын албаны дарга төвийн удирдлагад мэдээлж шалтгааныг тогтоон засч, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг хянаана.

Төвийн алба, тасгийн эмч ажиллагсад хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, сайн туршлага, алдаа, эрсдэл, аюул, үл тохирол зэргийг харьяалагдах алба, тасгийн эмч, удирдлагад, алба тасгийн эрхлэгч нь төвийн захиралд тус тус тухай бүр дамжуулж баримтжуулна.

Мэдээллийг төвийн хаалттай цахим хуудас, хурал, шуурхай, гар утсаар, санал, эрсдэл мэдээлэх хуудсаар, самбар дээрхи мэдээлэл, албаны тэмдэглэл, шууд амаар мэдээлэх зэрэг олон хэлбэрүдийг хэрхэн ашигалх талаар журмад зааж мөрдөнө. Мдээлэл дамжуулах гол зорилго үйл ажллагааг эбв явуулахад үүсэх эрсдэл, аюулыг урьдчилан тогтоож, бүртгэж мэдээлэн засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явдал юм.

Төвийн үндсэн байранд дотод сүлжээ ажиллан алба, тасгууд шаардлагатай үед холбогдож асуудлыг шийдвэрлэнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 66/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Даваа гараг бүр эмч, мэргэжилтнүүдийн шуурхай зөвлөгөөн хийн өнгөрөн 7 хоногт хийсэн ажил шинэ 7 хоногт хийх ажлын мэдээлэл солилцоно.

Албаны дарга, тасгийн архлэгч нар шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцсэн асуудал, мэдээллийг хамт олондоо мэдээлэх үүрэгтэй. Мөн алба, тасгийн хурлыг тогтмол хугацаанд хийн протокол хөтөлж баримтжуулна.

Төвийн захирлын шийдвэрээр бүх ажилчдын хурлыг жилд 1-2 удаа зохион байгуулна. Энэ хурлаар хийсэн ажлын тайлан тавьж, цаашдын хэрэгжүүлэх ажлын зорилтыг мэдээлнэ.

7.5 Баримтжуулсан мэдээлэл

7.5.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ-ийн чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд дараах мэдээлэл багтана. Үүнд:

- a) Төвийн чанар, ХЭМБ-ын гарын авлага, ISO 9001:2015, ISO 45001:2016 стандартад заагдсан мөрдөж хадгалах, хөтөлж хадгалах зэрэг чанарын гарын авлага баримтжуулсан мэдээлэл
- b) ЭМ-ийн байгууллагад мөрдөх хууль, ЦССҮТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандарт, ЭМ-ийн сайдын цусны аюулгүй байдалтай холбоотой баталсан зааврууд, Төвийн ерөнхий захирлын тушаалаар баталсан журам, САЗ, ТТАЗ, АЗ, маягт, хяналтын хуудасууд, үйл ажиллагааны болон тоон үзүүлэлтийн төлөвлөгөө, тайлан, аудитын зөвлөмж, тайлан, хэрэгжүүлсэн арга хэмжээний нотолгоо, алдаа, эрсдлийн бүртгэл засч сайжруулсан арга хэмжээ, санал хүсэлтийн дүн, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан зэргийг мөрдөж, хөтөлж хадгална.

Төвийн хэмжээнд Баримт бичиг боловсруулах, дугаарлах, кодлох, архивлах журам **Ж-ЕР-2-01-03** мөрдөн жишиг загварын дагуу нэгэн жигд байна. Албаны дарга, тасгийн эрхлэгч нар Баримт бичиг хянах журам **Ж-ЕР-2-02-03** мөрдөж холбогдох баримт бичгийг хянаж, шинэчлнэ.

7.5.2 Мээдэлэл бий болгох, шинэчлэх

ЦССҮТ нь баримтжуулсан мэдээлэл боловсруулах журмыг мөрдөж ажиллана. Баримт бичигт дараах зүйлсийг тодорхой болгоно. Баримт бичгийн бүтэц, агуулагдахууныг тодорхойлсон жишиг загвар боловсруулж, төвийн хэмжээнд жигд мөрдөнө. Үүнд:

- a) Баримт бичгийн тэмдэглэгээ, тайлбар /нэр, зохиогч, огноо, дугаар гэх мэт/
- b) Хэлбэр / боловсруулах хэл, програм хангамжийн хувилбар, график, зөөгч цаасан цахим /

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 67/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- с) Баримт бичиг тухайн ажилбар, түвшинд тохирч, зохистой байгаад дүн шинжилгээ хийж баталгаажуулна.

Төвийн хэмжээнд байх баримтжуулсан мэдээлэл ЧМТ, ХЭМАБ-ын стандартын болон ЭМЯ-ны холбогдох шаардлагад нийцүүлэн тодорхойлно. Төвийн хэмжээнд мөрдөх, хөтлөх баримтжуулсан мэдээлэл нь мөрдөж байгаа стандартын шаардлагад нийцсэн **нэг стандарт загвартай** байна.

Алба, тасгийн удирдлага өөрийн хамааралтай үйл явц, ажилбарт 1, 2, 3, 4-р түвшний хэдэн баримтжуулсан мэдээлэл байхыг тодорхойлж түүнийг бүрдүүлж, боловсруулан батлуулж, эмч, мэргэжилтэн, ажиллагсдыг сургаж, мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай өөрчлөлт шинэчлэлт хийж, хянах үүрэг гүйцэтгэнэ.

7.5.3 Баримтжуулсан мэдээллийг хянах

7.5.3.1 Чанарын болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо стандартын дагуу төвд байвал зохих баримтжуулсан мэдээлэл баримт бичгийг дараах зорилгоор хянана. Үүнд:

- а) Алба, тасаг, нэгжийн ажлын байр бүр дээр үйл явц, ажилбар хийхэд мөрдөх холбогдох баримт бичиг хүртээмжтэй, тохиромжтой хэлбэрээр байгаа эсэх,
- б) Зохих хэмжээнд нууцлал, буруугаар ашиглагдахаас, бүрэн бүтэн байдал, алдагдахаас сэргийлэгдсэн эсэх, ажлын байр дээр хүчин төгөлдөр, сүүлийн зөв хувилбар ашиглаж байгаа эхэсийг тус тус хянана.

Баримтжуулсан мэдээлэл баримт бичгийг ажлын байр бүр дээр тохиромжтой хэлбэрээр түгээж баримтжуулахыг алба, тасгийн эрхлэгч, ажлын байран дээр ашиглах, бүрэн бүтэн байлгах, хадгалах, буруугаар ашиглах, нууц алдагдахаас хамгаалах үүргийг тухайн ажлын байран дээр ажиллаж байгаа эмч, мэргэжилтэн, ажиллагсад тус тус хариуцна.

Төвийн чанарын алба, ХЭМАБ-ын зөвлөл холбогдох, албаны дарга, тасгийн эрхлэгчтэй хамтран жилд 1-ээс доошгүй удаа баримт бичгийн хяналтыг хийнэ.

7.5.3.2 Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд байгууллага дараах арга хэмжээнд анхаарал тавина. Үүнд:

- а) Хүчин төгөлдөр баримт бичгийг түгээлтийг хэрхэн хийж баримтжуулсан түгээсэн хэсэг бүрт хүлээн авсан ажилтны нар, гарын үсэг баримтжуулсан байх, ажлын байран дээр байрлуулсан байх, ажиллаж байгаа хүнд ашиглах боломжтой байх, цахимд нэвтрэх эрх, хуучин баримт бичгийг буцаан татсан баримтжуулалт, сэргээх
- б) Ажлын байран дээр зөв хадгалах, аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, гаргацтай байдал

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 68/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- с) Өөрчлөлтийг хянах, хамгийн сүүлийн засвар хийж өөрчилсөн хувилбарыг ашиглаж байгаа байдал, жил бүр хянасан эсэх
- d) Хүчингүй болсон баримт бичгийн нэг хувийг архивлах, бусад хувийг устгасан /хүн ашиглах боломжгүй болгосон байх/ байдал, баримтжуулалт хийсэн байдал

Төвийн Чанарын менежментийн тогтолцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд шаардлагатай **гадны эх үүсвэр бүхий** баримтжуулсан мэдээллийг ялгаж, дугаарлан хянан баримтжуулна.

Баримт бичигт эрх бүхий албаны дарга, тасгийн эрхлэгч, холбогдох мэргэжлийн эмч, мэргэжилтэн завсар хийж протокол хөтлөн баримтжуулна.

Төвийн баримтжуулсан мэдээллийг боловсруулж батлуулахад холбогдох алба, тасаг албан ёсны хэдэн эх хувь байхыг тодорхойлж чанарын албаар баталгаажуулна.

Чанарын алба төвийн хэмжээний бүх баримтжуулсан мэдээллийн мастер жагсаалтыг бүртгэн, нэгтгэж, төвийн захирлаар баталгаажуулна.

Алба, тасаг баталгаажсан, хүчинтэй, шинэчилсэн баримт бичгийн хувилбарыг түгээж баримтжуулалт хөтөлнө. Мөн албаны дарга, тасгийн эрхлэгч нар баталгаажсан хүчин төгөлдөр баримт бичгийн 2-р хувилбарыг сканердэн МТИТ-д хүргүүлж, цахимд байршуулан эмч, мэргэжилтэн, ажиллагсад авч ашиглах боломж бүрдүүлэн ашиглах сургалт зохион байгуулж, аюулгүй байдал, нууцлал, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

Ажлын байран дээр мөрдөж ашиглах баримт бичгийг хадгалах хамгаалах хариуцлагыг эмч, мэргэжилтэн, ажиллагсад хариуцуулж баримтжуулна. 7 хоног, сар, улирлаар ажлын байр солигдон хуваарилагдахад баримт бичиг хүлээлцэж баримтжуулна.

Алба, тасаг хуучин баримт бичгийг хураан авч, бүртгэн, устган баримтжуулна.

Чанарын алба дээр хадгалж байсан баримт бичгийн 1-р албан хувийг архивт өгч баримтжуулна.

8. Ажиллагаа

8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

ЦССҮТ нь цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээг нийлүүлэхэд шаардлагатай үйл явц, ажилбаруудыг төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж, эрсдэл, боломжуудыг тодорхойлон шаардлагатай өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга хэмжээг авна. Төвийн үндсэн цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах түгээх, дэмжих үйл ажиллагаа тоног төхөөрөмжийн суурилуулалт, завсар үйлчилгээ, үйл ажиллагаа

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 69/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

явуулахад шаардлагатай зүйлсийг ханган нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, стратеги төлөвлөлт, санхүү нягтлан бодох, бүртгэл, үйл ажиллагааны тоо мэдээ цуглуулж, тайлан мэдээ гаргаж, боловсруулалт хийх, эмч мэргэжилтэн ажилчдыг сургах, мэргэшүүлэх, судалгаа шинжилгээний ажил эрхлэх, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг зөв уялдуулж зохион байгуулна. Үүний тулд:

- a) Үйлдвэрлэж буй цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна. ЭМ-ийн сайдын 2020 оны 373, тоот, 2017 оны 03 тоот тушаалаар тогтоосон цусны донор, цус, цусан бүтээгдэхүүн, ард иргэдийн цусны бүлэг тодорхойлох, эмнэлгүүдийн хүсэлтээр хийх лавлагаа шинжилгээнд тавигдах шаардлагыг хэрэгжүүлж ажиллана. Үйлдвэрлэж буй ЦЦБ, үйл ажиллагаанд шаардагдах хүүдий оношлуур, хэрэгсэлд тавигдах шаардлага, төвийн эмч, ажилчдад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байна.
- b) Дээрх шаардлагыг хэрэгжиж байгааг үнэлэх шалгуурыг тогтоон хянаж байна. Үүнд:
 1. Үйл явцын шалгуур - Төвийн үндсэн болон дэмжих үйл явцын эцсийн бүтээгдэхүүн бүрийн шалгуурыг тодорхойлж тэр явцыг гүйцэтгэсэн алба, тасаг хянаж, баримтжуулна.
 2. Бүтээгдэхүүн үйлчилгээг хүлээж авах шалгуур, төвийн алба, тасгууд өөрийн үйл явцын орцыг хүлээн авах шалгуурын дагуу шалган хүлээн авч баримтжуулалт хөтөлнө. Шаардлага хангаагүй тохиолдолд шалтгааныг нотолгооны хамт орцыг нийлүүлсэн алба, тасагт мэдэгдэнэ. Бүтээгдэхүүн, үйлчилгээний техникийн стандартыг хэрэгжүүлж ажиллана.
- c) Бүтээгдэхүүн үйлчилгээнд тавих шаардлагыг хангахад хэрэгцээтэй нөөцийг тодорхойлсон байна. Төвийн алба, тасгууд өөрийн хариуцах үйл явц, ажилбарыг зөв, чанартай хийхэд шаардагдах нөөцийг тодорхойлж, бэлэн байдлыг хангана. Хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад дагалдах хэрэгсэл зэрэг нөөцүүдийг тодорхойлж бэлэн байдлыг хангана.
- d) Үйл явц, ажилбаруудыг шалгуурын дагуу хянана Төвийн алба, тасгууд хийж буй үйл явц, ажилбаруудын шат дамжлага, хяналтын эгзэгтэй цэгийг тогтоон тухай бүр шалган баримтжуулна. Чанарын хяналт хийж баримтжуулна.
- e) Төвийн алба, тасаг нэгжүүд дараах зорилгоор баримтжуулсан мэдээллийг шаардлагын хэмжээнд тодорхойлж, хадгална. Үүнд:
 1. Үйл явц, ажилбар төлөвлөсний дагуу дагуу явагдсанд итгэлтэй байхын тулд бүх үйл ажиллагааг бүрэн баримтжуулж, хадгална. Мөн шаардлагатай үед мөшгөн тогтоох боломжтой байлгах, мөн 10 жилийн дараа ч асуудал гарахад архиваас сэргээн үзэх боломжтой байлгах
 2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ тавигдаж байгаа шаардлагад нийцэж байгааг харуулах, нотлохын тулд баримтжуулсан байна. Өөрийн үүрэг хариуцлагын дагуу хийж гүйцэтгэсэн үйл явц, ажилбар бүрийн үе шат, шат дамжлагын хяналт шалгалтыг багтаасан

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 70/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

баримтжуулалт хөтөлж, хадгална. Ямар баримтжуулалт хөтөлж байхыг холбогдох САЗ, ТТАЗ, АЗ-т тодорхой тусгаж өгнө.

Тухайлбал цуглуулсан цус, эс, сийвэнгийн нэгж бүрд хийсэн халдвар илрүүлэх болон бүлэг тодорхойлох, чанарын хяналтын шинжилгээ хийгдсэн, хийсэн шинжилгээ зөв үр дүн гаргасан тухай нотлох баримтжуулалт хийж хадгална.

Төвийн үйл явц, ажилбарын төлөвлөлтийн эцсийн үр дүн нь төвийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийн боломжид тохирсон байна. Тухайлбал тоног төхөөрөмж эвдэрвэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурна. Иймд эвдэрхээс сэргийлж ажиллах хэрэгтэй болно.

ЦССҮТ төлөвлөсөн өөрчлөлтүүдийг хянах, санамсаргүй өөрчлөлтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх, сөрөг нөлөөг аль болох бууруулах арга хэмжээ авч ажиллана. Хэрэв үйл ажиллагаа өөрчлөгдвөл өөрчлөгдсөнөөс үүдэх үр дагавар бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний чанарт нөлөөлөх нөлөөллийг үнэлнэ.

ЦССҮТ гаднаас нийлүүлж буй, гадны байгууллагаар гүйцэтгүүлж буй бүх үйл явц, ажилбарыг тодорхойлон хянаж, хяналтандаа байлгана. Тухайлбал фракцинацид сийвэн илгээхэд ямар шаардлага нөхцөл тавигдах, үйлдвэрлэлийн ямар арга хэрэглэж байгааг мэдэж, хянах хэрэгтэй болно.

8.1.2. Аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах

Төв нь дараах шаталсан хяналтыг хэрэглэх замаар аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулахууд үйл явцуудыг бий болгох, хэвтрүүлэх ба хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Аюулыг арилгах
- b) Аюул багатай түүхий дэ, үйл явцууды, ажиллагаа эсвэл тоног төхөөрөмж оруулах
- c) Инженерингийн хяналт ашиглах ба эсвэл ажлыг өөрчлөн зохион байгуулах
- d) Захиргааны хяналт хэрэгжүүлэх, энд ХЭМАБ-ын сургалт хамаарна
- e) Тохиромжтой хувийн хамгаалах хэрэгсэл ашиглана.

Онцгой байдлын бэлэн байдал ба хриу арга хэмжээ

Төв нь олж тогтоосон онцгой байдалд бэлдэх, хариу арга хэмжээ авах үйл явцуудыг бий болгож нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Онцгой байдлын нөхцөлд авах төлөвлөсөн хариу арга хэмжээг бий болгох
- b) Төвөлсөн хариу арга хэмжээг үе үе турших, дадлага хийх
- c) Гүйцэгэлийн үнэлгээ хийх, шаардлагатай үед болон туршилтын дараа төлөвлөсөн арг хэмжээг хянаж үзэх

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 71/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- d) Бүх ажилчдад тэдгээрийн үүргэ, хариуцлагын талаар холобгдох мэдээллээр хагах ба мэдээлж таниулах
- e) Төлөвлөсөн хариу арга хэмжээний талаар сургалт хийх
- f) Холбогдох мэдээллийг гэрээтүүд, зочид, онцгой байдлын үйлчилгээ рхэлгчид, ЗГ байгууллагуудад мэдээлэх
- g) Холобгдох сонирхогч талуудын чадвар ба хэрэгцээг авчүзэх, хариу арга хэмжээ төлөвлөхөд тэдгээрийг оролцуулах

Төв нь блонжит онцгой байдал хариу арга хэмжээ авах төлөвлөгөө ба үйл явцуудын талаар баримтжуулсан мэдээллийг мөрдөж, хөтөлж хадгална.

8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага

8.2.1 Хэрэглэгчтэй тогтоох холбоо харьцах

ЦССҮТ нь үйлчүүлэгч, хэрэглэгчид зориулсан үйлчилгээ явуулна. Хэрэглэгчтэй тогтоох холбоо харилцаанд:

- a) Харилцагч эмнэлэг, эмч, мэргэжилтнүүдэд цус, цусан бүтээгдэхүүн тэдгээрийн агуулагдахуун, захиалга хийх, захиалсан бүтээгдэхүүн бэлэн болох хугацаа, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, ард иргэд, үйлчлүүлэгчид хийгдэх шинжилгээний төрөл, үр дүн, хариуны талаар мэдээлэл өгөх, цусны доноруудад сайн дурын авлагагүй тогтолцоо, цус өгөхөд бэлтгэх, асуумж үнэн, зөв, бүрэн бөглөх, эмчийн үзлэг хийж эрүүл мэндийг хянах, цус, сийвэн цуглуулах, цус өгсний дараа сахих дэглэм, сорьц авч шинжилгээ хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэн эмнэлэгт өвчтөнд хэрэглэдэг, шинжилгээний хариугаа хэрхэн авч дараа дахин цус өгөх хугацааг мэдэх тухай мэдээллээр тус тус хангаж ажиллана.
- b) Цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад лавлагаа авах, гаргах, гэрээ байгуулах, гэрээ, захиалганд өөрчлөлт гарвал мэдэгдэнэ. Хэрхэн хэзээ, хэн мэдэгдэх тухай журам, САЗ-д тодорхой тусгаж өгнө. Цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх талаар харилцагч эмнэлгүүдтэй, донорын сургалт, сурталчилгаа хийх сайн дурын ажилтан бэлтгэх талаар МУЗН, ДШУЗХ-той, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх талаар ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулж, үр дүнг үнэлж ажиллана.
- c) Хэрэглэгчид нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг олон хэлбэрээр тогтмол авч, дүгнэн, сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- d) Төвөөс тусламж, үйлчилгээ авч байгаа бүх хэрэглэгчийн өмчтэй зөв харьцан, хянаж, хамгаална. Тухайлбал: цусны донор, үйлчлүүлэгч ард иргэд, эмчлүүлэгчийн гадуур хувцас, хувийн хэрэгсэл, машин, эмнэлгийн машиныг зогсоолд байх үед нь хамгаалах, тээвэрлэлтийн сав, эмнэлэгт бүтээгдэхүүн хадгалж байгаа хөргөгч, хөлдөөгчийг хянах зэрэг орно.
- e) Тусламж үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчтэй холбоотой гарсан гэнэтийн тохиолдолд /нэн яаралтай, гамшиг тохиолдсон үед/ шаардлагатай бол авах арга

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 72/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

хэмжээний тусгай шаардлагыг тогтоон холбогдох журам, САЗ-д тодорхой тусгаж өгнө.

8.2.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах шаардлагыг тодорхойлох

Төвийн үйлдвэрлэж байгаа цус, цусан бүтээгдэхүүн, үзүүлж буй тусламж үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлохдоо дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- a) Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоосон
 1. Монгол улсын “Донорын тухай” хууль, ЭМ-ийн тухай хууль, ЭТ-ийн тухай хууль, ЭМ-ийн сайдын холбогдох зааврын шаардлага, сайн дурын авлагагүй донороос цус, сийвэн, эс цуглуулах, халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох шинжилгээг бүрэн хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зөв хадгалах, тээвэрлэх, эмнэлэгт олгох, цусны албаны бүтэц, үйл ажиллагааны болон цус, цусан бүтээгдэхүүнд тавигдах чанарын болон техникийн шаардлага, ISO 9001: 2015, 45001:2016 стандартын шаардлагууд хамаарна
 2. ЦССҮТ-өөс нэмэлтээр тавьж буй шаардлага тус тус хамаарна. Тухайлбал: Рентген туяагаар шарах, эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэхэд нэмэлтээр тавигдах шаардлагууд орно.
- b) Төв өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар гаргаж байгаа санал гомдлыг шийдвэрлэх нөхцөлийг хангаж нотолгоо гаргана. Тухайлбал бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдах, гемолиз болсон үед асуудлыг шийдвэрлэж чадах нотолгоог гаргасан байна.

8.2.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах шаардлагад дүн шинжилгээ хийх

8.2.3.1 ЦССҮТ нь Эмнэлгийн байгууллага, ард иргэдэд санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, холбогдох чанарын болон техникийн стандартын шаардлагыг хангах чадвартай байх нөхцөлийг хангаж ажиллана. Төв үйл ажиллагаа явуулах эрх, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн байна.

Төв цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээг хэрэглэгчид нийлүүлэх шийдвэр гаргахаас өмнө дараах шаардлагуудыг хянаж үзнэ. Үүнд:

- a) ЦЦБ-ийг эмнэлэгт олгох үед болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн дараах шаардлага бүхий хэрэглэгчийн тогтоосон шаардлага ЦЦБ олгох үйл явц, САЗ-т ямар шалгуур үзүүлэлтээр хэрхэн шалгаж хянах тухай тодорхой тусгаж, мөрдөж ажиллана. Бүтээгдэхүүн захиалах, хүлээн авсны дараа хэрхэн зөв харьцаж, хадгалж, тээвэрлэх талаар эмнэлгүүдтэй хийх гэрээнд тусгаж өгнө.
- b) Хэрэглэгч тогтоогоогүй боловч тусгай төлөвлөсөн хэрэглээнд хамаарах нь тодорхой шаардлага- Өвөрмөц бүтээгдэхүүнд тавигдах шаардлага орно. Тухайлбал нэгтгэж савласан криопресипитат, ялтаст эсийн өтгөрүүлгийн хүчинтэй хугацаа, хадгалах нөхцөл зэрэг хамаарна.
- c) Төвөөс тогтоосон шаардлага- захиалга хүлээн авах, бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах нөхцөл хамаарна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 73/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- d) ЦЦБ, тусламж, үйлчилгээнд хамаарах хууль, тогтоомжийн шаардлага ЭМ-ийн сайдын 2020 оны 373, 2017 оны 03 тоот тушаалаар батлагдсан шаардлагууд хамаарна.
- e) Гэрээ буюу захиалгад өмнө нь зааснаас өөр шаардлага зэргийг хянаж үзсэн байна. Тухайлбал эмнэлэг бүхэл цус захиалбал яагаад захиалга хийх болсон, өөр бүтээгдэхүүн санал болгох зэрэг зохистой зөв хэрэглээг зөвлөмж болгоно. Захиалга тодорхой бус эсвэл өвөрмөц үед захиалагчтай заавал холбогдож тодруулга авна. Утсаар захиалга авсан үед факс, мэйлээр авч баталгаажуулна.

ЦССҮТ нь гэрээ буюу захиалгад өмнө нь зааснаас өөр шаардлагыг шийдвэрлэсэн байх нөхцөлийг хангана.

Хэрэглэгч нь шаардлагаа баримтжуулж өгөөгүй тохиолдолд ЦССҮТ хэрэглэгчийн шаардлагыг хүлээж авахаас өмнө баталгаажуулна.

8.2.3.2 ЦССҮТ нь ЦЦБ-ийг хорионоос чөлөөлж, эмнэлэгт олгохдоо дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Үүнд:

- a) ЦЦБ- ний шаардлагыг хянаж, тодорхойлсон үр дүн хийгдсэн халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох, чанарын хяналтын шинжилгээний баталгаажсан үр дүнг хянаж, шаардлагад нийцсэн тохиолдолд хорионоос чөлөөлөх
- b) ЦЦБ- ний аливаа шинэ шаардлагатай холбогдсон баримтжуулсан мэдээллийг тус тус хөтөлж, хадгална. Туяагаар шарах, автомат аргаар угаах, нэгтгэн болон жижиглэн савлах зэрэг нэмэлт шаардлагууд орно.

8.2.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад орсон өөрчлөлт

ЦССҮТ нь ЦЦБ, тусламж, үйлчилгээний шаардлага өөрчлөгдсөн бол баримтжуулсан мэдээллийг өөрчилж, холбогдох ажилтныг энэ тухай мэдээллээр хангасан байна. Тухайлбал улаан эсийг даршлах уусмал өөрчлөгдсөн тухай мэдээллийг үйлдвэрлэгч, хэрэглэгчид тус тус өгч баримтжуулна.

Төвийн бүх үйл ажиллагаанд мөрдөх САЗ, ТТАЗ, АЗ-т өөрчлөлт орсон тухай бүр баримт бичгийг хянан өөрчилж, батлуулан холбогдох эмч, мэргэжилтнүүдэд сургалт хийн танилцуулж, хэрэгжилтэнд албаны дарга, тасгийн эрхлэгч нар хяналт тавьж ажиллана.

8.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт хийх

8.3.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ нь цус, цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээнд дагалдах үйлчилгээг хангасан шинэ бүтээгдэхүүн, арга аргачлал боловсруулахад дизайн гаргах болон шинэ боловсруулах үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөнө. Төв үйлдвэрлэж байгаа цус, цусан бүтээгдэхүүн үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж үйлчилгээг олон улсын сайн туршлага, эмнэлгийн техник технологийн дэвшилтэд

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 74/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

тулгуурлан шинэ арга аргачлал боловсруулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дизайн боловсруулна.

8.3.2 Дизайн ба боловсруулалтыг төлөвлөх

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн, боловсруулалтын үе шатыг тодорхойлж, хянахын тулд дараах баримтжуулсан мэдээллийг авч үзнэ. Үүнд:

- a) Шинэ бүтээгдэхүүний дизайн боловсруулалтын мөн чанар, үргэлжлэх хугацаа, бэрхшээлийг авч үзнэ. Бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, холбогдох хууль, стандарт, журмын шаардлагад нийцүүлэн сайжруулж, шинэчлэн боловсруулах учир шалтгаан, энэ өөрчлөлт, сайжруулалтыг хийхэд зарцуулах хугацаа, учирч болох бэрхшээл
- b) Шинэ бүтээгдэхүүн боловсруулалт, дизайн боловсруулалтыг хийхэд шаардлагатай үйл явц, үе шатуудыг тодорхойлж, САЗ, ТТАЗ боловсруулна.
- c) Дизайн боловсруулалтыг шалгах, баталгаажуулах үйл ажиллагаа- шинэ бүтээгдэхүүн болгонд дизайн загвар хийж, шинэ үзүүлэлтээр зөвшөөрөх хэмжээг тогтооно.
- d) Дизайн боловсруулалтад хамаарах хариуцлага, эрх мэдэл Тоног төхөөрөмж, сургалт, мэдээллийн технологи, цахим сүлжээг тодорхойлно.
- e) Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн гаргах, боловсруулахад шаардлагатай гадаад болон дотоод нөөцийг тооцож үзнэ.
- f) Дизайн гаргах, боловсруулах үйл явцад оролцож байгаа ажилтнуудын уялдаа холбоог хянах хэрэгцээ /ЦЦБ үйлдвэрлэл, шинжилгээнд оролцох, бүтээгдэхүүнийг хэрэглэх эмч, мэргэжилтнүүд хэрхэн зөв харилцан ажиллах/
- g) Хэрэглэгч болон үйлчлүүлэгчдийг дизайн гаргах, боловсруулах үйл явцад оролцуулах хэрэгцээ- цусны доноруудаас шинэ аппарат, тоног төхөөрөмжөөр ЦЦБ цуглуулах, эмнэлгүүдэд зөв оновчтой хэрэглээний талаар мэдээлэл өгнө. Эмнэлгийн ЦСЗЗ- тэй хамтран ажиллана.
- h) Бүтээгдэхүүн үйлчилгээний дагалдах үйлчилгээнд тавих шаардлага- шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай мэдээлэл хийх, сурталчлах хадгалалт, тээвэрлэлт, сэлбэлтэд тавигдах нэмэлт шаардлага тогтоож мэдээлэх
- i) Дизайн гаргах, боловсруулах явцад хэрэглэгч бусад холбогдох сонирхогч талаар хийлгэх, хяналтын түвшин - эмч нар шинэ бүтээгдэхүүнийг хэрэглээд үр дүнг эргэн мэдээлэх, хэрэглээтэй холбоотой үр дүнг холбогдож авах
- j) Шинэ бүтээгдэхүүн дизайн гаргах, боловсруулахад тавих шаардлага хангасныг нотлох баримтжуулсан мэдээлэл зэрэг багтана. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний боловсруулалтын үе шат бүрийг бүрэн баримтжуулж, хадгална.

8.3.3 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын оролтууд

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн гаргах, боловсруулах гэж буй онцлог төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах зайлшгүй шаардлагыг тодорхойлно. Үүнд:

- a) Чиг үүргийн болон гүйцэтгэлийн шаардлага

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 75/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- b) Өмнө нь хийж байсан ижил төстэй дизайн боловсруулалтын талаарх мэдээлэл
- c) Хууль тогтоомжийн шаардлага
- d) Төвийн мөрдөх стандарт ба зохистой дадлын дүрэм
- e) Бүтээгдэхүүн, үйлчилгээний мөн чанараас хамааран гарах магадлалтай гологдол гарахаас сэргийлэх- нээлттэй арга, нянгийн бохирдол гэх мэтээс сэрэмжлэх

Дизайн боловсруулалтын орц нь хангалттай, иж бүрэн, давхардаагүй товч, тодорхой байна.

Дизайн боловсруулалтын зөрчилтэй орцыг шийдвэрлэнэ. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гаднаас авах нэмэлт хүүдий, уусмал зэрэг нь чанарын шаардлага хангаж байгааг нотолно.

ЦССҮТ нь дизайн боловсруулалтын орцын талаарх баримтжуулсан мэдээллийг хадгална.

8.3.4 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын хяналт

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүн боловсруулах дизайн гаргах, боловсруулах үйл явцын талаар дараах баримтжуулсан мэдээллийг хадгалж, хянана. Шинэ бүтээгдэхүүн гарахдаа эцсийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт ямар байх, шат дамжлагын хяналтын эгзэгтэй цэгүүдийг тодорхойлж, шалган хянаж, баримтжуулсан байна. Мөн шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэх арга, технологи, ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэх хүүдий, уусмал, чанарын хяналт хийх шинжилгээний арга бүгд баталгаажсан байна. Баталгаажуулалт хийх САЗ –ыг мөрдөн хянаж, үр дүнг баримтжуулсан байна. Шинэ бүтээгдэхүүн боловсруулахад дараах үйл явцын хяналт хийн баримтжуулна. Үүнд:

- a) Шинэ дизайн гаргаж боловсруулснаар хүрэх гэж буй үр дүнг тогтоох
- b) Шинэ дизайн боловсруулалтын үр дүн шаардлага хангах чадвартайг үнэлэх зорилгоор хянаж, үзэх
- c) Дизайн боловсруулалтын гарц нь орцын шаардлагыг хангасныг нотлох зорилгоор шалгалтын үйл ажиллагаа явуулсныг
- d) Эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтын болон тодорхой хэрэглээний шаардлагыг хангаж байгааг тодорхойлохын тул баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулсныг
- e) Хянаж үзэх, шалгах, баталгаажуулах явцад гарсан аливаа асуудлыг шийдвэрлэх
- f) Эдгээр арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хадгалж, эрх мэдэлдээ байлгах нөхцөлийг хангах зорилгоор хянана.

8.3.5 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын гаралт

ЦССҮТ нь шинэ бүтээгдэхүүний дизайн, боловсруулалт хийх үйл явцын гаралтын талаар дараах баримтжуулсан мэдээллийг хадгалж, хянана. Үүнд:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 76/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- a) Орцын шаардлагыг хангасан байдлыг нотлох
- b) Бүтээгдэхүүн, үйлчилгээний дагалдах үйлчилгээнд тохирсон байх
- c) Байнгын хяналт, хэмжилтийн тохиромжтой шаардлага болон хүлээж авах шалгуурыг тусгах буюу иш татах, Шинэ бүтээгдэхүүний шинж чанарыг тодорхойлж, зөвшөөрөх хэмжээг тогтоосон байна.
- d) Бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтанд нийцэх, зөв аюулгүй байдалд нэн чухал үзүүлэлтийг тогтоох зэрэг хамаарна.

8.3.6 Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт

ЦССҮТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагын тохиролд сөрөг нөлөөгүй байдлыг хангах хэр хэмжээнд, шинэ бүтээгдэхүүний дизайн боловсруулалт хийх явцад эсвэл дараа нь гарсан өөрчлөлтийг тогтоож, дүн шинжилгээ хийж, хянана. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад ямар шинэ хэрэгсэл уусмал орох, энэ нь чанар хангасан байх, үе шат дамжлагад өөрчлөлт орсон байдлыг үнэлнэ.

ЦССҮТ дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a) Дизайн, боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт
- b) Хяналтын дүн шинжилгээний үр дүн
- c) Өөрчлөлт хийх зөвшөөрөл төвийн удирдлага, чанарын албанаас зөвшөөрөл авч хадгална.
- d) Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ зэрэг хамаарна. Хадгалалт, тээвэрлэлт болон бусад зүйлд нэмэлтээр орсон өөрчлөлтийг хөтөлж хадгална.

8.4 Гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт

8.4.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ нь гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлно. Гаднаас авч байгаа бүтээгдэхүүнд импортоор болон хандив тусламжаар авч байгаа цус бүлэгнэлтийн 8, 9-р факторууд, альбумин, иммуноглобулин зэрэг орно. Төв гаднаас авч буй бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээнд тавих хяналтыг дараах тохиолдолд тодорхойлно. Үүнд:

- a) Гаднаас авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээг төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нэгтгэх бол
- b) Хэрэглэгчид шууд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг гадны нийлүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс хийж байгаа тохиолдолд
- c) Үйл явц болон түүний хэсгийг байгууллагын шийдвэрийн дагуу гадны нийлүүлэгч гүйцэтгэж байгаа тохиолдолд тус тус хянана.

Гадны нийлүүлэгчийн шаардлагын дагуу үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээг хангах чадварт үндэслэн гүйцэтгэлийг үнэлэх, сонгох, хянах, дахин үнэлэх шалгуурыг ЦССҮТ тодорхойлж хэрэглэнэ. Төв эдгээр үйл ажиллагаа болон

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 77/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

үнэлгээний дүнгийн дагуу хийсэн шаардлагатай арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хадгална.

Худалдан авах гэрээнд ямар шаардлага тавихыг тодорхой тусгаж баримтжуулна. Бүтээгдэхүүний цуврал бүрийн чанарын сертификат чухал ач холбогдолтой. Хэрэглээний дараа эмчилгээний үр дүн ямар байгааг эмч нараас цуглуулан хянаж, хадгална.

ЦССҮТ -ийн гадны нийлүүлэгчид цусны донор, ханган нийлүүлэгч байгууллага орно.

8.4.2 Хяналтын төрөл ба хэмжээ

ЦССҮТ гаднаас авч буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өөрийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд тууштай хүргэх чадварт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангана. Төвийн чанарын болон техникийн стандартад гадны бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхой тусгаж өгнө.

ЦССҮТ дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) Гаднаас нийлүүлж байгаа үйл явц, цусны донорууд болон ханган нийлүүлэгч нь чанарын менежментийн тогтолцооны хяналтад байлгана.
- b) Цусны донор, ханган нийлүүлэгч байгууллага болон түүний гаргаж байгаа гаралтын аль алинд нь зориулсан хяналтыг тогтооно
- c) Дараах асуудалд анхаарна. Үүнд:
 1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчийн болон хууль тогтоомжийн шаардлагыг тууштай хангах талаарх байгууллагын чадварт гаднаас нийлүүлж байгаа үйл явцад үзүүлэх боломжит нөлөөлөл,
 2. Гадны нийлүүлэгчдийн хэрэглэж байгаа хяналтын үр нөлөөтэй байдлыг тус тус анхаарна.
- d) Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлага хангаж байгааг нотлох шалгалт буюу бусад үйл ажиллагааг тодорхойлох асуудлыг тус тус шийдвэрлэнэ.

Гаднаас нийлүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүний эцсийн хариуцлагыг ЦССҮТ хариуцна. Иймд гаднаас нийлүүлж цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хэрэглэж байгаа цусны хүүдий, оношлуур, кит бусад бүх хэрэгслийн чанарын баталгааг бүрэн авч хянана. Тухайлбал үйлдвэрлэгчийн олон улсын чанарын сертификат, бүтээгдэхүүний цуврал бүрийн чанарын сертификат, холбогдох хяналтын байгууллагын шинжилгээний үр дүн, шийдвэр гэх мэт

8.4.3 Гадны нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл

ЦССҮТ гадны нийлүүлэгч болох донор, ханган нийлүүлэгчидтэй холбогдохоос өмнө тавих гэж байгаа шаардлага тохиромжтой байх нөхцөлийг хангана. Төв дараах шаардлагыг гадны нийлүүлэгчид мэдээлнэ. Үүнд:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 78/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- a) Нийлүүлэх үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар
- b) Мөн доорх зүйлийг батлах тухай үүнд:
 - 1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ
 - 2. Арга, үйл явц, тоног төхөөрөмж
 - 3. Бүтээгдэхүүн гаргах, үйлчилгээ үзүүлэхийг батлах
- c) Ажилтнуудын чадамж, түүний мэргэшсэн байдал
- d) Гадны нийлүүлэгчтэй төв харилцах харилцаа ямар бүтээгдэхүүн үйлчилгээ авах урьд байсныг хэрхэн сайжруулж байгааг ойлгуулах төвөөс гадны нийлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ
- e) Гадны нийлүүлэгчийн гүйцэтгэлийг төвөөс хянах мониторинг хийх – нийлүүлэлт хэрхэн хийгдэж байгаа хугацаа, бүтээгдэхүүний чанар, нийлүүлэх үйлчилгээ хир зэрэг байгааг үнэлэх
- f) Гадны нийлүүлэгчийн байранд төвөөс эсвэл тэдний хэрэглэгчийн зүгээс хийх шалгалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд хамаарах шаардлагыг гадны нийлүүлэгчид тус тус мэдээлнэ.

Тухайлбал: Цусны хүүдийн хэдэн төрөл тэдгээр нь ямар өвөрмөц шаардлага хангасан байхыг төв эхлэн зөв тодорхой, нарийн тусгаж тендерийн материалд тусгасан байна. Эдгээр өвөрмөц шаардлагууд ханган нийлүүлэгчид ойлгомжтой байх хэрэгтэй.

8.5 Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх

8.5.1 Үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ үзүүлэх ажлын хяналт

ЦССҮТ нь ЦЦБ-ний үйлдвэрлэл, тусламж, үйлчилгээг хяналттай нөхцөлд гүйцэтгэнэ. Хяналттай нөхцөлд дараах зүйлсээс аль тохирохыг нь хамааруулна. Үүнд:

- a) Дараах баримтжуулсан мэдээллийг бэлэн байлгана. Үүнд
 - 1. Үйлдвэрлэх гэж байгаа бүтээгдэхүүн, үзүүлэх гэж буй тусламж, үйлчилгээ, гүйцэтгэх гэж буй ажлын үзүүлэлтүүд. Төв цусан бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний үзүүлэлтийг тодорхойлж хийх хяналтыг САЗ-д тусган мөрдөнө.
 - 2. Хүрэх үр дүнгийн талаар - бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний чанарыг тодорхой үзүүлэлтээр хянасан бол 4-р шатны маягт хөтөлж баримтжуулна.
- b) Хяналт хэмжилтийн зохих нөхцөлийг бэлэн байлгах, ашиглах тухайлбал термометрээр тээвэрлэлтийн хэмийг, оношлуурын чанарыг стандарт загвараар тус тус хянаж болно.
- c) Гаралтын явцыг хянах шалгуур болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авах шалгууруудыг хангаж байгааг үйл ажиллагааны холбогдох үе шатуудад байнгын хяналт, хэмжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар шалгах – чанарын хяналт, рН метр, баталгаажилтийн калибровка хийх зэргээр
- d) Үйл явцыг хэрэгжүүлэхэд тохиромжтой дэд бүтэц ба орчныг ашиглах- чийгшил, температур, жижиг биенцэрийн тоо гэх мэт

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 79/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- е) Шаардлагатай мэргэшил бүхий ур чадвартай ажилтныг томилох, ур чадвартай ажилтныг сонгох нь чухал
- ф) Байнгын хяналт, хэмжилтийн аргаар гаралтыг нь шалгах боломжгүй үйлдвэрлэл болон үйлчилгээний үйл явцууд нь төлөөлсөн үр дүнд хүрэх чадварыг баталгаажуулах, тодорхой давтамжтайгаар дахин баталгаажуулах – Тоног төхөөрөмжийг тодорхой давтамжаар баталгаажуулна. Үйлчилгээг хэмжих хэцүү зөвхөн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжаар хэмжиж болно.
- г) Эмч, мэргэжилтэн, ажиллагсдыг алдаа гаргахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх- тасралтгүй сургалтыг зохион байгуулах нь их чухал. Алдаа, үл тохирлыг хэзээ ч нууж болохгүй нэн даруй шат дараалан мэдээлж, засч, сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ойлголтыг ажилтан бүрд сургалтаар өгч, мөрдүүлж, ажиллах. Өөрийн болон бусдын үйл ажиллагаанд давхар хяналт хийх ач холбогдлыг мэдүүлэх нь онцгой ач холбогдолтой.
- н) Боловсруулж, бэлэн болгох нийлүүлэх болон нийлүүлэлтийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

8.5.2 Тэмдэглэгээ ба мөшгөх боломж

ЦССҮТ нь төвийн хэмжээнд мөрдөж байгаа болон олон улсын стандартын шаардлагад бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдлыг илэрхийлэхэд шаардлагатай гаралтуудыг тодорхойлох үйл явцын аргыг хэрэглэнэ. Үйл ажиллагаанд цахим бүртгэл, сүлжээ системийг бүрэн нэвтрүүлж ажиллана.

Үйлдвэрлэл явуулах болон үйлчилгээ үзүүлэх явцад хийгдэж байгаа хяналт, хэмжилтийн шаардлагад хамаарах гаралтуудын байдлыг тодорхойлно.

Мөшгөх боломжтой байхыг шаардсан тохиолдолд байгууллага гаралтын өвөрмөц тэмдэглэгээг хийж, мөшгөх боломжийг хангахад шаардлагатай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Тухайлбал: ЦЦБ эмнэлэгт олгохдоо халдвар илрүүлэх болон бүлэг тодорхойлох шинжилгээ хийгдэн зөв хариу гарсан тохиолдолд бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгоно. Давхар хяналт баримтжуулалт хийгдсэн байна. Донороос цус авахуулаад цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгох хүртэлх бүр үйл явц, ажилбар бүрэн баримтжуулагдан бүтээгдэхүүн бүр дахин давтагдахгүй дугаараар дугаарлагдсан байна. Баримтжуулалтын тогтолцоо зөв нэвтэрч, хөгжсөн тохиолдолд ямар ч нөхцөлд мөшгөн тогтоох боломж бүрдсэн байна.

8.5.3 Хэрэглэгч болон гадны нийлүүлэгчийн өмч

ЦССҮТ өөрийн хяналтанд байгаа эсвэл ашиглаж байгаа хэрэглэгчийн болон гадны нийлүүлэгчийн өмчийг хамгаална.

ЦССҮТ нь хэрэглэгчийн болон гадны нийлүүлэгчийн өмчийг өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эсвэл нэгтгэх гэж байгаа бол түүнийг тэмэглэж, шалгаж, хамгаалах ба хөнөөлөөс сэргийлнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 80/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Хэрэглэгч болон гадны нийлүүлэгчийн өмч алдагдах, гэмтэх эсвэл ашиглах боломжгүй болгоход хүргэсэн бол байгууллага энэ тухай хэрэглэгч буюу гадны нийлүүлэгчид мэдээлж, болсон явдлын тухай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Цусны донор, эмнэлгийн эмч, мэргэжилтэн, өвчтөн, лавлагаа шинжилгээ хийлгүүлж байгаа үйлчлүүлэгч иргэд гадны нийлүүлэгч, хэрэглэгч болно. Тухайлбал донороос цус, сийвэн авахын өмнө арьс ариутгах үйл ажиллагаа арга ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлбэл нийлүүлэгчийн эрүүл мэнд алдагдана. Иймд бид үүнээс сэргийлж ажилна.

Цусны донорын эрүүл мэндийн асуудал хэрэглэгчийн өмчид хамаарна. ЦССҮТ нь эрүүл мэндийн байгууллагын учир үйлчлүүлэгчийн хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллүүдийн нууцлалыг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээж ажиллана. Эдгээр мэдээллийг цусны аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор төвийн эмч, мэргэжилтэн ашиглаж болно. Төвийн эмч, тусгай мэргэжилтэн, мэдээллийн технологийн ажилтан бүр төвийн үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийн нууцлалыг хангаж, хамгаалж алдагдахаас сэргийлж ажиллах “Нууцлалын гэрээ” байгуулсан байна. Энэ гэрээний асуудлыг төвийн нууцлалын ажилтан ба хүний нөөцийн мэргэжилтэн хариуцаж, холбогдох баримтжуулалт, шинэчлэлт, өөрчлөлт, баталгаажуулалтыг хийнэ. Донорын хувийн болон эрүүл мэндийн мэдээллийг өөр зорилгоор ашиглах болон нууцлалыг алдагдуулвал холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Донор зохион байгууллалтын тасгийн эмч, сувилагч, нийгмийн болон олон нийттэй харилцах мэргэжилтнүүд цусны донорын хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг авах, бүртгэх, шинэчлэх эрх, үүрэгтэй ба эдгээр мэдээллийн нууцлалыг чанд хадгалах хариуцлагыг давхар хүлээнэ. Мэдээллийг оруулсан, шинэчилсэн, зассан зэрэг хийгдсэн бүх зүйлийг зөв, бүрэн баримтжуулж, мөшгөн тогтоох нөхцөлүүд бүрдүүлж ажиллана.

Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч донорын хувийн болон эрүүл мэндтэй холбоотой бүх мэдээллийг бүртгэх, шинэчлэх, хадгалах, нууцлалыг чанд хадгалах ажиллагааг тасгийн үйл явцын тодорхойлолт, журам, САЗ, АЗ –д тодорхой тусган, хариуцах эмч, ажилтанг маш тодорхой тусган үүрэгжүүлж, ямар ч тохиолдолд мөшгөн тогтоох нөхцөл бүрдүүлсэн байх тогтолцоог хэрэгжүүлж, хянаж, байнга сайжруулж ажиллана.

Төвийн Лаборатори, Технологи, Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн эмч, тусгай мэргэжилтэн, ажилтнууд цусны донорын шинжилгээний үзүүлэлт, шинжилгээний үр дүн, цахим сүлжээн дэх мэдээллийг бүртгэх, шалгах, шинэчлэх, шаардлагатай үед засвар оруулах үйл ажиллагааг МТИТ-ийн цахимд

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 81/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ажиллах журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Дээрхи үйл ажиллагаа бүрийг бүрэн, зөв баримтжуулсан байна.

Төвийн бусад эмч, мэргэжилтнүүд ажлын шаардлагаар цахим сүлжээнээс нэмэлт мэдээлэл авах ажиллагааг төвийн нууцлалын журмаар зохицуулна. Судалгаа шинжилгээний ажилд шаардагдах мэдээлэл олгохыг төвийн захирал зөвшөөрөл олгох ба албаны дарга, тасгийн эрхлэгч нар холбогдох эмч, мэргэжилтнүүдэд мэдээлж, баримтжуулалт хөтлүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

Донор зохион байгуулалтын тасгийн болон төвийн их эмч нар цусны донор цус, сийвэн, эс өгөхөд эрүүл мэндийн талаас шалгуур үзүүлэлтэд тохирч, нийцсэн, эдгээр донороос бэлтгэсэн цусан бүтээгдэхүүн эмчлүүлэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй нотолгоог эмчийн үзлэг, ярилцлага, лабораторийн шинжилгээний үр дүнгээр нотолж, донорын эрүүл мэндийн картанд бичэглэл хийн баримтжуулсан байна. Их эмч үзлэгийн явцад донорт эрүүл аж төрөх ёс, дадал хэвшлийн талаар тогтмол зөвлөгөө өгч ажиллана. Шаардлагатай үед эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, үзлэг, шинжилгээнд илгээн үр дүнг авч хянаж баталгаажуулж ажиллана. ДЗБТ-ийн эмч, нийгмийн ажилтан цусны доноруудад эрүүл аж төрөх ёс, эрүүл амьдралын дадал, хэвшил олгох, эрүүл мэндээ хамгаалах сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

Хэрэглэгч, нийлүүлэгчээс байнга санал хүсэлт авч үнэлж, үйл ажиллагаа, үйлчилгээний орчноо сайжруулах хэрэгтэй.

8.5.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгаалах

ЦССҮТ нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ үзүүлж байх явцад шаардлагын тохирлыг хангах хэмжээнд үйл явцын гаралтуудыг хамгаална. Хамгаалах гэдэгт таних, тэмдэглэгээ хийх, харьцах, бохирдлыг хянах, баглах, хадгалах, шилжүүлэх, дамжуулах, тээвэрлэх, хамгаалах асуудал хамааруулж үзнэ.

ЦССҮТ нь стандартын шаардлагад нийцсэн цус, сийвэн эс, цуглуулах, шинжлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмнэлэгт олгох үйл ажиллагааг явуулна.

8.5.5 Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагаа

ЦССҮТ бүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээнд хамаарах нийлүүлсний дараах шаардлагыг хангана. Цусны донорууд цус, сийвэн, эс өгсний дараах болон ЦЦБ-ийг эмнэлэгт олгосны дараа, бүтээгдэхүүнийг эмчилгээнд сэлбэсний дараах үйл ажиллагаа ЦССҮТ-д хамаарна. Тухайлбал: Улаан эсийн бүтээгдэхүүнийг сэлбэх үед бүлэн үүссэн тохиолдолд хэрхэн мэдээлж, цусны алба ямар арга хэмжээ авах зэрэг асуудлууд хамаарна.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 82/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээг тодорхойлохын тулд төв дараах зүйлийг авч үзнэ. Үүнд:

- a) Хууль тогтоомж, туушаалаар зохицуулсан шаардлага
- b) Бүтээгдэхүүн үйлчилгээнд хамаарах боломжит тааламжгүй болзошгүй тааламжгүй үр дагаврууд – тухайлбал үйлчлүүлэгч нойтон шалан дээр хальтирч унах эрсдэл үүнээс сэргийлж сэрэмжлүүлэх тэмдэглэл тавьж хэвших
- c) Бүтээгдэхүүн, үйлчилгээний мөн чанар, хэрэглээ, ашиглалтын хугацаа – тухайлбал бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа
- d) Хэрэглэгчийн шаардлага
- e) Хэрэглэгчийн санал хүсэлт

Нийлүүлэлтийн дараах үйлчилгээнд баталгааны нөхцөлийн агуух арга хэмжээ, засвар үйлчилгээ гэх мэт гэрээний нэмэлт үүрэг, дахин ашиглах эсвэл устгал хийх зэрэг нэмэлт үйлчилгээ тус тус багтаж болно.

ЦЦБ олгохдоо технологич эмч, сувилагч нар тээвэрлэлт, эмнэлэг дэх хадгалалт, өвчтөнд сэлбэлт хийх үед анхаарах зөвлөмжийг амаар, дүрс бичлэг, зөвлөмж, гарын авлага хэлбэрээр өгнө.

Мөн ЦЦБ нийлүүлэх гэрээнд тээвэрлэлт, хадгалалт, сэлбэх үед ЦЦБ- тэй зөв харьцах, зөв ажиллагаа, хийгдэх хяналт, үнэлгээний талаар тусгаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

ЭМ-ийн сайдын 2020 оны 373 тоот болон 2017 оны 03 тоот тушаалаар батлагдсан заавар журмыг мөрдөж ажиллана.

8.5.6 Өөрчлөлтийн хяналт

ЦССҮТ үйлдвэрлэл явуулах буюу үйлчилгээ үзүүлэх явц дахь өөрчлөлтүүд нь шаардлагад нийцсээр байгааг бататгах хяналт, дүн шинжилгээг хэрэгжүүлнэ.

Төвийн үйл явц, ажиллагаанд ямар нэг өөрчлөлт хийх шаардлагатай үед төвийн алба, тасгийн эмч, мэргэжилтэн ажиллагсад санал, үндэслэл гарган холбогдох эмч, мэргэжилтэнд танилцуулна. Санал, хүлээж авсан эмч, ажилтан үндэслэлийг шалган, үндсэн болон бусад дэмжих үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг судлан туршилт, давхар хяналт хийж баримтжуулна. Өөрчлөлт, давхар хяналтын нотолгоо үр дүнгийн хамт тасгийн эрхлэгч, албаны даргад танилцуулна.

Тасгийн эрхлэгч, албаны дарга хамт олноор хэлэлцүүлэн хяналт, нотолгооны үр дүнд тулгуурлан үйл явц, бусад үйл ажиллагааны нөлөөллийг судлан өөрчлөлтийг зөвшөөрч, холбогдох баримт бичгүүдэд /журам, САЗ, ТТАЗ, АЗ, ХХ, маягт/ нэмэлт өөрчлөлт хийн шинэчлэн чанарын албнд төслийг хүргүүлнэ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 83/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч, холбогдох мэргэжилтний нотолгоо, үр дүнгийн судлагаа, зөвшөөрлийн дагуу чанарын албаны дарга хянаж зөвшөөрөл олгоно.

Төвийн ерөнхий захирал дээрхи зөвшөөрөл, хяналтын дүнг үндэслэн баталгаажуулалт хийн гарын үсэг зурж, тамгалснаар үйл ажиллагаанд хэрэгжих эцсийн хяналт, баталгаажилт хүчин төгөлдөр болно.

Төв эдгээр өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээний үр дүн, өөрчлөлт хийх эрх бүхий албаны дарга, тасгийн эрхлэгч, чанарын албаны ажилтны мэдээлэл, дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээнүүдийн талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

8.6 Бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргаж, бэлтгэх

ЦССҮТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шаардлага хангаж байгааг шалгах төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг холбогдох үе шатанд хэрэгжүүлнэ.

Цус цуглуулахаас эхлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах тээвэрлэх, эмнэлэгт олгох зэрэг бүх үйл явцын үе шат бүрийн ХЭЦ-ийг хянаж, үр дүнг баримтжуулан давхар шалгалт хийсэн байна.

Төлөвлөсөн арга хэмжээ хангалттай хэрэгжиж дуусах, холбогдох эрх бүхий байгууллагаас болон ашиглаж болохыг хэрэглэгч зөвшөөрөх хүртэл бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид гаргаж, нийлүүлэхгүй байна.

ЦССҮТ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж, нийлүүлэхтэй холбоотой баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Баримтжуулсан мэдээлэлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- а) Хүлээн авах шалгуурыг хангаж байгаа тухай нотолгоо – шат дамжлага бүрийн хяналт, баталгаажуулалт хийгдсэн байна.
- б) Бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах эрх мэдэл бүхий ажилтны тодорхойлолт зэргийг тусгасан байна. Үйлдвэрлэсэн ЦЦБ-ийг эмчилгээнд олгох зөвшөөрлийг Технологийн тасгийн эрхлэгч, технологич эмч нар, үйлдвэрлэлийн явцын хяналт, баримт нотолгоо, НЛ-ийн тасгийн халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох болон чанарын хяналтын шинжилгээний үр дүнд үндэслэн олгож баримтжуулна. Технологийн тасгийн бүтээгдэхүүний нөөц хариуцсан тойролт дээр ажиллаж байгаа технологич сувилагч ЦЦБ-ийг хорионоос чөлөөлж, эмнэлэгт олгох бүтээгдэхүүний ялган ангилалт, давхар хяналт, бүх баримтжуулалт бүрдүүлэлтийг хянаж, нотолгоо бүрдүүлж ажиллана.

8.7 Үл тохирол бүхий гаралтын хяналт

8.7.1 ЦССҮТ нь шаардлагад тохирохгүй байгаа гаралтыг санамсаргүй байдлаар хэрэглэх, хэрэглэгчид хүргэхээс сэргийлж, тэмдэглэгээ хийж хянана.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 84/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

Төв үл тохирлын мөн чанар болон түүний бүтээгдэхүүн, үйлчилгээнд үзүүлэх үр нөлөөнд тохирох арга хэмжээ авна. Үүнийг бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлсний дараа, үйлчилгээ үзүүлж байх үед, эсвэл үзүүлсний дараа, үл тохирох байдлыг олж тогтоосон үед мөн хэрэгжүүлнэ.

ЦССҮТ-ийн бүх ажилчид шат дамжлагын хяналт хийн шаардлага хангасан үед дараагийн үе шатанд шилжүүлж, баримтжуулалт хөтөлнө.

Зөвшөөрөх хязгаараас хэтэрсэн тохиолдолд асуудал шийдэгдтэл хорионд хадгалж, таних тусгаарлах тэмдэглэл хийнэ. Хэн шалгасан гэдгийг эмч, мэргэжилтний дахин давтагдахгүй дугаараар тогтооно. Тасгийн эрхлэгч нар дахин давтагдахгүй дугаарыг олгож, баримтжуулан чанарын албанд мэдээлнэ. Чанарын алба төвийн үндсэн үйл ажиллагааны бүх тасгийн ажилчдын дугаар, бүртгэлийг хадгална. Ажилтан солигдох, шинэ ажилтан орох үед шинэчлэн баталгаажуулна.

Төв үл тохирол бүхий гаралтыг авч үзэхдээ дараах арга замуудын аль нэг эсвэл хэд хэдийг ашиглана.

- a) Залруулга
- b) Тусгаарлах, битүүмжлэх, буцаах буюу бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийг зогсоох
- c) Хэрэглэгчид мэдээлэх
- d) Тохиролцсоны үндсэн дээр хүлээн авахыг зөвшөөрүүлэх /Хүлээн зөвшөөрөх хязгаарт байгаа үед, хариу гараагүй үед олгох онцгой тохиолдолд/

Үл тохирол бүхий гаралтыг залруулсны дараа тохирлыг нотолно.

8.7.2 ЦССҮТ дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a) Үл тохирлын тухай тайлбар
- b) Авсан арга хэмжээний тухай тайлбар
- c) Тохиролцсон тухай тайлбар
- d) Үл тохирлын талаар шийдвэр гаргах эрх мэдэл бүхий этгээдийг тодорхойлох

Төв үл тохирлын үед авах хэмжээний журам боловсруулж мөрдөнө. Техник ажиллагаа, тоног төхөөрөмж, бичиг хэргийн, дүгнэлт буруу гаргах зэрэг үл тохирол байж болно. Үл тохирлыг хэрхэн илрүүлэх, хэнд мэдээлэх, хэрхэн засах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар журамд тусгасан байна.

9. Гүйцэтгэлийн үнэлгээ

9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ

9.1.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ нь ЦЦБ үйлдвэрлэн эмнэлгийн байгууллагад нийлүүлэх үндсэн болон дэмжих үйл ажилагаатай холбоотой дараах зүйлсийг 7 хоног бүр шуурхай зөвлөгөөн дээр мэдээлэл сонсож, хэлэлцэнэ. Үүнд:

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 85/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- а) Цусны донорын сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд хамт олонтой хамтран хийсэн үр дүн, үүнээс цус цуглуулах үйл ажиллагаанд хамрагдсан байдал,
Цус, сийвэн эс, цуглуулсан удаа, хэмжээ, цуглуулалтын үеийн хаягдал, ТТ тасагт хүлээлгэн өгсөн цус, сийвэн, эсийн хэмжээ, НЛ-ийн тасагт хүлээлгэн өгсөн шинжилгээний тоо
Шинжилгээнд хүлээн авсан сорьцын тоо, чанар, шинжилсэн шинжилгээний нэр төрөл, үр дүн халдварын эерэг хувь, давтан шинжлэсэн удаа, орон нутгаас ирүүлсэн сорьцын тоо, хариу баталгаажилт, ЦЦБ–ний дээжинд хийсэн чанарын хяналтын шинжлгээний төрөл, үр дүн Шинжлгээний дотод болог гадаад үнэлгээний үр дүн
Үйлдвэрлэсэн ЦЦБ төрөл хэмжээ, захиралга , олголт нөөцийн мэдээ бүтээгдэхүүн, бүлэг тус бүрээр алсын тээвэрлэлт, онцгой болон их хэмжээний захилга, олголт
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, үйлчилгээ, засвар, цахим сүлжээний ажиллагаа, цахилгааны хэвийн ажиллагаа, авсан арга хэмжээ
Урт богино хугацааны сургалт, хамрагдсан хүн, хүний нөөцийн шилжих хөдөлгөөн гадаад хамтын аижллагааны гол мэдээ
СТСБ, ЧМ, ХЭМАБ-ын тогтолцооны талаар хийсэн гол үйл ажиллагаа, анхаарах асуудлыг товч мэдээлэл сонсож ажиллана
- б) 7 хоногийн шуурхай дээр дээрх үйл ажиллагааны гол мэдээ, товч үр дүн, мэдээллийг сар, улирлаар үйл ажиллагааны болон тоон төлөвлөгөөний дэлгэрэнгүй тайланг сонсож ерөнхий захирал шийдвэр гаргаж ажиллана.
- в) Дээрхи үйл ажиллагаанд алба, тасаг нэгжийн удирдлага тогтмол хяналт тавьж үр дүнг үнэлж ажиллана. Шаардлагатай үед төвийн захиралд мэдэгдэж холбогдох шийдвэр гаргуулан арга хэмжээ авч ажиллана. Мониторинг, хэмжилтийг гүйцэтгэх хугацааг үйл ажиллагаатай холбоотой
- д) Жилийн эцэст төвийн алба, тасаг, эмч, мэргэжилтэн бүрийн ажлын гүйцэтгэл, тайланг сонсож, үнэлж дүгнэж ажиллана.

ЦССҮТ чанарын удирдлагын болон ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг үнэлнэ. Төв үнэлгээний үр дүнд холбогдох баримтжуулсан мэдээллийг нотолгоо болгон хөтөлж, хадгална.

ЦССҮТ төвийн эмч, мэргэжилтэн, ажиллагсдын ур чадвар, үйл ажиллагаанд хэрэглэж байгаа арга, аргачлал, тоног төхөөрөмжийн ажиллагаанд мониторинг, хяналт, хэмжилт, үнэлгээ хийж, баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Төвийн алба, тасгууд үйл ажиллагааны гол тоо баримтуудыг өдөр бүр цуглуулж, 7 хоног, сар, улирл, хагас бүтэн жилээр нэгтгэн үнэлж ажиллана. Үндсэн үйл ажиллагааны гол тоо мэдээний тайланг архивт өгч хадгалуулна.

9.1.2 Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 86/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ЦССҮТ нь хэрэглэгчийн хэрэгцээ ба найдлага хэр хэмжээнд хангагдаж байгаа тухай тэдний ойлголтын талаар хянан магадална. Төв нь дээрх мэдээллийг олж авах, мониторинг, дүн шинжилгээ хийх аргыг өөрийн үйл ажиллагааны өвөрмөц онцлогт тохируулан тодорхойлно.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлт, хэрэглэгчидтэй хийх уулзалт, зах зээл маркетингийн судалгаа сэтгэгдэл, баталгааны шаардлага, бүтээгдэхүүн олголтын тайлан орно.

Төвийн алба, тасаг бүр үйлчүүлэгч, хэрэглэгч, хамтран харилцан холбоотой ажилладаг байгууллага, тасаг, иргэдээс сар бүр тодорхой тооны санал хүсэлтийг олон арга хэлбэрээр авч, нэгтгэн дүгнэж, санал хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, үр дүнг тооцон алба, тасаг, хамт олонд ил тод мэдээлж ажиллана.

Төвийн ёс зүйн хороо эмч, мэргэжилтнүүдээс ЭМ-ийн сайдын тушаалд заасны дагуу санал хүсэлтийг авч, үнэлэн үр дүнг төвийн удирдлагад танилцуулан санал хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, үр дүнг хамт олонд мэдээлж ажиллана.

Сэтгэл ханамжийг үнэлэхэд бэрхшээлтэй. Хүн бүр адилгүй, өөр өнцгөөс харж өөр өөр үнэлгээгээр үнэлдэг учир ирсэн санал хүсэлт бүрийг хамт олноор хэлэлцэн үйл ажиллагааг сайжруулах өнцгөөс харж шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй.

9.1.3 Шинжилгээ ба үнэлгээ

ЦССҮТ нь мониторинг, хэмжилтийн үр дүнгээс гарах холбогдох өгөгдөл ба мэдээллийг шинжилж, үнэлнэ. Шинжилгээний үр дүнг дараах үнэлгээнд ашиглана. Үүнд:

- a) ЦЦБүтээгдэхүүн, тусламж, үйлчилгээний стандартын болон холбогдох шаардлагад нийцсэн тохирлын байдал
- b) Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинийн өөрчлөлт
- c) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл ба үр нөлөөг сайжруулах боломж
- d) Үйл ажиллагааг тасалдалгүй хэвийн зохион байгуулах, ЧМТийг хөгжүүлэх төлөвлөлтийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулалт
- e) Эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөөтэй байдал
- f) Гадны нийлүүлэгчийн гүйцэтгэл - хүүдий, оношлуурын нийлүүлэлт, үнэлгээ, баталгаажуулалт, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, баталгаажуулалт
- g) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоог сайжруулах хэрэгцээг тодорхойлох зэрэг болно.

Төв үндсэн болон дэмжих үйл ажиллагааны гол үзүүлэлт бүрийн тоо мэдээ баримтыг сар бүр цуглуулан нэгтгэн дүн шинжилгээ, статистик боловсруулалт

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 87/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

хийнэ. ЧМТ, ХЭМАБ-ын тогтолцооны баримтжуулалт хэр хэрэгжиж үр дүнгээ өгч байгаа, төлөвлөгдсөн үйл ажиллагаа хэрхэн чанартай цаг хугацаандаа хэрэгжиж байгаа, цаашид сайжруулах ямар гарц, арга зам байгааг дүгнэн хэлэлцэж төвийн захирал шаардлагатай өөрчлөлт хийх шийдвэр гаргаж ажиллана.

9.2 Дотоод аудит

9.2.1 ЦССҮТ нь чанарын менежмент, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны талаар дараах мэдээллийг авахын тулд дотоод аудитыг төлөвлөсөн хугацаанд хийнэ.

а) Доорх шаардлагад тохирч байгаа тухай:

1. Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны байгууллагын өөрийн шаардлага
2. Олон улсын энэхүү стандартын шаардлага

б) Үр нөлөөтэй хэрэгжиж, хэвийн ажиллаж байгаа тухай

Төв өөрийн үйл ажиллагаанд хийгдэх дотоод аудитын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, аудитын баг томилж, аудитын маягтын дагуу үнэлгээг хийнэ.

9.2.2 Байгууллага нь:

- а) Холбогдох үйл явцуудын ач холбогдол, байгууллагад нөлөөлж буй өөрчлөлтүүд, өмнөх аудитын үр дүнд үндэслэн аудитын давтамж, аргачлал, хариуцлага, төлөвлөх шаардлага, тайлагнал зэргийг тусгасан аудитын хөтөлбөрийг төлөвлөж бий болгох ба хэрэгжүүлж, мөрдөж, хадгална.
- б) Аудит тус бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтооно
- с) Аудитын үйл явц нь бодитой, шударга байхуйцаар аудиторыг сонгож, аудитыг явуулна.
- д) Аудитын үр дүнг холбогдох удирдлагад мэдээлнэ
- е) Зохих залруулга болон залруулах арга хэмжээг хойшлуулалгүй авна
- ф) Аудитын хөтөлбөр хэрэгжсэн тухай болон аудитын үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Хавсралт 19. ЦССҮТ-ийн жилийн аудитын хөтөлбөр

Аудитыг ISO 9001:2015, 45001:2016 стандартын бүх шалгуурын дагуу жилд 1-ээс доошгүй удаа хийнэ. Жилийн турш бүх алба, тасагт стандартын бүлэг бүрээр хэрэгжилтийг үнэлсэн байна.

Аудитыг хийх төлөвлөгөө, маягыг боловсруулан төвийн захирлаар батлуулна. Аудит хийх эмч, мэргэжилтнүүдийг сургана. Хөндлөнгийн тасгийн хүмүүсээр хийлгэнэ. Аудитын үр дүн, зөвлөмжийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг хамтран боловсруулна. Зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянаж үзнэ

Хавсралт 20. 2021 онд хийсэн аудитын тайлан, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 88/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

9.3 Удирдлагын дүн шинжилгээ

9.3.1 Ерөнхий зүйл

Төвийн Ерөнхий захирал төвийн чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоо байгууллагын алсын хараа эрхэм зорилго, стратегийн чиг хандлагад тохирсон, нийцсэн, үр нөлөөтэй, байнга хэрэглэх байдалд нь дүн шинжилгээг жилийн эцэст 1 удаа хийнэ. Удирдлагын зөвлөлөөр юуг хэрхэн яаж сайжруулах талаар хэлэлцэнэ.

Удирдлагын дүн шинжилгээ хийх журмыг мөрдөж ажиллана.

9.3.2 Удирдлагын дүн шинжилгээний оролтууд

Удирдлагын дүн шинжилгээг төлөвлөсөн байх ба дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- a) Өмнөх удирдлагын дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээний тухай Анх удаа хийж байгаа бол энэ асуудал хамаарахгүй.
- b) Чанарын менежментийн тогтолцоонд хамаарах гадаад, дотоод асуудлуудад гарсан өөрчлөлтүүд
- c) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны болон ЭМ-ийн лабораторийн чанар ба чадахид тавигдах шаардлага стандартын гүйцэтгэл ба үр нөлөөний мэдээлэлд дараах чиглэлийг хамааруулна. /Үйл ажиллагааны статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ/ Үүнд:
 1. Холбогдох сонирхогч талуудаас ирсэн санал, хүсэлт болон хэрэглэгчийн сэтгэл ханамж
 2. Чанарын зорилтууд биелсэн байдал, хэр хэмжээ
 3. Үйл явцын гүйцэтгэл ба бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдал
 4. Үл тохирлууд ба залруулах арга хэмжээнүүд
 5. Байнгын хяналт, мониторинг, хэмжилтийн үр дүн
 6. Аудитын үр дүнгүүд
 7. Гадны нийлүүлэгчдийн гүйцэтгэлийг харуулсан чанарын менежментийн тогтолцооны хандлагыг харуулсан гүйцэтгэлийн үр нөлөөний тухай мэдээлэл
- d) Нөөцийн хангалттай байдал
- e) Эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөө
- f) Сайжруулах боломжууд

9.3.3 Удирдлагын дүн шинжилгээний гаралтууд

Удирдлагын дүн шинжилгээний гаралтад дараах асуудал бүхий удирдлагын зөвлөлийн шийдвэрүүд болон арга хэмжээ хамаарна. Үүнд:

- a) Сайжруулах боломжууд

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 89/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- b) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээ
- c) Нөөцийн хэрэгцээ / санхүү, хүний нөөц, бусад/

Төв удирдлагын дүн шинжилгээг нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр нь төвийн алба, тасгуудын дараа жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж гүйцэтгэл нь дараагийн удирдлагын дүн шинжилгээгээр хэлэлцэгдэж байна.

Хавсралт 21. 2020 оны удирдлагын дүн шинжилгээний шийдвэр .

10. Сайжруулалт

10.1 Ерөнхий зүйл

ЦССҮТ сайжруулах боломжуудыг тодорхойлох болон сонгох ба хэрэглэгчийн шаардлагыг хангах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:

- a) Шаардлагыг хангах ирээдүйн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхээр бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах,
- b) Тааламжгүй үр дүнг залруулах, сэргийлэх буюу бууруулах,
- c) Чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг сайжруулах

Сайжруулалтад залруулга, залруулах арга хэмжээ, байнгын сайжруулалт, огцом өөрчлөлтүүд, шинэчлэл болон дахин зохион байгуулалт хамаарна.

Хавсралт 22. Төвийн үйлчүүлэгчийн болон эмч, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан /улирал, бүтэн жилээр/

10.2 Үл тохирол ба залруулах арга хэмжээ

10.2.1 Хэрэглэгчийн гомдол, саналыг оролцуулан үл тохирол, тохиолдол, аюул, эрсдэл илрэх үед ЦССҮТ нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) Үл тохирол, эрсдэл, тохиолдлын эсрэг доорх арга хэмжээний аль тохирохыг авна:
 - 1. Хянаж, залруулах арга хэмжээ авах,
 - 2. Үр дагаврыг арилгах
- b) Мөн:
 - 1. Үл тохирол, тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийх, шинжлэх
 - 2. Үл тохирол, тохиолдол, эрсдлийн шалтгааныг тодорхойлох,
 - 3. Ижил төстэй үл тохирлууд байгаа, эсвэл тохиолдож болохыг тодорхойлох замаар үл тохирол хаа нэгтэй илрэх, дахин илрэхээс сэргийлэх зорилгоор түүний шалтгааныг арилгах арга хэмжээний хэрэгцээг үнэлэх,

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 90/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

- с) Шаардлагатай аливаа арга хэмжээг авах,
- д) Аливаа залруулах арга хэмжээний үр нөлөөнд дүн шинжилгээ хийх,
- е) Шаардлагатай гэж үзвэл, төлөвлөлтийн явцад тодорхойлсон эрсдэл, боломжуудыг шинэчлэх,
- ф) Шаардлагатай гэж үзвэл, чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцоонд өөрчлөлт оруулах.

Залруулах арга хэмжээ нь илэрсэн үл тохирол, тохиолдол, эрдлийн үр дагаварт тохирсон байна.

Үл тохирол, тохиолдол, эрдлийг илрүүлэх, бүртгэх, шалтгааныг тодорхойлж, засч сэргийлэх журмыг мөрдөж ажиллана.

Төвийн алба, тасаг бүр, эмч, мэргэжилтэн ажилтан бүр үйл ажиллагааны явцад илэрсэн үл тохирол, тохиолдол, эрсдлийг илрүүлэх, бүртгэх, холбогдох эмч, эрхлэгч, удирдлагад мэдээлэх, шалтгааныг тодорхойлох, засч, сэргийлэх ажилд оролцох үүрэг хариуцлага хүлээнэ.

Алба, тасгийн эрхлэгч үйл ажиллагаанд тохиолдол, эрсдэл, үл тохирол үүсгэхгүй байх зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, удирдлагын дэмжлэг авах, тохиолдол, эрсдэл, үл тохирол илэрсэн үед зөв шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх удирдлагад мэдээлэх, засч, сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, үүрэг хариуцлага хүлээнэ.

10.2.2 ЦССҮТ нь баримтжуулсан мэдээллийг:

- а) Тохиолдол, эрсдэл, үл тохирлын мөн чанар, түүний дагуу авсан арга хэмжээнүүд,
- б) Аливаа залруулах арга хэмжээний үр дүнг нотлох зорилгоор хөтөлж, хадгална.

10.3 Байнгын сайжруулалт

ЦССҮТ нь чанарын менежмент, ХЭМАБ-ын тогтолцооны зохимж, тохиромж, үр нөлөөг үргэлж сайжруулна.

Төв нь байнгын сайжруулалтын хэсэг гэж авч үзэх хэрэгцээ болон боломжуудыг тодорхойлохын тулд дүн шинжилгээ, үнэлгээний үр дүн ба удирдлагын дүн шинжилгээний гаралтыг судална.

Төвийн алба, тасгууд үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийсэн ажлуудыг бүртгэн баримтжуулж, сайн туршлага, ололт, амжилтын сан үүсгэн бусдад сурталчилж, түгээн дэлгэрүүлнэ.

Хавсралт 23. ЦССҮТ-ийн 2020 оны гол үйл ажиллагаа, шинэлэг зүйлс

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12-.2021.06.11.	Хуудас 91/ 92

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

ТӨГСӨВ.

Баримт бичгийн № ББ-ДУ -1-04-06		Чанарын гарын авлага		
Хэвлэлт №05	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.17/25	Өөрчлөлт № 5	Өөрчлөлт оруулсан огноо:2021.04.12- .2021.06.11.	Хуудас 92/ 92